


# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

*Бүх шатны Засаг дарга,  
Хамтарсан багийн гишүүдэд зориулав*



**Улаанбаатар хот  
2010 он**

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ  
ТЭМЦЭХЭД ХАМТАРСАН БАГААР  
АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ**

*Бүх шатны Засаг дарга,  
Хамтарсан багийн гишүүдэд зориулав*

Улаанбаатар  
2010

Монголын эмэгтэйчүүдийн сангаас нийтлэв.

Зохиогч: Л.Бадамцэцэг  
Хянан тохиолдуулсан: Д.Энхжаргал

**Монголын эмэгтэйчүүдийн сан**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 44-р байр 4 тоот

Шуудангийн хаяг: Улаанбаатар 46А,ш/х -280

Утас/факс: 976-11-317904

И-мэйл хаяг: [mones@mongol.net](mailto:mones@mongol.net)

Веб хуудас: [www.mones.org.mn](http://www.mones.org.mn)

**Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, 40-р байр 3,6 тоот

Шуудангийн хаяг: Улаанбаатар 46

Утас/факс: 976- 70119949

И-мэйл хаяг: [mongolcav@mongol.net](mailto:mongolcav@mongol.net)

Веб хуудас: [www.safefuture.mn](http://www.safefuture.mn)

**Хүүхдийн эрх хамгаалал төв**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг

"Билиг" дээд сургуулийн байр 208 тоот

Утас: 976-11-312178

И-мэйл хаяг: [childnetcpn@yahoo.com](mailto:childnetcpn@yahoo.com)

Энэхүү номыг Филиа сангийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

## ГАРЧИГ

Өмнөх үг ..... 6

### **Бүлэг 1. Гэр бүлийн хүчирхийлэл ба Хамтарсан баг**

Гэр бүлийн харилцаа ба гэр бүлийн хүчирхийлэл ..... 10

Хамтарсан багаар ажиллах үзэл баримтлал ..... 15

Хамтарсан багаар ажиллах эрх зүйн үндэслэл ..... 19

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төр ба

төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа ..... 24

### **Бүлэг 2. Хамтарсан багийн бүтэц, бүрэлдэхүүн, үүрэг хариуцлага**

Хамтарсан багийн бүтэц, бүрэлдэхүүн, гишүүдийн үүрэг хариуцлага ..... 29

Хамтарсан багаар ажиллах зарчим ..... 34

### **Бүлэг 3. Хамтарсан багаар үзүүлэх үйлчилгээ**

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ ... 38

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд чиглэсэн

хамгаалах үйлчилгээ ..... 39

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг нөхөн сэргээх үйлчилгээ... 40

Олон нийтийн дэмжлэгийг авах, идэвхжүүлэх үйл ажиллагаа . 41

### **Бүлэг 4. Хамтарсан багийн үйл ажиллагааг хөгжүүлэх нь**

Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт ..... 43

Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөлт ..... 49

Хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагааны

үр дүнг нэмэгдүүлэх боломжууд ..... 51

### **Бүлэг 5. Хамтарсан багаар үйлчилгээ үзүүлж**

**байгаа сайн туршлагууд** ..... 55

Улаанбаатар хотын хороодод Хамтарсан багийн

байгуулж, ажиллуулж байгаа туршлага ..... 57

Завхан аймагт Хамтарсан багаар ажиллаж байгаа туршлага .. 61

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад Хамтарсан

багаар ажиллах туршлага ..... 63

Хэнтий аймгийн Хэрлэн сумын хүүхэд хамгааллын

Хамтарсан баг ..... 64

## ГАРЧИГ

Өмнөх үг .....	6
<b>Бүлэг 1. Гэр бүлийн хүчирхийлэл ба Хамтарсан баг</b>	
Гэр бүлийн харилцаа ба гэр бүлийн хүчирхийлэл .....	10
Хамтарсан багаар ажиллах үзэл баримтлал .....	15
Хамтарсан багаар ажиллах эрх зүйн үндэслэл .....	19
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төр ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа .....	24
<b>Бүлэг 2. Хамтарсан багийн бүтэц, бүрэлдэхүүн, үүрэг хариуцлага</b>	
Хамтарсан багийн бүтэц, бүрэлдэхүүн, гишүүдийн үүрэг хариуцлага .....	29
Хамтарсан багаар ажиллах зарчим .....	34
<b>Бүлэг 3. Хамтарсан багаар үзүүлэх үйлчилгээ</b>	
Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ ...	38
Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд чиглэсэн хамгаалах үйлчилгээ .....	39
Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг нөхөн сэргээх үйлчилгээ..	40
Олон нийтийн дэмжлэгийг авах, идэвхжүүлэх үйл ажиллагаа .	41
<b>Бүлэг 4. Хамтарсан багийн үйл ажиллагааг хөгжүүлэх нь</b>	
Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт .....	43
Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөлт .....	49
Хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх боломжууд .....	51
<b>Бүлэг 5. Хамтарсан багаар үйлчилгээ үзүүлж байгаа сайн туршлагууд .....</b>	<b>55</b>
Улаанбаатар хотын хороодод Хамтарсан багийн байгуулж, ажиллуулж байгаа туршлага .....	57
Завхан аймагт Хамтарсан багаар ажиллаж байгаа туршлага ..	61
Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад Хамтарсан багаар ажиллах туршлага .....	63
Хэнтий аймгийн Хэрлэн сумын хүүхэд хамгааллын Хамтарсан баг .....	64

Говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний төвийн дэргэдэх Хамтарсан багаар ажиллаж, шийдвэрлэсэн хэрэг .....	65
<b>Хавсралт 1.</b> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 .....	70
<b>Хавсралт 2.</b> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг тайлбарласан Улсын Дээд шүүхийн тайлбар .....	81
<b>Хавсралт 3.</b> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Үндэсний хөтөлбөр 2007 он. ....	84
<b>Хавсралт 4.</b> "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Хуульзүй дотоод хэргийн сайдын хамтарсан 128/188 тоот тушаал /2009. 09. 21/-аар батлагдсан багц заавар .....	104
❖ Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлыг тодорхойлох үнэлгээг хийх заавар .....	106
❖ Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлыг тодорхойлох үнэлгээний маягт .....	109
❖ Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлж, эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах загвар .	122
❖ Хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээний маягт .....	127
❖ Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн бүртгэлийн маягт .....	128
<b>Хавсралт 5.</b> Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах тухай Эрүүл мэндийн сайд, Хуульзүй дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 308/189/129 тоот хамтарсан тушаал 2009 он. ....	130
<b>Хавсралт 6.</b> Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр .....	135
(Хуульзүй дотоод хэргийн сайд болон Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд батлагдсан)	
<b>Хавсралт 7.</b> Хамтарсан багийн судалгааны маягт, загварууд.	143
<b>Хавсралт 8.</b> Гэрээний загвар аргачлал, хувийн хэргийн мяггтын загвар батлах тухай ХХҮГ-ын даргын тушаал 2010 оны 02 сарын 08 –ны өдрийн 25-р тушаал .....	148
❖ Гэрээгээр гүйцэтгэх үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийн тоо, хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал	
<b>Ашигласан номын жагсаалт.</b> .....	154

### **Товчилсон үгсийн тайлбар**

БСШУЯ- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

ГБХ – Гэр бүлийн хүчирхийлэл

ГБХТХ - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

ГБХТҮХ- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр

ДЗ - Дэлхийн Зөн

ЗДТГ – Засаг даргын тамгын газар

МУИС- Монгол Улсын Их Сургууль

НЗДТГ – Нийслэлийн Засаг даргын тамгын газар

НҮБ - Нэгдсэн үндэстний байгууллага

НХХ – Нийгмийн хөгжлийн хэлтэс

НХХЯ - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

СӨХ – Сууц өмчлөгчдийн холбоо

ТББ – Төрийн бус байгууллага

ХЗДХЯ - Хууль зүй, дотоод хэргийн яам

ХТХ – Хүүхдийн төлөө хэлтэс

ХЭҮТ - Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

ИБХИС – Их Британий Хүүхдийг ивээх сан

ОНТХХХТ –Олон нийтэд түшиглэсэн хүүхдийн хөгжил хамгааллын төв

## ӨМНӨХ ҮГ

Дэлхий нийтэд хүний эрхийн ноцтой зөрчил хэмээн хүлээн зөвшөөрөгддөг гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол улсад ч нийгмийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Монгол улсын хууль /2004/ батлагдсанаас хойш зургаан жил болж байна. Тус хууль хэрэгжсэнээс хойш бодлогын түвшинд чамлахааргүй өөрчлөлт гарсан ч хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалт хангалтгүй байна. Энэ нь тус хуулийг хэрэгжүүлэх механизм тодорхойгүй, хуулиар үүрэг хүлээсэн байгууллагууд, мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны уялдаа, салбар хоорондын зохицуулалт сул байгаатай холбоотой.

Гэр бүл нь нэг талаас нийгмийг бүрдүүлэгч дэд систем төдийгүй социологийн үүднээс үзвэл, хүн амын тодорхой бүлгүүдийн нэгдэл юм. Үүнээс шалтгаалан гэр бүлд олон талт харилцаа үүсэхийн зэрэгцээ үзэл бодлын ялгаа, асуудлыг шийдвэрлэх хандлагаас шалтгаалсан зөрчлүүд бий болж, энэ нь заримдаа гэр бүлийн гишүүдийн хэн нэгнийх нь үндсэн эрх, эрх чөлөөнд харшилж, тэр ч байтугай амь нас, эрүүл мэндэд нь ноцтой аюул занал учруулах хэмжээнд хүртэл хурцаддаг учир төрийн зүгээс хөндлөнгийн оролцоог зайлшгүй шаарддаг. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн шууд үйлчилгээ үзүүлэх практик туршлагуудаас үзэхэд аль нэг салбар, байгууллага дангаараа уг асуудлыг хариуцах боломжгүй, төрийн нэгдсэн бодлого, холбогдох төрийн ба төрийн бус байгууллагуудын /ТББ/ хамтын ажиллагаа, уялдаа холбоо зайлшгүй хэрэгцээтэй нь нотлогдож байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах салбар дундын зохицуулалтын арга, хэлбэрийг турших зорилгоор Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв/ХЭҮТ/-ийн Хүүхэд хамгааллын нэгжийн санаачилгаар Их Британий Хүүхдийг Ивээх Сан /ИБХИС/-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2003 онд Улаанбаатар хотын Хан Уул дүүргийн 8-р хороо, Дорнод аймгийн Хэрлэн сумын 4, 7-р багууд дээр хамтарсан баг байгуулагдаж эхэлсэн. Хамтарсан багууд засаг захиргааны хамгийн анхан шатны нэгж болох хороо, баг дээр байгуулагдаж, нийгмийн ажилтан, цагдаагийн хэсгийн байцаагч, өрхийн эмч нар өөрсдийн ажил, мэргэжлийн дагуу гэр

бүлийн хүчирхийллийн хохирогч болсон иргэдэд сэтгэл зүй, хууль, эрүүл мэндийн ганцаарчилсан зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлэхээс гадна үйлчлүүлэгчид тулгарсан бэрхшээлийг шийдэхийн тулд багаар хамтран ажиллаж эхэлсэн нь ажлын шинэ, сонирхолтой хэлбэр болж байлаа. Багийн гишүүд салбарынхаа хүрээнд хуримтлуулсан мэдлэг, чадвар, туршлагаа харамгүй хуваалцан, бие биедээ урам зориг, эрч хүч нэмэрлэж, үр дүнд хүрч, хамтын ажиллагаандаа сэтгэл хангалуун байгаа нь 2005 онд хийгдсэн төслийн үнэлгээнд<sup>1</sup> дурдагдаж байсныг санаж байна. Эдгээр туршилтын төслүүд нь тухайн үедээ гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон олон нийтийн хүсэл сонирхол, хэрэгцээнд нийцэж, засаг захиргааны анхан шатны нэгж дээр төрийг төлөөлөн ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд итгэх итгэл нэмэгдэхэд нөлөөлсөн юм.

Үүний дараа тодорхой аймаг, дүүргүүдийг сонгож, Хамтарсан багийн ач холбогдлыг ойлгуулан таниулах, баг байгуулах, багийн гишүүдийг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, орон нутгийн шийдвэр гаргах түвшнийхэнд нөлөөлөх зэрэг олон ажлыг ХЭҮТ, ИБХИС тэргүүлэн, бусад санхүүжүүлэгч олон улсын байгууллага, үндэсний төрийн бус байгууллагууд дэмжин ажиллаж ирсэн билээ.

2007 онд Монгол Улсын Засгийн Газрын 225 тоот тогтоолоор батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"/ГБХТҮХ/-т Хамтарсан багийг үндэсний хэмжээнд дэмжин дэлгэрүүлэх, гишүүдийг нь мэргэшүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах, хохирогчид чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг Хамтарсан багаар үзүүлэх зэрэг асуудлыг тусгасан нь чухал алхам болсон.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд нарын хамтарсан тушаалаар 2009 онд батлагдсан "Нийгмийн ажилтны талаар авах зарим арга хэмжээний тухай" баримт бичигт сум, хороо, боловсролын нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд хамтарсан багт гүйцэтгэх үүргийг тодорхой тусгаж өгсөн.

Хэдийгээр төр засгаас батлагдаж буй бодлогын баримт бичгүүдэд ийнхүү Хамтарсан багийг дэмжсэн шийдвэр гарч, боломж нэмэгдэж байгаа ч төрийн захиргааны анхан, дунд

---

<sup>1</sup>"Хамтарсан багаар ажилласан туршлага" төслийн дотоодын үнэлгээний материалаас ХЭҮТ, ИБХИС 2005 он. Энэ судалгаа хэвлэгдээгүй бөгөөд зохиогч өөрийн тэмдэглэл дээр үндэслэв.

шатанд болон мэргэжлийн салбаруудын хувьд жинхэнэ утгаараа тогтолцоо болон хөгжиж чадаагүй байна. Учир нь Хамтарсан багийг одоогоор ямар байгууллага удирдан чиглүүлэх, мэргэжил арга зүйгээр хэн хангах, багт тодорхой үүрэг хүлээх анхан, дунд шатны албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтод гүйцэтгэх үүргийг нь боловсруулж, мөрдүүлэх, ажлын үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох зэрэг асуудлууд тодорхойгүй байна. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх хуулийн болон нийгмийн бодлогын хэлтсүүд, Нийслэлийн хүүхэд, залуучуудын газар, ХЭҮТ, Хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төв хамтран НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хамтарсан багийн хувьд тодорхойгүй байгаа дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг туршин шийдвэрлэхээр хамтран ажиллаж байгааг дурдахад таатай байна.

Миний бие нь 2000 оноос гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлын мөн чанарыг судалж, хариу үйлдэл үзүүлэх үйлчилгээг гардан хийж, анхны Хамтарсан багийг байгуулалцахаас эхлээд өнөөг хүртэл ажилласан өөрийн мэдлэг, хуримтлуулсан туршлага, мөн хамтран ажиллагсдынхаа нөр их хичээл зүтгэл, аймаг, нийслэл орон нутгуудад ажиллаж буй мэргэжилтнүүдийн санаа бодол, ажлын туршлага дээр үндэслэн, дээрх асуултын хариу болгож, энэхүү гарын авлагыг бичсэн юм.

Гарын авлага нь харъяа нутаг дэвсгэрийн хүн амд төрийн үйлчилгээг хүргэж байгаа, Хамтарсан багийн гишүүд болох бүх шатны засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаагийн болон эмнэлгийн байгууллагын ажилтнууд, бусад албан тушаалтнууд, энэ асуудлаар ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнууд, судлаач, сонирхогч хувь хүмүүст зориулан гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг судалж, үр дүнтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

Энэхүү гарын авлагад хамтран ажиллах талаар эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн онол, арга зүй, эрх зүйн зохицуулалтыг аль болох өргөнөөр тусгахыг хичээсэн бөгөөд эдгээрт үндэслэн Хамтарсан багийн бүтэц, хэлбэрийг тодорхойлж, өнөөгийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх боломжит хувилбаруудыг дэвшүүлсэн болно. Хамтарсан багаар ажиллахад удирдан зохион байгуулах,

багаар хамтран ажиллах, мэдээллээ хуваалцах ур чадвар чухал бөгөөд энэ талаар хэрхэн чадавхиа бэхжүүлэх асуудлыг ч хөндсөн. Мөн Хамтарсан багт хэрэглэх баримт бичгийн загварыг НХХЯ-аас баталсан хувилбараар, хүчирхийллийг илрүүлэх, тандалт явуулах судалгааны асуулгуудыг загьар байдлаар боловсруулж оруулсныг Хамтарсан багийн гишүүд ажилдаа өргөнөөр хэрэглэнэ гэдэгт итгэж байна.

Энэхүү гарын авлагыг боловсруулж, хэвлүүлж, олны хүртээл болгоход санхүүгийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн Канад сан, Монголын эмэгтэйчүүдийн санд гүн талархлаа илэрхийлье.

*Л.Бадамцэцэг  
Сэтгэл судлалын магистр*

**ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭХ НЬ ЭХЛЭЛ  
ХАМТДАА ХЭЛЭЛЦЭХ НЬ АХИЦ  
ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ АМЖИЛТ**

## БҮЛЭГ 1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ХАМТАРСАН БАГ

### ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА БА ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүл нь эхнэр нөхрийн харилцаанд суурилсан, сэтгэл зүй, ёс суртахуун, эдийн засаг, эрх зүй зэрэг нийгмийн олон төрлийн харилцааг өөртөө багтаасан, хоорондоо хамааралтай ураг төрлийн хүмүүс нэг гэрт амьдарч, харьцангуй тогтвортой харилцаанд орж байдгаараа онцлогтой өвөрмөц тогтолцоо бөгөөд дотоод тэнцвэрээ хадгалахыг байнга эрмэлздэг. Гэр бүл бат бэх оршин тогтноход гишүүд хоорондын зохистой харилцаа маш чухал байдаг.

*Зохистой харилцаатай гэр бүл:*

- **Харилцан бие биеэ хүндэтгэх:** Аливаа асуудалд хандахдаа нэн тэргүүнд ойлголцохыг, нэгийгээ дэмжихийг урьдал болгож, буруутган шүүмжлэхээс зайлсхийдэг.
- **Шударга хариуцлагатай байх:** Өөрийн хийсэн үйлдэл, алдааг айж эмээлгүй хэлэх, буулт хийх, зөвшилцөхөөс гадна хариуцлага хүлээж чаддаг.
- **Итгэлцэх:** Биеэ биенийхээ амьдралын зорилго, сэтгэл хөдлөл, найз нөхөд, ажил үйлсийг хүндэтгэн дэмждэг.
- **Халамжийн үүргийг хамтдаа хүлээх:** Үр хүүхдүүддээ сайнаар үлгэрлэхийг эрмэлзэх, эцэг эх байх үүрэг хариуцлагаа тэгш хүлээх, ахмад буурлууддаа хүндэтгэлтэй ханддаг.
- **Үүрэг хариуцлагаа тэнцвэржүүлэх:** Гэр бүлийн асуудлаа хамтдаа шийдвэрлэн, үүрэг хариуцлагаа шударгаар хуваарилдаг.
- **Эдийн засгийн хамтын дэмжлэгээ ухамсарлах:** Харилцан бие биедээ итгэлтэйгээр санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран зүтгэж, мөнгө, санхүүгийн асуудлаа хамтран шийдвэрлэж чаддаг.

Харин зохист харилцаа алдагдсан гэр бүлд хэн нэг нь эрх мэдэл, давуу талаа ашиглан, бусад гишүүддээ хяналт тогтоох

замаар тэгш бус харилцаа бий болгодог. Үүнийг гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцаа гэдэг.

Гэр бүлийн харилцаан дахь дарамт хүчирхийлэл нь хүний өөрийн үнэлэмжийг бууруулж, энэ бүхний шалтгааныг гаднаас хайн, эцэст нь амьдралынх нь хэвийн үзэгдэл болтлоо дасан зохицсон байдаг. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчтэй харьцахдаа хэт болгоомжлох, аргадах, уучлал гуйх зэргээр тухайн нөхцөл байдалд аль л тохиромжтой аргыг хэрэглэдэг. Энэ байдал нь хөндлөнгийн нүдээр харахад хохирогч өөрөө буруутай, хүчирхийллийг өөгшүүлж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх талтай ч тэрээр өөрийгөө хамгаалахаар хэрэглэж буй арга юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн хүрээнд хэн нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор хяналтаа тогтоон, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус харилцаа юм.<sup>2</sup>

*Хүчирхийллийн харилцаатай гэр бүл нь:*

- **Харилцан хүндэтгэл, итгэлцэл үгүй болох:** Хоорондын харилцаа нь айж түгшсэн, үл итгэсэн, эсхүл эзэрхүү шүүмжлэгчийн байр сууринаас хандах, албадлага хэрэглэх
- **Сэтгэл санааны дарамтанд оруулах:** Хүсэл эрмэлзэл, амьдралын зорилгыг үгүйсгэж мохоох, ойр дотны хүмүүсээс нь хөндийрүүлэх, мөрдөн мөшгих, нэр төрийг гутаах, буруутгах, айлган сүрдүүлэх, хуурч мэхлэх, итгэл эвдэх
- **Хүчирхийлэл үйлдэгч өөрийн давуу байдал болон хохирогчийн сул тал, эмзэг байдлыг ашиглаж, хүслээ гүйцэлдүүлэх:** Хүч хэрэглэх, үл хайхрах, үл сонсох, доог тохуу болгох, наад захын хэрэгцээгээр нь гачигдуулах, хүүхдийг өшөө хорслын зорилгоор ашиглах, барьцаалах гэх мэт
- **Эдийн засгийн дарамт, хавчлага үзүүлэх:** Ажил, орлого олох боломжоос хөндийрүүлэх, эсхүл цалин, орлогыг хураан авах, эд хөрөнгө, мөнгөний эрх мэдэлгүй байлгах гэх мэт

<sup>2</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги, ХЭҮТ, 2005 он

Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй хэмээн хүний жам ёсны эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглалд бататган, хэнийг ч зовоон тарчилгах, харгис хэрцгий, хүний ёсноос гадуур харьцах, эрүү шүүлт тулгах, шийтгэхийг хориглосон байдаг. Гэвч хүний суурь эрхийн зөрчил, ноцтой гэмт хэрэг болсон гэр бүлийн хүчирхийлэл сүүлийн жилүүдэд улам өсч, цар хүрээгээ тэлж, оновчтой зохицуулалт, шийдлийг шаардсан нийгмийн тулгамдсан асуудлын нэг болоод байгааг дараах тоо баримтууд нотолж байна. Үүнд:

- НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос 2009 онд хийсэн "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа"-нд оролцсон 9106 хүний 73.6% нь хүчирхийллийн ямар нэг харилцаатай гэр бүлийг мэдэхээ илэрхийлжээ. Уг судалгаанд хамрагдсан 6894 эмэгтэйн 19 хувь буюу 5 эмэгтэй тутмын 1 нь нөхөр, хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. 1998 оноос хойш гэр бүлийн хүчирхийллийн бие махбодын хэлбэрийн тархац хоёр дахин нэмэгдсэн байна.<sup>3</sup>
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртөн, амь нас, эрүүл мэндэд нь ноцтой аюул занал учирсан үедээ Хамгаалах байранд хандан байрлагсдын тоо жил тутам өсөж байна.<sup>4</sup> 2008 онд хамгаалах байраар үйлчлүүлсэн нийт 487 үйлчлүүлэгчдийн 63.8 % нь хүүхэд байна. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн цаана 2-3 хүүхдийн аюулгүй байдал давхар алдагдаж байдгийг харуулж байна.
- 2008 оны эхний 11 сар; 2009 оны 3-8 сар хүртэлх нийт 17 сарын хугацаанд 2392 үйлчлүүлэгч утсаар зөвлөгөө авсан байна.<sup>5</sup>

<sup>3</sup>1998 онд МУИС-ийн Хүн ам, сургалт сурталчилгааны төв, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв хамтран явуулсан 21 аймгийн 5000 хүнийг хамруулсан судалгааны дүнгээр "10 эмэгтэй тутмын нэг нь зодуулдаг" гэсэн байна.

<sup>4</sup>Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн 5 хамгаалах байрны 2009 оны эхний 3 улирлыг багтаасан статистик мэдээ

<sup>5</sup>Гэр бүлийн дотны зөвлөх" итгэлтэй утасны статистик мэдээ, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хороо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, 2009 он

- 2006 онд Нийслэлийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаас Захиргааны хариуцлагын хуулийн дагуу 2415 хүн баривчлагдаж байсан бол 2008 онд 3419 болж 2 жилийн хугацаанд 1000 тохиолдлоор өсчээ.<sup>6</sup>
- 2008 оны 5 сараас 2009 оны 9 сар хүртэлх хугацаанд улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 515 гэмт хэрэг бүртгэгджээ. Нийт хохирогчдын 68.3% нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн нь хүндэвтэр, хүнд гэмтэл авсан үедээ л хуулийн байгууллагад хандаж байгааг илтгэж байна.<sup>7</sup>
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст 1 сарын хугацаанд 812 хүн эрүүлжүүлэгдсэний 49.7% нь согтуугаар гэр бүлдээ дарамт учруулж, агсам тавьсан үндэслэлээр албадан эрүүлжүүлэгдсэн байна.<sup>8</sup>
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлээд 5 орчим жил болоход хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэр 41 гарчээ.<sup>9</sup>

Гэр бүлийн хүчирхийлэл нь гишүүдийн тэгш бус харилцааны үр дагавар болон гарч ирдэг бөгөөд гэр бүлийн тогтолцоонд үүсдэг хямралын нэг юм. Үүнд:

- Гэр бүлийн гишүүд, төрөл, садангийн хүмүүс, урьд нь гэр бүлийн харилцаатай байсан, гэрлэсэн буюу хэзээ нэгэн цагт хамт амьдарч байсан эсэхийг үл харгалзан хүүхэд нэгтэй хүмүүсийн дунд болон хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлж байгаа, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны үр дүнд харилцаатай болсон хүмүүс болон гэр, аж ахуйг хамтран эзэмшиж байгаа хүмүүсийн дунд үйлдэгддэг.
- Хүний хувийн амьдрал, хувийн нууцтай холбоотой эмзэг

<sup>6</sup>Албадан саатуулах, баривчлах байрны 2006 оны болон Нийслэлийн цагдаагийн газрын 2008 оны статистик судалгаанаас

<sup>7</sup>Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн мэдээ, Цагдаагийн Ерөнхий Газар, 2009

<sup>8</sup>Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх байрны 2009 оны 8 сарын 20-ноос 9 сарын 20-ны статистик мэдээ

<sup>9</sup>ХЗҮТ-ийн үйлчилгээний бүртгэлээс 2009

асуудал учраас далд үйлдэгдэж, давтагдан даамжирч байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн хандлага болон хувь хүний ухамсар, хүмүүжилтэй шууд хамааралтай. Гэвч гэр бүлийн хүчирхийллийн шалтгааныг архи, ядуурал гэх мэт нийгмийн хүчин зүйлтэй хутгаж эндүү ташаа ойлгохоос гадна тухайн гэр бүлийн дотоод асуудал, сахилга батжуулах нэг арга зэргээр зөвтгөл хайх, хүлээн зөвшөөрөх хэвшмэл хандлага манай нийгэмд тодорхой хэмжээнд оршсоор байна. Аюулгүй амьдрах эрх нь зөрчигдөж буй хохирогч ч өөрийг нь хуулийн хүрээнд хамгаалах эрхзүйн боломжууд, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдийн талаар мэдээлэл бага байгаагаас шалтгаалан хүчирхийллийг даван туулахдаа цаг алдаж, хүнд гэмтэл учрах, амь насаа алдах зэрэг ноцтой аюул занал тулгарсан үед л албан ёсны дэмжлэг хайж байна.

Гэр бүлийн нэг гишүүний аюулгүй байдал алдагдахад бусад гишүүдийн эрх ашиг дагаад хөндөгддөг. Гэр бүл нь нийгмийг бүрдүүлэгч дэд системийн хувьд гэр бүл доторхи хямрал нь нийгмийн бусад асуудалд зайлшгүй нөлөөлдөг. Хүчирхийллийн улмаас гэр бүлд хувь хүний аюулгүй байдал алдагдаж, эрүүл мэнд, амь насаараа хохирох, эдийн засгийн хямрал үүсэх, хүүхдийн хүмүүжил, зан байдалд сөрөг өөрчлөлт орж, сургууль завсардах, гэмт хэрэгт холбогдох, гэр бүл цуцлах, хувь хүний хөдөлмөрийн бүтээмж буурах, улмаар ажилгүйчүүдийн эгнээнд шилжих, ядуурал, архидалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг дагуулдаг.

Хүчирхийллийн давтамж, даамжирлын үр дагавраас болоод хохирогч хүчирхийллийг эсэргүүцэх хүч нь суларч, жилээс жилд, аажим аажмаар өөрийн орон зайгаа алдсаар байдаг. Энэ үед хохирогчид хүчирхийллийг зогсоох, даван туулахын тулд өөр өөрийн арга замаар зохицуулж байна гэж боддог ч ихэнх тохиолдолд хүчирхийллийн эргүүлэгт орсон байдаг. Тэд гарах гарцыг хайдаг боловч дахин давтан зодуулах болон дарамтлуулах бүртээ энэхүү нөхцөл байдлыг өөрчлөх найдлага нь улам багасдаг байна. Энэ тохиолдолд төрийн хөндлөнгийн оролцоо зайлшгүй шаардлагатай болдог ба хохирогч эрүүл мэндээрээ ноцтой гэмтэх, амь насаа алдах, амиа хорлох эрсдэл өндөр болж ирдэг учраас чухам энэ үед л төрийн зүгээс хөндлөнгөөс зайлшгүй оролцох шаардлага гарч ирнэ.<sup>10</sup>

<sup>10</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги, ХЭҮТ, 2005 он

Гэхдээ энэ нь олон жил, байнга давтагддаг хүчирхийллийн тохиолдлууд дээр л орж ажиллана гэсэн үг биш. Хүчирхийллийг аль болох эрт шатанд нь илрүүлж, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхэд төрийн хөндлөнгийн оролцоо бас хэрэгтэй. Ер нь хохирогч албан ёсны туслалцаа хүсч хандаж байна гэдэг нь ихэнх тохиолдолд тухайн хохирогчийн хувьд эцсийн найдвар байдаг учраас анхан шатны үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагын ажилтнууд хөндлөнгөөс оролцохдоо мэдрэмжтэй, аюулгүй байдлыг нь бодолцож ажиллах шаардлагатай. Хүчирхийлэлтэй харилцааг хөндлөнгөөс оролцож таслан зогсооход хохирогчийн эрх, хэрэгцээнээс шалтгаалан засаг захиргаа, хууль хяналт, нийгмийн халамж, хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, иргэний нийгмийн байгууллагуудын олон талт цогц оролцоо шаардагддаг. Иймээс хуулиар үүрэг хүлээсэн төрийн албан хаагчид нь асуудалд өөр өөрсдийн ойлголт, үзэл хандлагын үүднээс үзэмжээрээ хандах бус нэг зорилго, нэгдсэн үзэл баримтлалтайгаар, нэгдмэл зохион байгуулалтанд орж, хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай.

## **ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Анх 1950-иад онд АНУ-ын Питтсбург, Лос-Анжелос, Денвер зэрэг хотуудад хүүхэдтэй зүй бус харьцах явдлыг илрүүлэх, эмчилгээ үзүүлэх зорилгоор Хамтарсан багийн үйл ажиллагааг эмнэлэг дээр байгуулан ажиллаж эхэлсэн. Энэ хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн Хамтарсан багууд орон нутгийн хүүхэд хамгааллын үйлчилгээний гол хэсэг болон ажиллаж эхэлжээ. Өнөөдөр барууны орнуудад төдийгүй Азийн олон оронд эмнэлэгт суурилсан болон олон нийтэд түшиглэсэн багууд ажиллаж байна<sup>11</sup>.

Хамтарсан багийн хөгжлийг тодорхойлоход эрдэмтэн, судлаачдын гаргасан онолын үндэслэл маш хэрэгтэй. Хамтарсан багийн зорилго, үзэл баримтлал, ажиллах чиглэл, арга зүйн талаар сүүлийн үеийн эрдэмтэн судлаачид олон санал дэвшүүлсэн байдаг. Үүнд:

---

<sup>11</sup>"Хүүхэд хамгааллын үйлчилгээ" А.Батхишиг нар Save the children 2009 он 65-р хуудас

- Америкийн эрдэмтэн Эллис /2000/: "Хамтарсан баг нь хүчирхийллийн талаар ирсэн мэдээлэлд үр дүнтэй хариу арга хэмжээ авахын тулд хамтарсан зохицуулалтын аргаар ажиллах мэргэжилтнүүдийн бүлэг юм" гэжээ.
- Белл /2001/ : "Хамтарсан багийн зорилго нь хүчирхийлэлд өртөгсдөд эрх зүйн, нийгмийн болон эмнэлгийн үйлчилгээнд туслалцаа авах зэрэг олон талт хэрэгцээг өргөн хүрээнд хангах үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ" гэж тодорхойлжээ.
- А.Батхишиг /2008/: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчид үйлчилгээг үзүүлэхийн тулд ажил үүргийнхээ дагуу өөр өөр мэргэжлийн хүмүүс нэг баг бүрдүүлж, асуудлыг олон талаас нь тандан судалж, хариу арга хэмжээ авах үйл явц Хамтарсан багийн үйл ажиллагаа юм. Нэртэйгээ адилаар энэ багийн бүрэлдэхүүнд төр, нийгмийн үйлчилгээний салбарын холбогдох мэргэжилтнүүд багтах бөгөөд гишүүн тус бүр тухайн гэр бүлд шаардлагатай нэг үйлчилгээг төлөөлнө<sup>12</sup> хэмээн үзсэн байна.
- С.Энхтуяа, Д.Олончимэг /2009/ нар: Хамтарсан баг гэж хороо, баг, сум дээр ажилладаг Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмч, сургуулийн нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч зэрэг албан тушаалтан мэргэжилтнүүд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, шуурхай таслан зогсоох, нэгэнт өртсөн хүмүүст эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд хэвийн нөхцөл байдалд эргэн ороход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нэгдэн ажиллах хамтын ажиллагааг хэлнэ<sup>13</sup>.
- Стиил: Хамтарсан багийн тодорхойлолт ямарч байлаагэсэнгэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа бэлгийн хүчирхийллийг тандахад нэг байгууллагын зохицуулалтгүй явцуу аргаас хэд хэдэн байгууллагын мэргэжилтнүүдээс бүрдсэн зохицуулалттай Хамтарсан багийн үйл ажиллагаа ямагт илүү үр дүнтэй байдаг хэмээн дүгнэсэн байдаг.

Дээрхи тодорхойлолтуудыг үндэслэн "Гэр бүл, олон нийтэд үйлчлэх үүрэг бүхий орон нутгийн анхан, дунд шатны төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагад ажиллаж буй мэргэжилтнүүд шат, шатандаа хийх гэр бүл рүү чиглэсэн ажил

<sup>12</sup>А.Батхишиг "Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь" ХЭҮТ, АНУ-ын Азийн сан 2008 он 147-р хуудас

<sup>13</sup>Хороо, сум, багийн түвшинд хүүхэд хамгааллын үйлчилгээг олон нийтэд түшиглэн хамтарсан багаар үзүүлэх нь. С.Энхтуяа, Д.Олончимэг, Save the children. 2009

үйлчилгээгээ нэгтгэж, нэг цэгийн үйлчилгээний зарчмаар хамтран ажиллах зохион байгуулалтын хэлбэрийг Хамтарсан баг хэмээн нэрлэнэ” гэж тодорхойлж болно.

Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг янз бүрээр бүрдүүлж, зохион байгуулдаг талаар олон улсын туршлагауд байдаг. Үүнийг судлаач Каминер дөрвөн үндсэн бүлгээр ангилсан байна<sup>14</sup>:

1. **Эмчилгээний баг:** Гэр бүлийн болон хүүхдийн эмчилгээ, оношилгооны асуудлаар хамтран ажилладаг эмчилгээ заслын баг юм. Хийх үйл ажиллагаа нь хүчирхийллийн харилцаатай гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх, эмчилгээ үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах, үйлчилгээнд зохицуулалт хийх, үйлчилгээг үнэлэх зэрэг болно. Энэ багийн зохион байгуулалт дээр нь дурдсан эмнэлэг дээр суурилсан нэг цэгийн үйлчилгээний загвартай төстэй.
2. **Зөвлөлдөх баг:** Тодорхой тохиолдол/хэрэг дээр санал бодлоо солилцох, зөвлөлдөх шинжээчдийн мэргэжлийн баг юм. Тохиолдол/хэрэг дээр ярилцах, анализ хийх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйлчлүүлэгчид шийдвэр гаргахад нь туслах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Ийм төрлийн үйлчилгээг Хэнтий, Өвөрхангай, Дорнод зэрэг аймгуудад “Хүүхэд хамгааллын хамтарсан баг”-аар үзүүлж байна.
3. **Хөрөнгө, нөөцийг дайчлах баг :** Хүчирхийлэл дарамтыг даван туулахад нь дэмжих, мэргэжлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх байгууллагууд болон олон нийтийн төлөөллөөс бүрдсэн баг. Тэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд болон хүний эрхийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-ууд, санхүүжүүлэгчидтэй холбогдон хохирогчийн хэрэгцээг хангахын тулд одоо байгаа боломжит нөөцийг дайчлах төдийгүй тогтвортой санхүүгийн эх үүсвэр бий болгоход нөлөөлөх зэрэгт анхаарч ажилладаг.
4. **Холимог баг :** Нэгдсэн зохицуулалтаар олон төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээг нэг эсхүл хоёр буюу түүнээс дээш багаар хамтран гүйцэтгэх бүлэг юм. Үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах зорилготой зохион байгуулдаг.

<sup>14</sup>А.Батхшиг нар “Хүүхэд хамгааллын үйлчилгээ” Save the children 2009 он 66-р хуудас

Хамтарсан багийн бүрэлдэхүүнд:

Америкийн судлаач Колбо ба Строн нар:

1. Хүүхэд хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагын ажилтнууд, шүүх, цагдаагийн байгууллагын ажилтнууд
2. Эрүүл мэнд, боловсрол, засан хүмүүжүүлэх байгууллагын ажилтнууд
3. Сэтгэлзүйч, сэтгэцийн эмгэг судлаач, шүүхээс томилогдсон өмгөөлөгч оролцож болох тухай санааг дэвшүүлсэн байдаг.

Манай орны хувьд Хамтарсан багийн цөм бүрэлдэхүүнд:

1. Тухайн хохирогчийн оршин суудаг баг, хорооны Засаг дарга
2. Баг, хорооны нийгмийн ажилтан
3. Хэсгийн байцаагч буюу цагдаагийн ажилтан
4. Өрхийн эмч
5. Хэрвээ хүүхэд уг хэрэгт гэрч, хохирогчоор оролцсон бол хамран сургах тойргийн сургуулийн нийгмийн ажилтан нар орж байна.

Хамтарсан багийн бүрэлдэхүүн нь тухайн тохиолдол/хэргийн онцлогоос шалтгаалан янз бүр байж болно. Тухайлбал: халамжийн нийгмийн ажилтан, өмгөөлөгч, холбогдох үйлчилгээг үзүүлж буй ТББ-ын ажилтан зэрэг мэргэжилтнүүд Хамтарсан багийн бүрэлдэхүүнд багтаж болно.

Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын тулд төрийн нэрийн өмнөөс хөндлөнгөөс хохирогчийн аюулгүй байдлыг анхаарлынхаа төвөөс салгалгүй, мэдрэмжтэй, үр дүнтэйгээр оролцож, хохирогч болон гэр бүлийн бусад гишүүн тус бүрийн эрсдлийн түвшинг өөрсдийн мэргэжил, үүрэг хариуцлагын үүднээс үнэн зөв тодорхойлж, хамтдаа системчилсэн үнэлгээ хийж, хүрээлэн буй нийгмийн орчны нөлөө, гэр бүл, хувь хүний онцлог, давуу талд тулгуурлан, тэдний оролцоотойгоор асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд Хамтарсан багийг байгуулан ажиллаж байна.

## ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

### 1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2004/

Хамтарсан багийн гол чиглэлээ болгох эрхзүйн үндэслэл нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Монгол улсын хууль юм. /хуулийг хавсралт 1-ээс үзнэ үү/ Энэ хуулийг тайлбарласан Улсын Дээд шүүхийн тайлбар бас эрхзүйн гол үндэслэлийн нэг болно. /тайлбарыг хавсралт 2-оос үзнэ үү/ Тус хуулинд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага, албан тушаалтнуудын бүрэн эрх болон хариуцлагыг тодорхой зааж өгсөн.<sup>15</sup> Тухайлбал:

- Харъяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсвөөс тусгайлан төсөвлөж санхүүжүүлэх;
- Хууль хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих;
- Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх /Тайлбар: Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль гэх мэт/;

Дээрх заалтыг үндэслэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар /ГБХТХ/ үүрэг хүлээсэн хороо, багийн засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаагийн хэсгийн байцаагч, өрхийн эмч, боловсролын нийгмийн ажилтан, олон нийтийн байцаагч нарын бүрэлдэхүүнтэйгээр "Хамтарсан баг" байгуулан ажиллуулах тухай Нийслэлийн болон зарим аймгуудын Засаг даргын захирамжууд гарч, тодорхой хороо, багт хэрэгжин, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад үр дүнгээ өгч байна.

<sup>15</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 8 дугаар зүйл, 2004 он

Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд гол үүрэг гүйцэтгэх цагдаагийн байгууллагын ажилтан, сум, багийн Засаг дарга, нийгмийн ажилтны тус хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг Та бүхэнд дэлгэрэнгүй танилцуулья.

Сум, багийн Засаг дарга засаг захиргааны анхан шатны нэгж дээр гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаар:

- Хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны байранд дуудан ирүүлж, шаардлага тавих;
- Шаардлагатай гэж үзвэл хохирогчийн байгаа гэр, орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, эсхүл боломжтой бол хохирогчийг төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтанд өгөх;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах үүргийг хүлээсэн.<sup>16</sup>

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох талаар дараах үүргийг хүлээхээр тодорхойлсон<sup>17</sup>. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авч, бүртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж, хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах;
- Хохирогчид эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчид эрхийг нь хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар тайлбарлаж өгөх;
- Хүчирхийлэл үйлдэгчид захиргааны болон эрүүгийн шийтгэл ноогдуулж болох тухай сануулах;
- Шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл садангийн хүний нь түр хамгаалалтанд өгөх;

<sup>16</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 14 дүгээр зүйл, 2004 он

<sup>17</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 9 дүгээр зүйл, 2004 он

- Шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах;
- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх;
- Хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрхзүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь түр хямарсан үед эмчилгээ хийх, нөхөн сэргээх хамруулах талаар нийгмийн ажилтанд мэдэгдэх;
- Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах;
- Хууль тогтоомжид заасан бусад үүрэг багтана. /Тайлбар: Иргэдийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийнхээ хүрээнд хүлээсэн үүргүүд/

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх нийгмийн ажилтан нь:

- Тухайн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг цагдаагийн ажилтантай хамтран тогтоох /багц зааврыг Хавсралт 4-аас дэлгэрүүлэн үзнэ үү/
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг 2009 онд Хуульзүй дотоод хэргийн сайд болон Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр"-ийн дагуу цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах /хөтөлбөрийг Хавсралт 5-өөс дэлгэрүүлэн үзнэ үү/
- Хохирогчид үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын аргазүйн тусалцаатайгаар явуулах
- Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх тайлан, мэдээ гаргаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийн сүлжээ бий болгоход оролцох үүрэгтэй<sup>18</sup>.

<sup>18</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 10 дугаар зүйл, 2004 он

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ биелүүлж байх үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага, боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй<sup>19</sup>. Иймээс тэд тухайн тохиолдлыг болон ижил төстэй бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд Хамтарсан багийн гишүүн болж, өргөтгөсөн байдлаар ажиллах эрхзүйн үндэслэл байгааг эндээс харж болно.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.<sup>20</sup>

Хохирогчийг хамгаалах байраар хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах, хохирогчид үзүүлэх үйлчилгээ болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх бусад үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу ТББ-аар гүйцэтгүүлж болно.<sup>21</sup> ТББ нь Хамтарсан багийн бүрэлдэхүүнд орж ажиллаж болох тухай эрх зүйн үндэс бүрдсэн байгааг орон нутагт ажиллаж буй шууд болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх, бодлого тодорхойлох багууд олж харж ажиллах хэрэгтэй юм.

Энэ чиг үүргийнхээ дагуу Засгийн газрын тухай хуулийн 19 дугаар зүйлд заасны дагуу эдгээр үйл ажиллагаануудыг мэргэшсэн ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх явдал жилээс жилд нэмэгдсээр байна.

2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрөөс гаргасан бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдэд Хамтарсан багийг дэмжсэн заалтууд дараахь байдлаар орсон байна.  
Тухайлбал:

- **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөр-т /2007/:** Нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийн буюу **Хамтарсан багийн**

<sup>19</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 13 дугаар зүйл, 2004 он

<sup>20</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 11 дугаар зүйл, 2004 он

<sup>21</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 11 дүгээр зүйл, 2004 он

**хэлбэрээр хүргэх** /хөтөлбөрийг хавсралт 3-аас үзнэ үү/

- **Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр /2009/ -т:** Хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх чиглэлээр эмнэлэгт түшиглэсэн " Нэг цэгийн үйлчилгээ"-г аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт байгуулах ажлыг дэмжиж, түүний чанар хүртээмжийг сайжруулах
- **Нийгмийн ажилтны талаар авах зарим арга хэмжээний тухай** Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаал /2010/-аар сум, хороо, ерөнхий боловсролын нийгмийн ажилтны ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг баталж, эдгээр албан тушаалтнуудын Хамтарсан багт гүйцэтгэх үүргийг тодорхой тусгаж өгчээ.

Дээрх хууль, бодлогын баримт бичгүүдээс үзэхэд манай төр захиргааны нэгж дээр ажиллаж буй аймаг, нийслэл, дүүрэг, сум, хороо, багийн засаг дарга, нийгмийн ажилтан, эмч, багш, цагдаа нар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад гол үүрэг хүлээгчид юм. Харин эдгээр албан тушаалтнууд хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд хамтын хүчин чармайлт шаардлагатай байна. Яагаад гэвэл тэдний хүрч очих цэг нь нэг л айл, нэг л иргэн, нэг л үйлчлүүлэгч шүү дээ.

Өдгөө гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор орон нутгийн түвшинд Хамтарсан багаар ажиллаж, үйлчилгээ үзүүлж эхэлсэн сайн туршлагууд гарч эхэлж байна. Эдгээр Хамтарсан багийн гишүүдийн гүйцэтгэх үүргийг мэргэжилтэн бүрийн ажил байдлын тодорхойлолт болон урамшуулах, хариуцлага тооцох, ажил дүгнэх үзүүлэлтэнд суулгаж өгөх шаардлага гарч байна. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх хуулийн болон нийгмийн бодлогын хэлтсүүд, Нийслэлийн хүүхэд, залуучуудын газар, ХЭҮТ, Хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төв хамтран НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хамтарсан багийн хувьд тулгамдаад байгаа дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг туршин шийдвэрлэхээр хамтран ажиллаж байна.

Хамтарсан багаар ажиллах тухай үндсэн үүрэгт ажил гэж тодорхойлсонтой адил, Хамтарсан багийн бусад гишүүд мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг холбогдох эрх бүхий байгууллагууд анхааралдаа авах хэрэгтэй байна.

Олон улсын түвшинд Хамтарсан багийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүргийг нийгмийн ажилтнууд хүлээдэг. Манай улсад ч ялгаагүй нийгмийн ажилтнууд Хамтарсан багийн үйл ажиллагааг зангидан зохицуулж байна.

## **ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ТӨР БА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Хүүхэд хамгааллын нэгж 2003 оноос Их Британий Хүүхдийг ивээх сангийн дэмжлэгтэйгээр гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах зорилгоор ажиллах олон нийтэд түшиглэсэн Хамтарсан багийн үйл ажиллагааг анх санаачилсан. Уг загварыг Улаанбаатар хотын Хан - Уул дүүргийн 8,9-р хороо, Дорнод аймгийн Хэрлэн сумын 1,4,6,7-р багуудад амжилттай туршиж хэрэгжүүлсэн. Улмаар 2007 онд Улаанбаатар хот, Баянхонгор, Дорнод, Дархан-Уул, Өмнөговь, Завхан, Увс, Ховд, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв зэрэг аймгийн **Засаг дарга** нар тухайн орон нутгийн харъяа нутаг дэвсгэрийн сум, дүүрэг, хороо, багт тодорхой албан тушаалтнуудаас бүрдсэн Хамтарсан баг бүрдүүлж, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тухай **захирамж** гаргаж баталгаажуулсан юм. Энэ загвар үндэсний хэмжээнд амжилттай түгэн дэлгэрэхэд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монголын эмэгтэйчүүдийн сан, НҮБ-ын Хүүхдийн сан /UNICEF/, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /UNESCO/, Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн зэрэг үндэсний болон олон улсын ТББ-ууд чухал хувь нэмэр оруулсан юм.

2009 онд Эрүүл мэнд, Хууль зүй дотоод хэрэг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд нарын хамтарсан тушаалаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Хүн амын сангийн арга зүй, техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр Гэмтэл согог

судлалын үндэсний төв, Шүүх эмнэлэг, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгүүд дээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүй, эрхзүйн үйлчилгээ үзүүлэх "Нэг цэгийн үйлчилгээ"-ний төвүүд байгуулагдлаа. Эдгээр төвүүдэд хүчирхийллийн хохирогчид харъяалал харгалзахгүйгээр гэмтлийн эмч, нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтнууд багаараа үйлчилгээ үзүүлэхээс гадна, аюулгүй байдлыг шуурхай хангах үүднээс 1-3 ортой түр хамгаалах байр ажиллуулдаг болсон. /нэг цэгийн үйлчилгээ байгуулах тухай тушаалыг хавсралт 6-аас үзнэ үү/


Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр /2009/-т гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчлэх эмнэлэг дээр суурилсан нийгмийн ажлын үйлчилгээг үндэсний хэмжээнд нэмэгдүүлэх тухай төлөвлөсөн байгаа учраас харъяа нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудтай хамтран ажиллах замаар эмнэлэг дээр суурилсан нэг цэгийн үйлчилгээг бий болгох боломжтой.

Зарим аймаг, сум, хороонд байгуулагдсан Хамтарсан багуудын ажиллаж буй байдлыг судлахад удирдлагын бүтэц нь тодорхой бус, тухайн орон нутагт анх санаачилсан тэр байгууллага нь удирдан зохион байгуулж, бусад байгууллагууд идэвхигүй байр сууринаас хандаж байгаа байдал ажиглагдаж байна. Тухайлбал, зарим аймгийн Хүүхдийн төлөө хэлтсүүд Хамтарсан багаар ажиллах арга зүйд ач холбогдол өгч, хороо, баг, сумын холбогдох мэргэжилтнүүд оролцсон, зөвхөн хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх, хохирогчийг хамгаалах, шууд үйлчилгээ үзүүлэх "Хүүхэд хамгааллын хамтарсан баг" байгуулж, зохион байгуулалтыг тухайн хэлтэс хариуцан ажиллаж байгаа туршлага байна. Мөн цөөн хэдэн аймгийн хороо, баг дээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, шууд үйлчилгээ үзүүлэх Хамтарсан багийг тухайн орон нутагт ажиллаж байгаа төрийн бус байгууллага зохион байгуулж байна. Зарим аймагт Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хууль зүйн хэлтэс нь хариуцах зэрэг янз бүрийн зохион байгуулалттай ажиллаж байна. Аль аль нь одоогийн нөхцөлд боломжит хувилбар бөгөөд энэ нь орон нутгийн онцлог гэхээсээ илүүтэй хөгжлийн эхний үеүдэд биежиж, өөрийн гэсэн өвөрмөц хэлбэр төрлөө олох хүртлээ үргэлжилж буй үйл явц гэж үзэж болно. Цаашид засаг захиргааны анхан шатны нэгж дээр

Хамтарсан баг байгуулагдан ажиллах нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид өөртөө хамгийн ойр байдаг засаг захиргааны нэгжээсээ төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд, шуурхай хүртэх боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.


Гэр бүл дэх хүчирхийлэлтэй харилцааг илрүүлэх, шуурхай таслан зогсоох, хүчирхийллийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүй, эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахаас гадна хүчирхийлэл үйлдэгчид хуулийн хариуцлага хүлээлгэх, тэдний зан үйлд нөлөөлөх зэрэг олон салбарын оролцоо шаардах асуудлууд гардаг. Эдгээр асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, мэргэжилтнүүд хуулиар хүлээсэн ажил үүргийн хүрээнд уялдаа холбоотой ажиллаж, цогц сүлжээт үйлчилгээ үзүүлэн, багаар хамтран ажиллах хэрэгцээ шаардлага зайлшгүй гарч ирдэг.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид ихэвчлэн эмнэлэг, цагдаагийн байгууллагад анх ханддаг ч энэ байгууллагууд зөвхөн өөрсдийн ажил мэргэжлийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу биеийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, нөхөн сэргээх, хүчирхийлэл үйлдэгчийг архи хэрэглэсэн бол эрүүлжүүлэх, баривчлан саатуулах, эрүүгийн хэрэг үүсгэх, гэр бүл цуцлуулах хүсэлтээ шүүхэд гаргаж болох талаар мэдээлэл өгөх,



энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудад хандахыг зөвлөх зэргээр үйлчилгээ нь хязгаарлагддаг байна. Гэтэл хүчирхийллээс үүдэлтэй эд материалын хохирол учирсан, сэтгэл санааны стресс, хямралд орсон, амьдралд итгэх итгэл үнэмшлээ алдсан тохиолдолд хэрхэх вэ, хүүхдийн асуудлыг орхих уу, хүчирхийллийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг хэнд даатгах вэ зэрэг олон асуудал асуулт хэвээр үлддэг. Тэгвэл гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох хэргийн онцлогт нийцүүлэн тухай бүрд нь ямар ямар хариу үйлдэл үзүүлэх шаардлагатайг дараах зураглалаас харна уу.

Гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар ба хөндлөнгийн оролцооны зураглал<sup>22</sup>



Гэр бүлийн хүчирхийллийн бусад гэмт хэргээс ялгагдах дээрх онцлог, ноцтой үр дагаврыг олон нийтэд ойлгуулах, уг гэмт хэрэгтэй нийгмээрээ тэмцэх, нэгэнт үйлдэгдсэн хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийллийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг нөхөн сэргээх, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага ноогдуулах зэрэгт цогцоор хандах оновчтой, үр дүнтэй механизм шаардлагатай.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нь салбар дундын асуудал учир засаг захиргааны анхан болон дунд шатны нэгж аймаг, нийслэл, сум, хороо, баг дээр ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд ХЭҮТ "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги" мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагын 32,37 дахь талууд

хүргэж байгаа шат шатны Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмч, боловсролын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нар албан ёсоор үйл ажиллагаагаа нэгтгэж, "Хамтарсан баг" байгуулан, ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ нь нэг талаас хуулиар үүрэг хүлээсэн албан тушаалтнууд гэр бүлд нэг цэгээс төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүртээх, нөгөө талаас асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж нэмэгдэж



байгаагаараа ач холбогдолтой юм. Хамтарсан багаар ажиллах санаачлага Монгол улсад 2003 онд эхэлж байсан үетэй харьцуулахад өнөөдөр хамтран ажиллах эрх

зүйн орчин, арга зүй, сайн туршлага тодорхой түвшинд бүрдсэн байна.

Салбар байгууллага, мэргэжилтнүүдийн үр дүнтэй хамтын ажиллагаа нь олон талын ач холбогдолтой байдаг. Үүнд:

- Олон талын мэдлэг, ур чадвар, нөөцийг хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, шуурхай таслан зогсоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх зэрэг бүх шатанд дайчлах нь аливаа асуудлыг цогцоор нь, бүрэн шийдэх боломжийг олгодог.
- Мэдээллийг солилцох боломжийг бүрдүүлдэг тул үйлчилгээнд ямар нэгэн хийдэл, давхардал гарах нь багасна.

Асуудлыг хамтдаа хэлэлцэж шийдвэрлэдэг тул хүнд, хэцүү тохиолдол, хэрэг дээр ажиллахад мэргэжилтнүүд бие биеэ дэмжин, харилцан туслах боломжтой байдаг тул Хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх явдал сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд ихээхэн дэлгэрч, оновчтой, үр дүнтэй загвар болон хөгжиж байна

## БҮЛЭГ 2. ХАМТАРСАН БАГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

### ХАМТАРСАН БАГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ

Нийгмийн ажилтан анхан шатны Хамтарсан багийг чиглүүлнэ. Тэрээр бусад гишүүддээ үйлчлүүлэгчийн болон холбогдох бусад мэдээллийг өгч, багийн үйл ажиллагааг зохицуулна. Анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх Хамтарсан багийн бүрэлдэхүүн нь хороо, багийн гэсэн 2 өөр бүтэцтэй зохион байгуулагдаж болох бөгөөд энэ нь багт нийгмийн ажилтны орон тоо байхгүйтэй холбоотой байна. Цаашдаа бүх баг хороодод нийгмийн ажилтны орон тоог бий болгож ажиллуулах хэрэгцээ шаардлага байна.

#### **А. Сум, хорооны Хамтарсан багийн бүрэлдэхүүн:**

- Сум, хорооны нийгмийн ажилтан – Багийн ахлагч /ажлын байрны тодорхойлолтоор/
- Сум, хорооны Засаг дарга – Багийн гишүүн
- Сум, хорооны хэсгийн төлөөлөгч/байцаагч - Багийн гишүүн
- Сум, хорооны өрхийн эмч - Багийн гишүүн
- Боловсролын нийгмийн ажилтан - Багийн гишүүн
- Хэсгийн ахлагч / эсхүл СӨХ-ийн дарга / - Багийн гишүүн
- Иргэдийн төлөөлөл

#### **Б. Багийн хамтарсан баг:**

- Боловсролын нийгмийн ажилтан – Багийн ахлагч /ажлын байрны тодорхойлолтоор/
- Багийн Засаг дарга – Багийн ахлагч
- Багийн зохион байгуулагч – Багийн гишүүн
- Багийн хэсгийн байцаагч - Багийн гишүүн
- Багийн өрхийн эмч - Багийн гишүүн
- Хамран сургах тойргийн сургуулийн нийгмийн ажилтан - Багийн гишүүн
- Хэсгийн ахлагч / эсхүл СӨХ-ийн дарга / - Багийн гишүүн
- Иргэдийн төлөөлөл гэх мэт бүтэцтэйгээр ажиллаж болно.

Жич: Тухайн тохиолдол/хэрэг болон хороо, баг, сумын нийгэм-эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, хүн ам зүйн онцлогоос хамаарч, бүрэлдэхүүн болон зарим ажил үүрэг өөрчлөгдөж болно.

### **Хамтарсан багийн гишүүдийн үүрэг:**

#### **Нийгмийн ажилтан:**

- Хамтарсан багийг арга зүйн удирдлагаар хангах, багийн гишүүдтэй хамтран хүчирхийлэл дэхин давтагдахаас урьдчилан сэргийлэх, хохирогчийг болон гэр бүлийн бусад гишүүдийн эрх, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд хамтын ажиллагаа, ажил үүргийн уялдаа холбоог зохицуулах;
  - Хамтарсан багийн бичиг баримтыг хөтлөх;
  - Судалгаа хийх, нэгтгэн боловсруулах, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах;
  - Хохирогч болон гэр бүлийн гишүүдэд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх;
  - Хамтарсан багаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн бүртгэл, хэргийн файлыг хөтлөх;
  - Үйлчилгээ авсан гэр бүлд үйлчилгээний үр дүнд мониторинг хийх ажлыг хариуцах;
  - Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийг төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамруулах;
  - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн болон Хууль зүй дотоод хэргийн сайдын 2009 оны 128/188 тоот хамтарсан тушаалаар батлагдсан загвараар гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, эрсдлийн түвшинг тодорхойлох нөхцөл байдлын үнэлгээ хийх;
  - Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдэд хэрэгцээтэй байгаа бусад үйлчилгээг төлөвлөх, холбон зуучлах;
  - Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ, олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааг холбогдох ТББ болон Хамтарсан багийн оролцоотойгоор зохион байгуулах;

- Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн бусад үүрэг;

**Засаг дарга:**

- Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг захирамж гарган батлах, багийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлгээ өгөх, үүргээ биелүүлээгүй ажилтанд хариуцлага тооцох;
- Харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төсөвтөө суулгах, хөрөнгө дайчлах арга хэмжээг хариуцах;
- Хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг ТББ-ыг дэмжих, гэрээгээр хамтран ажиллах;
- Хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчид шаардлага тавих; холбогдох байгууллагуудад асуудлыг нь шийдвэрлүүлэхээр шилжүүлэх;
- Шаардлагатай гэж үзвэл хохирогчийн байгаа гэр, орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, эсхүл хохирогчийг төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, нотлох баримт бүрдүүлэх;
- Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн бусад үүрэг;

**Цагдаагийн ажилтан:**

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авч, бүртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах;
- Хохирогчид түүний эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчид эрхийг нь хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар

тайлбарлан өгөх;

- Хүчирхийлэл үйлдэгчид захиргааны болон эрүүгийн шийтгэл ногдуулж болох тухай сануулах;
- Шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх;
- Шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх;
- Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд хүчирхийлэл үйлдэгчид эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ шүүхэд гаргах;
- Хохирогчийг сэтгэлзүй, нийгмийн халамж, хамгаалал болон бусад холбогдох үйлчилгээнд хамруулах талаар нийгмийн ажилтанд мэдэгдэх;
- Хамтарсан багийн гишүүдэд хууль, эрх зүйн мэдээлэл өгөх;
- Хуулийн байгууллагад хохирогч хандах тохиолдолд өргөдөл, гомдол, хүсэлтийг ямар байгууллагад хэрхэн гаргах талаар зөвлөгөө өгөх, тайлбарлах;
- Бүртгэл мэдээллийг зохих журмын дагуу хөтөлж, харъяа цагдаагийн байгууллагад тодорхой хугацаанд тайлагнах;
- Гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд илрүүлэх, цаг алдахгүй таслан зогсоох, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх ажлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх;
- Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн бусад үүрэг;

#### **Өрхийн эмч:**

- Хамтарсан багийн гишүүдтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажил явуулах;
- Албан үүргээ биелүүлж байх үедээ буюу өвчтөнд үзлэг хийх, зөвлөгөө өгч байх, ярилцлага хийх явцдаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж

болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага, боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх;

- Хохирогчийг эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээх, эмчлэх, илааршуулах;
- Хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдэд мэргэжлийнхээ хүрээнд мэдээлэл өгөх;
- Хохирогчийг нийгмийн ажилтантай холбон зуучлах;
- Хамтарсан багаар тохиолдол/хэргийг хэлэлцэхэд оролцох;
- Бүртгэл мэдээллийг нэгтгэж, дүүргийн эрүүл мэндийн газарт тайлагнах;
- Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн бусад үүрэг;

***Боловсролын нийгмийн ажилтан:***

- Хамтарсан багийн гишүүдтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил явуулах;
- Сургуулийн сурагчдын дунд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн болзошгүй эрсдлийг тандах судалгаа явуулах;
- Эрх нь зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад хэрэгцээт мэдээлэл өгөх;
- Анхан шатны зөвлөгөө өгөх;
- Хохирогчийг хорооны нийгмийн ажилтантай холбон зуучлах;
- Бүртгэл мэдээллийг нэгтгэж, дүүргийн боловсролын асуудал хариуцсан хэлтэст тайлагнах;
- Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн бусад үүрэг;

***Хэсгийн ахлагч:***

- Хариуцсан хэсгийнхээ айл өрхийн судалгааг гаргаж нийгмийн ажилтанд тайлагнах;
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн болзошгүй эрсдлийн талаар мэдээлэл цуглуулах;
- Хамтарсан багийн гишүүдтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт,

сурталчилгааны ажил явуулах;

- Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн бусад үүрэг;

**Олон нийтийн байцаагч:**

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн болзошгүй эрсдлийн талаар мэдээлэл цуглуулах, мэдээлэх;
- Хамтарсан багийн гишүүдтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил явуулах;
- Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн бусад үүрэг;

**Олон нийтийн төлөөлөл:**

- Тохиолдол/хэрэг бүр дээр гэр бүлийг дэмжиж тусалдаг ах дүү, хамаатан садан, найз нөхөд, эсхүл ойр хөрш амьдардаг иргэдээс оролцож болно.
- Хорооны нийгмийн ажилтан тухайн хүний дэмжлэг оролцоог гэр бүлд эерэг нөлөөтэй гэж үзвэл хамтарсан багийн хуралдаанд оролцуулж болно. Энэ тохиолдолд хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор нууцлалын зарчмыг нийгмийн ажилтан түүнд танилцуулж, гарын үсэг авна.
- Аюулгүй байдлын төлөвлөгөө, кейс төлөвлөгөөг хэрхэн биелүүлж буйд хяналт тавьж, эрсдэл учирвал мэдээлэх эрхтэй.<sup>23</sup>

## **ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАХ ЗАРЧИМ**

Хамтарсан багийн гишүүд хувь хүн, гэр бүлд үзүүлэх үйлчилгээндээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Аливаа хүнтэй хувь хүнийх нь хувьд нэр төр, үнэ цэнэ, онцлог байдалд нь хүндэтгэлтэйгээр хандах;
- Хохирогчийн өөрөө өөрийгөө тодорхойлох, өөрийнхөө амьдралд хамаатай асуудлаар шийдвэр гаргах, өөрийгөө төлөөлөх жам ёсны эрхийг хангах, гаргасан

<sup>23</sup>Хороо, сум, багийн түвшинд хүүхэд хамгааллын үйлчилгээг олон нийтэд түшиглэн хамтарсан багаар үзүүлэх нь. С.Энхтуяа, Д.Олончимэг, Save the children. 2009. 30-р хуудас

шийдвэрийг нь хүндэтгэх;

- Үйлчлүүлэгчийг анхааралтай сонсох, тайтгаруулах, үл шүүмжлэх, хүлээцтэй, соёлтой хандах;
- Харилцан итгэлцэл, хүндлэлд тулгуурласан хамтын ажиллагааны түншлэлийн үзэл санаагаар үйлчлүүлэгчтэй харьцах, хохирогч төвтэй үйл ажиллагаа явуулах;
- Нэн тэргүүнд хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдалд гол анхаарлаа хандуулах;
- Бодит байдлыг ойлгох, асуудалд мэдрэмжтэй хандах /итгэх, үйлчлүүлэгчид эргэлзээ төрүүлэхгүй байх, худал ярьсан ч буруутгахгүй байх/
- Хүнийг нас, хүйс, нийгмийн гарал, хөгжлийн бэрхшээл, итгэл үнэмшил, үзэл бодол, бэлгийн чиг баримжаа, эдийн засгийн боломж болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй, тэгш хандах;
- Нууцыг чандлан хадгалах;
- Олон салбарын мэргэжилтнүүд хамтарч байгааг харгалзан цаг баримтлах, багийн өмнө хүлээсэн үүргээ мэргэжлийн түвшинд хугацаанд нь гүйцэтгэх;

Хүчирхийллийн болзошгүй эрсдэл үүссэн тохиолдолд хохирогчийн болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авахдаа Хамтарсан багийн гишүүд мэдээллийн нууцыг чандлан хадгалж, зөвхөн түүнийг мэдэх шаардлагатай гэсэн албан тушаалтнуудад л хүргэнэ.

#### **Хамтарсан багийн гишүүдийн үүрэг хариуцлага:**

Багийн гишүүд нэн тэргүүнд үйлчлүүлэгчийнхээ аюулгүй байдлыг хангах, нууцыг хадгалах үүргийг хүлээнэ. Болзошгүй эрсдлийг урьдчилан таних, нэгэнт бий болсон тохиолдолд бууруулахын төлөө шаардлагатай бүхий л зохих арга хэмжээг заавал авна.

**Хамтарсан багийн гишүүд нь дараах асуудлын талаар тодорхой мэдлэгтэй байх шаардлагатай. Үүнд:**

- Хүний насны үечлэл, онцлог, хэрэгцээний талаар ерөнхий мэдлэг
- Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл болон

хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдал, тэдгээрийн үр дагаврууд

- Хохирогчийг хамгаалах шаардлага, эмзэг, эрсдэлт байдалд оруулж буй эдийн засаг, нийгэм соёлын хүчин зүйлс
- Хүний эрх болон эрхэд суурилсан хандлага
- Хүүхдийн эрхийг хамгаалах болон гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомж
- Хохирогчийг хамгаалахад зайлшгүй оролцогч талуудын эрх мэдэл, чиг үүрэг, хариуцлага
- Кейс менежмент

### **Хамтарсан багийн гишүүдийн ур чадвар**

- Үйлчлүүлэгчид учирсан асуудлыг оновчтой тодорхойлох чадвар
- Туслалцаа үзүүлэх, боломжит аргуудыг эрэлхийлэх чадвар
- Ярилцлага хийх, зөвлөгөө өгөх чадвар
- Үйлчлүүлэгчид тулгарсан асуудлыг шийдвэрлэх чадвар
- Нотлох баримт бүрдүүлэх, баримтжуулах чадвар
- Үйлчилгээтэй холбоотой бүртгэл маягтыг үнэн зөв хөтлөх чадвар
- Холбон зуучлах арга ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах чадвар

### **Үйлчлүүлэгчидтэй харилцахад анхаарах зүйлс:**

- Үйлчлүүлэгчийн өмнө хариуцлага хүлээж, мэргэжлийн ёс зүйн шаардлагын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;
- Үйлчлүүлэгчийн итгэлийг хүндэтгэн, аюулгүй байдлаа хангуулах, хувийн нууцаа хамгаалуулах эрхийг хангаж, олж авсан мэдээллийг зөвхөн үйлчлүүлэгчийн эрх ашгийн үүднээс ашиглана. Мэдээллийг цуглуулж, ашиглах тохиолдол бүртээ үйлчлүүлэгчид урьдчилан мэдэгдэнэ. Үйлчлүүлэгч хариуцлага хүлээх чадваргүй буюу бусдад ноцтой хор аюул учруулж болзошгүйгээс бусад тохиолдолд үйлчлүүлэгчид урьдчилан мэдэгдэж, түүний зөвшөөрлийн дагуу холбогдох байгууллага хүмүүст өгч байна. Үйлчлүүлэгч нь өөртэйгээ холбогдох

аливаа мэдээллийг үзэж танилцах эрхтэй.

- Үйлчлүүлэгчийн хувийн байдал, онцлогийг хүлээн зөвшөөрч хүндэтгэнэ. Үйлчлүүлэгчид өөрөө шийдвэрээ гаргахад нь туслах бөгөөд бүх үйлчлүүлэгчид тэгш хандана. Мэргэжлийн үйлчилгээг дээрх байдлаар үзүүлж чадахгүй тохиолдолд энэ тухай үйлчлүүлэгчид мэдэгдэж, үйлчилгээ авах эсэхээ сонгох боломж олгоно.
- Үйлчлүүлэгчтэй мэргэжлийн холбоо харилцаа тогтоож, тэдний эрх, ашиг сонирхол, хүсэл эрмэлзлийг хүндэтгэж ажиллана.

#### **Байгууллагуудтай харилцахад анхаарах зүйлс:**

- Оновчтой стандарт, хохирогч төвтэй үйл ажиллагааг бий болгох үүднээс зохистой бодлого журам, үйл ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч, холбогдох байгууллагуудын зорилго чиг үүрэг, уялдаа холбоо, хамтын ажиллагааг тодорхойлж хэрэгжүүлнэ.
- Үйлчлүүлэгчийн өмнө хариуцлага хүлээж, холбогдох байгууллагуудаар дамжуулан зохих бодлого журам, практик үйл ажиллагаанд хохирогчийн эрх, ашиг сонирхолд нийцсэн өөрчлөлт оруулах санаачилга гаргана. Хүссэн үр дүнд хүрээгүй бол холбогдох дээд шатны байгууллагад хандаж асуудлыг дахин тавина.
- Үйлчилгээ үзүүлэх явцад хяналт тогтмол хийж, үр дүнг үйлчлүүлэгч, холбогдох байгууллагад тайлагнаж байна.
- Бодлого журам, практик үйл ажиллагаа нь нийгмийн ажлын ёс зүйн зарчмуудтай шууд зөрчилдөж буй тохиолдолд хохирогчийн эрх, ашиг сонирхлыг удирдлага болгон бүхий л боломжийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэнэ.

### БҮЛЭГ 3. ХАМТАРСАН БАГААР ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

#### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны хамгийн үр дүнтэй, чухал хэсэг нь урьдчилан сэргийлэх үйлчилгээ юм. Энэ үйлчилгээний талаар С.Энхтуяагийн "Хүүхэд хамгааллын үндэс" хэмээх нийгмийн ажилтнууд болон хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлагад маш тодорхой өгүүлжээ. Энэ нь зөвхөн хүүхдийн эсрэг хүчирхийлэл төдийгүй гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ашиглахад боломжтойг харгалзан тус гарын авлагаас урьдчилан сэргийлэх үйлчилгээний төрөл, түвшинг ангилсан ангиллыг Та бүхэнд танилцуулж байна.

Урьдчилан сэргийлэх үйлчилгээг 1/олон нийтэд, 2/эрсдэлт бүлэгт гэж хувааж үзнэ. Урьдчилан сэргийлэх үйлчилгээг ерөнхийдөө үндсэн 3 түвшинд явагддаг байна.<sup>24</sup> Үүнд:

- Хүчирхийлэл гарахаас нь өмнө зогсоох зорилготой, олон нийт рүү чиглэсэн анхан шатны урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд
- Хүчирхийлэл үүсэхэд нөлөөлөх магадлалтай нөхцөл байдлыг бууруулахад чиглэсэн үйлчилгээг өндөр эрсдэлтэй гэр бүлд үзүүлэх арга хэмжээнүүд
- Нэгэнт гарсан хүчирхийллийн сөрөг үр дагаврыг бууруулах, дахин гарахаас сэргийлэх зорилгоор хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарч байсан гэр бүл рүү чиглэсэн арга хэмжээнүүд


Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөвхөн тэмдэглэлт үйл явдлуудыг тохиолдуулан нэг удаа зохион байгуулах юм уу, Хамтарсан баг ажлын үр дүнгээ шалгуулж үнэлүүлэхийн тулд хийдэг ажил биш, байнгын тогтмол ажиллагаа байх нь чухал юм. Өнөөдөр ажилгүй, нийгмийн халамж хамгаалал хүссэн маш олон иргэд зөвхөн хороо, багаараа бараг өдөр тутам үйлчлүүлдэг.

<sup>24</sup>С.Энхтуяа, "Хүүхэд хамгааллын үндэс" Хүүхдийг ивээх сан, 2009 он

Иймээс тэдэнд хандсан урьдчилан сэргийлэх бүх түвшний арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах боломжтой юм.

Урьдчилан сэргийлэх аливаа арга хэмжээг ардаа заавал хамгаалах үйлчилгээ бэлэн байхаар зохион байгуулах нь зүйтэй санагддаг. Тухайлбал, өөрийн буруугаас болоод нөхөртөө дарамтлуулдаг гэж ихэнх эмэгтэйчүүд үздэг ч урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтанд суугаад гарахдаа өөрийнхөө нөхцөл байдал, гэр бүлийн харилцаандаа дүгнэлт хийж, зөвлөгөө авахыг хүсдэг. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг "сургалт – сурталчилгаа – зөвлөгөө" хэмээн төлөвлөвөл зохилтой.

**Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зорилго:**



Урьдчилан сэргийлэх үйлчилгээг аль ч шатны хамтарсан багууд хэрэгжүүлэх боломжтой.

## **ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨГСДӨД ЧИГЛЭСЭН ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох шуурхай механизмын нэг хэлбэр нь Хамтарсан багийн үйл ажиллагаа байдаг. Хэдийгээр хүчирхийлэлд шуурхай хариу үйлдэл үзүүлэх тогтолцоо төлөвшөөгүй, эхлэл төдий байгаа ч эрх зүйн хүрээнд Хамтарсан багаар дараах хамгаалах үйлчилгээг үзүүлж болно. Үүнд:

- Эмзэг хүүхэд, гэр бүлийг судалж илрүүлэх;
- Эрсдэлтэй орчин, газрын байршлыг тогтоож, эрсдлийг

- бууруулах арга хэмжээ авах;
- Мэдээллийг хүлээн авч, бүртгэх, баримтжуулах;
- Хохирогчийн болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хангах, амь нас эрүүл мэндийг хамгаалах;
- Хохирогчийн аюулгүйн төлөвлөгөөг хамтран боловсруулах;
- Сэтгэл зүй, эрхзүй, эрүүл мэндийн зөвлөгөө, нийгмийн ажлын туслалцааг цогцоор үзүүлэх;

#### Хамгаалах үйлчилгээний бүтцийн схем



Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд чиглэсэн хамгаалах үйлчилгээ нь анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх Хамтарсан багийн үндсэн үйл ажиллагаанд багтана.

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨГСДИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хамтарсан баг гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хэвийн амьдралд эргэн ороход нь ихээхэн үүрэг гүйцэтгэж чадна.

- Хүчирхийллийг даван туулахад зөв мэдээлэл өгч, чадавхижуулах;
- Сэтгэл зүй, эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээх үйлчилгээг өөрт нь хамгийн ойр байдаг газарт нь, урт хугацаагаар үзүүлэх;

- Архины хамааралтай хүчирхийлэл үйлдэгчийг хамаарлаасаа гарахад нь чиглэсэн гэгээрүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах, ажиглах, зан үйлээ өөрчлөхөд нь нөлөөлөх;
- Үйлчлүүлэгчдээ шаардлагатай нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг хүртэхэд нь дэмжлэг туслалцааг хамтарсан шийдвэрээр хурдан хугацаанд үзүүлэх гэх мэт ажлуудыг хийж чадна.

### Нөхөн сэргээх үйлчилгээний бүтцийн схем



Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг нөхөн сэргээх үйлчилгээ нь анхан шатны шууд, дунд шатны зөвлөх үйлчилгээний аль алинд тодорхой хэмжээгээр тусгагдан хэрэгжих боломжтой.

## ОЛОН НИЙТИЙН ДЭМЖЛЭГИЙГ АВАХ, ИДЭВХИЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд иргэд, байгууллагууд оролцсон олон нийтийн бүлгүүдийг үүсгэн, Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, сурталчилах, хүчирхийллийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, мэдээлэл солилцох, түгээх ажилд хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь чухал юм.

Аймаг, нийслэл, дүүрэг, сум, хороо, багийн ахмадын, эмэгтэйчүүдийн, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэх мэт оролцооны бүлгүүдийг энэ чиглэлийн үйл ажиллагаанд татан оролцуулж, ажлаа Хамтарсан багийн хэлбэрээр төлөвлөж, хэрэгжүүлнэ. Мэдээлэл хүргэх, солилцох, олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны ажилд тэдний дэмжлэг, идэвхтэй оролцоо туйлын чухал.

Энэ үйл ажиллагааг бодлого тодорхойлох, зөвлөх, шууд үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий Хамтарсан багуудын аль ч шатанд хэрэгжүүлэх боломжтой.

### Олон нийтийг идэвхижүүлэх үйл ажиллагаа



## **БҮЛЭГ 4. ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ**

### **ХАМТАРСАН БАГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хамтарсан багийн зорилго нь сум, хороо, багийн нутаг дэвсгэр дээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж, хүчирхийллийн харилцаатай гэр бүл, эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хохирогчид төрөөс үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг хүргэх явдал билээ.

Хамтарсан багийг байгуулах, ажиллах нөхцөл боломжоор хангах, үнэлэх, зөвлөх үйл ажиллагаанд нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагуудын бодлого шийдвэр чухал ач холбогдолтой.

Аймаг, нийслэл, сум дүүргийн хэмжээнд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль" болон холбогдох үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, түүний дотор Хамтарсан багийн ажиллах механизмыг тодорхой тусгаж, хуулиар үүрэг хүлээсэн албан тушаалтан мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлуудыг нарийвчлан оруулах, ажлын явц, үр дүнг үнэлэх асуудлыг цогцоор нь тусгах шаардлагатай.

Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийх ажлыг тусгаж, Засаг дарга Хамтарсан баг байгуулах шийдвэрийг захирамжаараа баталгаажуулж, анхан шатанд холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнууд багаар ажиллаж үр дүнд хүрч байгаа орон нутгийн туршлагын талаар дээр дурдаж байсан билээ. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажил нь олон салбар, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор засаг захиргааны бүхий л түвшинд бодлого, үйл ажиллагаа нь уялдаж

байж, үр дүнг авчирдаг тул Хамтарсан багийн хэлбэрийг дараах байдлаар тодорхойлж, зохион байгуулалтыг хийх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх хамтарсан баг
- Дунд шатны зөвлөх үйлчилгээ үзүүлэх хамтарсан баг
- Дунд шатны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хамтарсан баг хэмээн ангилж болно.

### **Анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх Хороо/баг, сургууль, байгууллага дээрх Хамтарсан баг**

Энэ баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн, төрийн анхан шатны нэгж хороо, багийн түвшинд сонгогдож, томилогдож ажиллаж байгаа Засаг дарга, цагдаагийн хэсгийн байцаагч, ерхийн эмч, хороо/багийн болон сургуулийн нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч зэрэг албан тушаалтан, ажилтнуудаас бүрдэнэ. Багийг нийгмийн ажилтан ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүргийнхээ дагуу удирдан чиглүүлнэ. Хэрэг/тохиолдол болон нутаг дэвсгэрийн байршил, онцлогоос шалтгаалан багийн бүрэлдэхүүнийг өөрчилж болно. Энэ баг нь анхан шатанд хамгийн хариуцлагатай бөгөөд иргэдэд хүргэх шууд үйлчилгээг хариуцна. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох, бүртгэх, баримтжуулах, хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх ажлууд нь анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх Хамтарсан багийн үндсэн үйл ажиллагаа юм. Багийн үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлвол:

- **Хамтран ажиллах стратеги тодорхойлох:** Хэрэг/тохиолдол болон орон нутгийн онцлогт тохирсон гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх нийгэмд тогтсон уламжлалт үзэл хандлагыг өөрчлөхөд нөлөөлөхүйц урьдчилан сэргийлэх агуулга бүхий сургалт, сурталчилгааны урт хугацааны тасралтгүй үргэлжлэх стратеги боловсруулан ажиллах;
- **Судалгаа хийх:** Баг, хороон дээр нийгмийн ажилтан, хэсгийн байцаагчид голлох үүрэг гүйцэтгэн, бусад

гишүүд мэдээллээр хангах үүрэгтэйгээр:

- Ойр орчиндоо түгшүүр төрүүлдэг гишүүнтэй айл өрх
- Архины хамааралд хэт орсон гишүүнтэй айл өрх
- Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй хүмүүс
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд
- Шинээр шилжин суурьшиж буй айл өрх
- Үндэсний цөөнх
- Сургуулиас завсардсан хүүхэд
- Хөдөлмөр эрхэлж буй хүүхэд
- Бусад шаардлагатай асуудлаар нарийвчилсан судалгаа хийх

Энэхүү судалгаанууд нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэхэд, мөн хамтран ажиллах үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, төлөвлөлт хийхэд ач холбогдолтой гэж үздэг.

- **Үйлчилгээний зураглал гаргах:** Гэр бүлд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний зураглалыг өөрийн нутаг дэвсгэрт болон хот, аймаг, улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, албан тушаалтан, мэргэжилтнүүдтэй холбоо тогтоож, багийн хүрээг өргөжүүлэх зорилгоор нарийн боловсруулах;
- **Мэдээлэл түгээх:** Иргэдэд хэрэгцээт мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр амаар, бичгээр, ном, гарын авлага, тараах материал, мөн тогтмол ажиллах самбарын мэдээллээр хүргэх;
- **Анхан шатны зөвлөгөө өгөх:** Хохирогчид сэтгэл зүй, хууль, эрүүл мэнд, сурган хүмүүжүүлэх болон бусад хэрэгцээт зөвлөгөөг багийн гишүүдийн зүгээс иргэдэд үзүүлнэ. Үүний тулд үйлчлүүлэгчид ганцаарчилсан зөвлөгөө өгөх нөхцлийг бүрдүүлэх ёстой. Жишээлбэл: нийгмийн ажилтны өрөө тусдаа байх шаардлагатай бөгөөд үйлчилгээ хүсэгчтэй ганцаарчлан уулзаж, хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх наад захын орчинг бүрдүүлэх шаардлагатай.
- **Бүлгээр зөвлөгөө өгөх:** Хүүхэд, ээжүүд, аавууд, гэр бүл, архины хамаарлаас гарахыг эрмэлзэгч иргэдийн гэх мэт тусгай хэрэгцээн дээр үндэслэн, дэмжих бүлэг ажиллуулж, бүлгийн сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх,

энэ чиглэлийн ТББ-тай хамтрах;

- **Хүчирхийллийн тохиолдол/хэрэг дээр хамтран ажиллах:** Хамтарсан багийн гишүүд өөр өөрсдийн ажил үүргийн дагуу тохиолдол/хэргийг шийдвэрлэхэд оролцож, хамтдаа хэргийг дуустал ажиллана. Үүний тулд:
  - Илрүүлэх
  - Мэдээлэл хүлээн авах
  - Шуурхай таслан зогсоох
  - Бүртгэх, баримтжуулах
  - Эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх
  - Үйлчилгээний төлөвлөгөө гаргах
  - Үйлчилгээний хэрэгжилтийг хянах, үйлчлүүлэгчтэй эргэх холбоотой ажиллах
  - Хэргийг хаах зэрэг нийгмийн ажил үйлчилгээнд мөрддөг технологийн дагуу хамтран ажиллана.
- **Сургалт:** Хүүхэд, эцэг эх, нийт иргэд рүү чиглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг төлөвлөн, багийн гишүүд болон бусад мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийг урьж оролцуулан зохион байгуулах;
- **Сурталчилгаа:** Хороо, багийн янз бүрийн сэдэвт өдөрлөг, үдэшлэг, баяр ёслолын арга хэмжээг тохиолдуулан сурталчилгааны олон талт үйл ажиллагаа явуулах;
- **Олон нийтийн оролцоог дайчлах:** Гэр бүл, хүчирхийлэл дарамтаас ангид аюулгүй амьдрах эрх, хүүхэд хамгаалалд онцгой анхаарч, олон нийтийн оролцоог дайчлах, хүүхдийн оролцоог бий болгох, чадавхижуулах;
- **Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах:** Хамтарсан багийн гишүүд тохиолдол/хэргийг шийдвэрлэхэд холбон зуучлах, сургалт сурталчилгаа явуулах, мэдээлэл авах, зарим нэгэн дээд шатны шийдвэр гаргагчидтай холбоотой асуудлаар холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах нь чухал. Аль болох олон салбарын мэргэжилтнүүдийг үйл ажиллагаандаа татан оролцуулснаар үйлчлүүлэгчид тулгарсан асуудлыг цогцоор нь үр дүнтэй шийдэж

чадна. Үүний тулд холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, байнгын харилцаатай байх, тодорхой сэдвээр кампанит ажил зохион байгуулах, харилцан мэдээлэл, туршлагаа солилцох, тохиолдол/хэрэг дээр хамтран ажиллаж, шийдвэрлүүлэхэд нөлөөлөх, үйлчлүүлэгчийн эрх, ашгийн үүднээс практик, бодлого, эрхзүйн орчныг боловсронгуй болгохоор нөлөөллийн ажил явуулах зэргээр хамтран ажиллаж болно.

### **Сум, дүүргийн түвшинд ажиллах Зөвлөх үйлчилгээ үзүүлэх Хамтарсан баг**

Орон нутгийн хэмжээнд хамтран ажиллах байгууллагуудаас баг бүрдүүлэх боломжтой. Багийн бүрэлдэхүүнийг Хүүхдийн төлөө зөвлөх, сум, дүүргийн цагдаа, эмнэлэг, боловсролын холбогдох албан тушаалтан, хороо, баг хариуцсан мэргэжилтэн, өмгөөлөгч зэрэг гэр бүл, хүүхдийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтэн, экспертээс бүрдүүлвэл илүү ач холбогдолтой.

- Зөвлөх баг нь орон нутгийн түвшинд мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх Хамтарсан багийг мэргэшүүлэх, арга зүйгээр хангах;
- Хороо баг дээр ажиллах хамтарсан багийг мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Орон нутгийн хэмжээнд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын судалгааг байгууллага тус бүрийнхээ мэдээлэл, бүртгэлд үндэслэн хийх, хариу арга хэмжээг төлөвлөж, бодлого тодорхойлох багт хүргүүлэх;
- Ноцтой тохиолдол/хэргийг шийдвэрлэхэд оролцох, дэмжлэг үзүүлэх;
- Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах, хариуцлагатай байхад анхаарч, зөвлөгөө туслалцаа үзүүлэх зэрэг ажлуудыг хийнэ.

### **Аймаг, нийслэлийн түвшинд ажиллах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх Хамтарсан баг**

Сум, дүүрэг, хороо, багт ажиллах Хамтарсан багуудыг бодлогоор хангах зорилгоор холбогдох албан тушаалтнуудаас бүрдсэн бодлого тодорхойлох баг бүрдүүлэх нь чухал. Үүрэг хариуцлагаа тодорхой байлгах үүднээс тус багийг аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс хариуцаж, бүрэлдэхүүнд нь нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хууль зүйн хэлтэс, харъяа Цагдаагийн хэлтсийн дарга, Хэв журмын хэлтсийн дарга, мөн чиглэлээр ажилладаг ТББ-ын төлөөлөл орж болно. Бодлого тодорхойлох баг нь:

- Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд;<sup>25</sup>
- Харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2004/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр /2007/, Гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого /2003/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжуудын хүрээнд төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; /ГБХТ хууль 8.1.1/
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж, санхүүжүүлэх; /ГБХТ хууль 8.1.2/
- Хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг ТББ-дыг дэмжин ажиллах талаарх ГБХТХ-ийн заалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх;
- Аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарга нар харъяа хэлтсээрээ дамжуулан Хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод Хамтарсан багт тэдний гүйцэтгэх ажил үүргийг оруулан баталгаажуулах;
- Хамтарсан багийн гишүүдийн ажлыг дүгнэх, үнэлэх,

<sup>25</sup>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн 8 дугаар зүйл

урамшуулах, хариуцлага тооцох механизмыг бий болгох зорилгоор бүтээгдэхүүн нийлүүлэх, үр дүнгийн гэрээнд асуудлыг тусгуулахад нөлөөлөх;

- Хамтарсан багийн ажиллах журмыг боловсруулж батлах, мөрдүүлэх;
- Анхан шатны Хамтарсан багийн ирүүлсэн судалгаанд үндэслэсэн бодлогын арга хэмжээ авах;
- Аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын Газрын дэргэд "Гэр бүлийн хөгжлийн төв"-ийг байгуулж, нийгмийн ажилтан ажиллуулж, уг төвөөс хороо, багийн Хамтарсан багийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах нь зүйтэй. Энэхүү арга хэмжээг эхний үед төслийн үйл ажиллагаагаар дэмжиж, дараа жилээс төсөвт суулгаж, орон тоогоор ажиллуулах боломжтой гэж үзэж байна.

## **ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ**

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын гол суурь болдог. Учир нь нийгэм, иргэдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийг хүн үйлддэг, тэр нь аль нэг гэр бүлийн гишүүн байдаг, орчны аливаа нөлөө нь зувь хүний зан үйлийн төлөвшилд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг гэж үздэг учир гэр бүл рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ нь зохих үр дүнгээ өгдөг. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд хэдий чинээ хүч зарцуулна, төдий чинээ нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг дагаж буурдаг гэж судлаачид үздэг байна. Манай анхан болон дунд шатны засаг захиргааны нэгж дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь сайн зохион байгуулагддаг, гүйцэтгэх механизм нь тодорхой уламжлалт ажлуудын нэг юм. Иймээс гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх Хамтарсан багийн ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын төлөвлөгөөнд оруулж, үе шаттай зохион байгуулж болно.

Хүчирхийлэлтэй харилцааны улмаас тухайн гэр бүлийн

гишүүдийн хүний үндсэн эрх зөрчигдөж, шийдвэрлэвэл зохих олон асуудлууд хуримтлагдсан байдаг. Иймээс хуулиар үүрэг хүлээсэн ганц нийгмийн ажилтан, эсхүл цагдаагийн ажилтан дангаараа, тус тусдаа үйлчилгээ үзүүлээд хүссэн үр дүнг авчирч чадахгүй. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийллийн зөвхөн нэг тохиолдол/хэрэг дээр ажиллахад дараах арга хэмжээг яаралтай авах шаардлагатай байдаг. Үүнд:

- Хүчирхийллийг шуурхай таслан зогсоох, хүчирхийллийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх;
- Гэр бүлийн гишүүдэд хэрэгцээт мэдээлэл өгөх;
- Сэтгэл зүйн тэнцвэрт байдлаа алдсан хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;
- Гэр бүлийн гишүүдийн хэрэгцээнд үнэлгээ хийж, тэдний онцлогт тохирсон богино ба урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх буюу холбогдох байгууллагад холбон зуучлах;
- Зөрчигдсөн эрхийг нь сэргээлгэх, хамгаалахад чиглэсэн эрх зүйн туслалцаа үзүүлэх;
- Хүүхдийн эрхийг хамгаалах талаар сургууль, хамт олонтой нь ажиллах;
- Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж хамгааллын үйлчилгээнд хамруулах;
- Хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох болон зан үйлийг нь өөрчлөхөд нөлөөлөх зэрэг олон асуудлыг нэгэн зэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанууд хэрэгтэй болдог.

Иймээс гэр бүлийн хүчирхийлэлд хөндлөнгөөс оролцогчид нь хоорондоо үйл ажиллагаагаа уялдуулан, албан ёсоор хамтран ажиллах шаардлагатай.

## **ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, үүргийг тодорхойлж өгсөн байдаг. Тухайлбал: гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх эрхийг баталгаажуулж өгснөөс гадна хохирогчийн аюулгүй байдлыг хангахад оролцох, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох, улмаар нууцлал хадгалах зэрэг үүрэг хүлээж байдаг. Үүгээр хуулиар тусгайлан үүрэг хүлээж байгаа төрийн үйлчилгээний байгууллага төдийгүй ТББ, иргэд, бизнесийн байгууллага ч хамтран ажиллах боломжийг шинээр нээж өгсөн бөгөөд энэ нь үйл ажиллагааны цар хүрээгээ өгсөн нэмэгдүүлэх боломж юм.

Орон нутгийн засаг захиргаа нь харъяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх үүргийг хүлээж байдаг. Мөн одоогийн төсвийн уламжлалт хэсэг болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал, Засаг даргын нөөц зардал, холбогдох үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардал, мөн гадаад дотоодын ТББ-ын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр зэргээс тухайн Хамтарсан баг өөрсдөө эрэл хайгуул хийж, хөрөнгө, нөөцийг дайчлах тусгай төлөвлөгөө гарган, төсвөө бүрдүүлэх боломжтой.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын хүрээнд хийгдэх ажил, тэр дундаа хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдэд чиглэсэн дэмжлэг нь төрөөс албан ёсоор зохион байгуулагдах ёстой. Энэ нь тусгай судалгаа, тайланд үндэслэж, өөрийн төсөвлөгдсөн зарцуулалт бүхий хөрөнгийн эх үүсвэртэй байна. Иймд орон нутаг бүр өөрийн өвөрмөц онцлогийг харгалзсан үйл ажиллагааг төлөвлөн, Хамтарсан багийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх боломжтой.

### ***Хохирогчийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх:***

"Хохирогчид үзүүлэх үйлчилгээ" гэж хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн тэнцвэрт байдлаа түр алдаж, хямарсан үед эмчилгээ хийх, нөхөн сэргээх үйлчилгээг хэлнэ. Эдгээр үйлчилгээнүүдийг засаг

захиргааны анхан шатны нэгж дээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулиар хохирогчдод үйлчлэх үүрэг хүлээсэн ажилтнууд үзүүлнэ.

### **Мэргэшин ажиллах:**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудал нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх суурь болохын зэрэгцээ төрийн нийгмийн үйлчилгээ, эрх зүйн үйлчилгээний гол хэсэг нь болж, цаашид гүнзгийрэн хөгжих боломжийг олгоно. Иймээс Хамтарсан баг цаашид мэргэшин ажиллах шаардлага зүйл ёсоор гарч ирж байна.

### **Үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар:**

- Тохиолдол/хэргээр дамжуулан гэр бүл, хүүхдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний олон төрлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлон гаргаж ирэхэд нөлөөлөх;
- Хуулиартусгай эрх, үүрэг хүлээсэн албан тушаалтнуудын ажиллах боломж, нөхцлийг бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах;
- Үйлчлүүлэгчийн болон гэр бүлтэй холбогдох хувийн нууцлалыг чанд хадгалах, ёс зүйн хүрээнд ажиллах;

### **Сум, дүүргийн хэмжээнд:**

- Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дэргэд гэр бүлийн хөгжлийг дэмжих төвийг байгуулах;
- Гэр бүлтэй ажиллах мэргэшсэн нийгмийн ажилтны орон тоог бий болгох;
- Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээтэй зэрэгцүүлж, нөхөн сэргээх, сэтгэл заслын үйлчилгээ бий болгон хөгжүүлэх;

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг сум дүүргийн хэмжээнд төлөвлөхдөө төрийн захиргаа, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хамгаалал, хуулийн байгууллагын оролцоотойгоор хамтарсан төлөвлөгөө гаргаж, жил бүр үр дүнг тооцож байх нь чухал.

### **Аймаг, нийслэлийн түвшинд:**

Тухайн жилд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны бодлого, стратегийг төрийн захиргаа, стратеги удирдлагын, нийгмийн хөгжлийн хэлтсүүд болон хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын оролцоотойгоор орон нутгийн онцлог хэрэгцээтэй уялдуулан тодорхойлно. Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны зардлыг жилийн төсөвт суулгаж өгөх шаардлагатай. Ингэснээр Хамтарсан багуудын үйл ажиллагааг идэвхижүүлэх, үр дүнтэй ажиллах боломжийг бий болгоно. Салбар хоорондын уялдааг хангаж, зохицуулалтыг тухайн орон нутгийн нийгмийн хөгжлийн хэлтсийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хохирогчид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг зохион байгуулах;
- Амь нас, эрүүл мэндэд нь аюул занал тулгарсан хохирогчдыг тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлж дуустал нь түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах;
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл засах албадан сургалтыг зохион байгуулах;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэшин ажилладаг ТББ-тай хамтран ажиллах, гэрээгээр үүрэг гүйцэтгүүлэх;
- Хуулиар хүлээсэн бусад чиг үүрэг;

### **Засгийн газрын түвшинд:**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгасан цагт энэ ажилд нилээд ахиц, хөгжил гарна.

Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хууль зүй, дотоод хэрэг, эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний бодлого стратегийг тодорхойлж, салбар дундын зохицуулалтыг хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах тухай Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын

тогтоолд тусгаж өгсөн байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгчдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний стандарт, удирдамжийг баталж, мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих нь бас энэ байгууллагын бүрэн эрхийн хэмжээнд хэрэгжих ёстой.

Энэ хүрээнд одоогийн байдлаар:

- Хамгаалах байрны стандарт
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх
- Нэг цэгийн үйлчилгээний төв

**Төрийн бус байгууллагын оролцоо:**

Гэр бүлийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээг Засгийн газартай гэрээлэн гүйцэтгэх боломж аль ч шатанд хэрэгжих боломж бий. Үүнд

- Хохирогчийг хамгаалах байраар хангах;
- Хохирогчид нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх;
- Утсаар яаралтай туслалцаа үзүүлэх үйлчилгээ;
- Хохирогчид эрхзүйн туслалцаа үзүүлэх;
- Хохирогчид сэтгэлзүйн болон сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх;
- Хүчирхийллийг даван туулагчдад зориулан өөрөө өөртөө туслах бүлэг зохион байгуулах;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаархи сургалт, сурталчилгаа, судалгааны үйл ажиллагаа явуулах, хууль сурталчлах;
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах;
- Хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийг сургах, аргагүйгээр хангах;
- Мөн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох зэргээр Хамтарсан багийг дэмжих орчин бүрдүүлж ажиллах боломжтой.

## БҮЛЭГ 5. ХАМТАРСАН БАГААР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БАЙГАА САЙН ТУРШЛАГУУД

Хамтарсан багаар ажиллах арга зүй нь анх 2003 онд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Хүүхэд хамгааллын нэгж, Их Британий Хүүхдийг ивээх сангийн санаачилгаар Хан-Уул дүүргийн 8-р хороо дээр хэрэгжиж эхэлсэн. Хамтарсан багийг нийгмийн ажилтан чиглүүлж, бүрэлдэхүүнд нь хорооны Засаг дарга, хэсгийн байцаагч, хэсгийн ахлагч, өрхийн эмч, сургуулийн нийгмийн ажилтан орж, тус хороон дээр хэрэгждэг Өрхийн амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэх хэлбэрээр ажлаа хамтран төлөвлөж, гишүүн бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, жишиг хороо болох зорилт тавин эхэлсэн. Амьжиргаа дэмжих зөвлөл урьд нь харъяа нутаг дэвсгэрийн нийгмийн халамж шаардлагатай эмзэг өрх, аж амьдралаа дээшлүүлэхийн тулд төрөөс дэмжлэг хүсэж буй иргэдийг зээл тусламжид хамруулахад хамтран хэлэлцэж, тодорхой шийдвэр гаргадаг байсан бол Хамтарсан багийн зохион байгуулалтанд орсноор хүний эрх, эрх чөлөө, аюулгүй амьдрах эрхийг хамгаалах асуудлаар хамтын хүчин чармайлт гарган ажиллаж эхэлсэн юм. Гэхдээ энэ нь урьд өмнө хийгдэж л байсан ажил тул ер түүртэж байгаагүй. Учир нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, архи дан согтуурч, гэр бүлийн гишүүдийнхээ амгалан тайван байдлыг алдагдуулсан талаар цагдаагийн байгууллагад байнга дуудлага ирдэг. Цагдаагийн ажилтан дуудлагын мөрөөр ажиллахдаа шаардлагатай иргэн, гэр бүлд чиглэсэн нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлэх, халамжийн үйлчилгээнд хамруулах талаар нийгмийн ажилтан, Засаг дарга нарт санал хүсэлт гарган, зарим ажлыг хамтран зохион байгуулдаг туршлага байсан. Хамгийн анх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар Хамтарсан багийн төлөвлөгөө боловсруулж суухдаа хорооны цагдаагийн хэсгийн байцаагч нь “*Ингэж нэг миний ажлыг ойлгож, тусалж, хамтран ажиллах хүмүүс гарч ирж гялайлгах гэж*” хэмээн хошигнож байж билээ. Түүнээс хойш энэ хороон дээр иргэд, гэр бүлд тулгамдсан олон асуудлаар судалгаа, санал асуулга явуулж, үүний үр дүнд “Архины хор уршиг”, “Гэр бүлийн амар амгалан”, “Эцэг хүний үүрэг хариуцлага”,

“Хүүхдээ сайн хүн болгомоор байна уу” зэрэг кампанит ажлууд өрнөж, үүнтэй зэрэгцүүлэн иргэдэд ганцаарчилсан зөвлөгөөг өгч эхэлсэн. Үүнд: хэсгийн байцаагч нь хуулийн, нийгмийн ажилтан нь сэтгэл зүйн, өрхийн эмч нь эрүүл мэндийн зөвлөгөө өгч, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдийн дэмжих бүлэг, хорихоос суллагдсан болон хорихоос өөр төрлийн ял эдэлж буй эрэгтэйчүүдийг нийгмийн амьдралд оролцуулах зорилготой төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулсан нь иргэдийн талархлыг хүлээж байлаа. Ингэснээр энэ хороо тухайн жилдээ нийслэлийн тэргүүний хороо шалгаруулахад 3-р байр эзэлсэн нь “Хамтарсан багаар ажилласны үр дүн” хэмээн өөрсдөөрөө бахархаж байж билээ.

Хамтарсан багаар ажиллах загварыг энэ хороон дээр туршсаны дараа Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Их Британий Хүүхдийг ивээх сангаас Хамтарсан багийн ач холбогдлыг сурталчлан таниулах, багаар ажиллах хэрэгцээ, шаардлагыг засаг захиргааны анхан шатны нэгж дээр ажилладаг мэргэжилтнүүдээс тодорхойлон гаргаж ирэх, төрийн захиргааны дунд болон дээд шатанд ойлгуулан таниулах, бодлогын баримт бичгүүдэд тусгуулах зэргээр бодлогын түвшинд олон үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан. Үүний үр дүнд 2007 он гэхэд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн салбар байдаг зарим аймаг, Их Британий Хүүхдийг ивээх сангийн орон нутаг дахь Хүүхдийн хөгжил, хамгааллын төвүүд, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүд, Монголын Эмэгтэйчүүдийн сангийн дэмжлэгтэй арав гаруй аймагт Хамтарсан баг байгуулагдсан байлаа.

Хамтарсан багаар ажиллах тухай хамгийн анхны шийдвэрийг Дорнод аймгийн Засаг дарга 2006 оны 6 сарын 12 -нд аймгийн Засаг даргын 205 тоот захирамж гаргаснаар эхлүүлж, дараа нь Өвөрхангай, Өмнөговь, Завхан, Говьсүмбэр, Дархан –Уул, Сэлэнгэ, Дундговь зэрэг аймгуудын Засаг даргын захирамжууд гарч, тухайн орон нутгуудад хэрэгжиж эхэлсэн. Харин нийслэлийн хувьд 2007 онд бүх хороодод Хамтарсан баг байгуулж ажиллах тухай Нийслэлийн Засаг даргын захирамж гарсан.

Хамтарсан багийн хөгжлийн явцаас харахад хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүлийн асуудлаар үүрэг хүлээж ажилладаг салбар, нэгжүүд энэ асуудалд анхаарал хандуулах нь нэмэгдэж

Тухайлбал, хүүхдийн төлөө хэлтэс, нийгмийн хөгжлийн хэлтэс, хуулийн хэлтсүүд илүү анхаарч ажиллаж байна.

2007 оны 9-р сарын 12-нд Монгол улсын Засгийн газрын №225 тоот тогтоолоор "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Үндэсний хөтөлбөр" батлагдаж, энэхүү хөтөлбөрт Хамтарсан багийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд үе шаттайгаар дэмжин дэлгэрүүлэх тухай /1.3.3/ заалт орсон нь амжилттай хэрэгжих эрх зүйн боломжийг бүрдүүлж өгсөн юм.

Иймээс Хамтарсан багаар ажиллах нь өнөөдөр хүссэн нь хийж, хүсээгүй нь тоомжиргүй орхидог асуудал биш болжээ. Хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагынхаа хүрээнд заавал хэрэгжүүлэх алхам болсон байна. Бүх хүн гэр бүлдээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл дарамтаас ангид, эрүүл саруул, хамгаалагдсан орчинд эрх тэгш амьдрах эрхтэй. Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил учраас хохирогчдын нийтлэг эрх ашигт нийцсэн цогц үйлчилгээг хүртээмжтэйгээр, мэргэжлийн түвшинд үзүүлэх талаар Хамтарсан багт ажиллах албан тушаалтнуудыг мэргэшүүлж, захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл салбар дундын зохицуулалт шаардсан асуудал. Мөн хүн амын бүлгийн дунд нийтлэг тохиолддог нийгмийн сөрөг үзэгдэл гэдэг талаас нь авч үзвэл энэ нь орон нутгийн нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудал юм.

Орон нутагт ажиллаж буй Хамтарсан багийн туршлагын талаар энэ бүлэгт хавсралтаар оруулсан нь ижил төстэй үйл ажиллагааг явуулахад хөтөч болно хэмээн үзэж байна.

## **УЛААНБААТАР ХОТЫН ХОРООДОД ХАМТАРСАН БАГИЙГ БАЙГУУЛЖ, АЖИЛЛУУЛЖ БАЙГАА ТУРШЛАГА**

*С.Айнагүл, Нийслэлийн Засаг даргын Тамгын  
газрын Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн*

Сүүлийн жилүүдэд Нийслэлийн засаг захиргааны зүгээс "Гэр

бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой алхмуудыг хийж байна. Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын 2007 оны 144 дүгээр захирамж гарч, хороо бүрт гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулах "Хамтарсан баг"-ийг байгуулсан бөгөөд багийн бүрэлдэхүүнд хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч, хэсгийн байцаагч, өрхийн эмч, хамран сургах тойргийн боловсролын нийгмийн ажилтнуудыг хамрууллаа. Мөн захирамжаар Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг дүүргийн төсөвт суулгахыг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон. Хамтарсан баг байгуулан ажиллуулснаар хуулиар үүрэг хүлээсэн албан тушаалтнууд болон бусад ажилтнууд, олон нийтийн зүгээс гэр бүлийн хүчирхийллийг хувийн, гэр бүлийн дотоод асуудал мэт үзэж байсан хандлага өөрчлөгдөж эхэлсэн гэж үзэж болохоор үр дүн харагдаж байна.

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хууль зүйн хэлтэс нь Хамтарсан багийг цаашид тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Нийслэлийн Хүүхдийн Төлөө Газар /НХТГ/, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв /ХЭҮТ/ ТББ, Хүүхдийг Хүчирхийллээс Хамгаалах Төв /ХЭҮТ/ ТББ, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтарч 2009 оны 3-5 дугаар сард нийслэлийн 45 хорооны 200 гаруй Хамтарсан багийн гишүүдэд сургалт явууллаа. Энэхүү сургалтаар:

- Хамтарсан багаар ажиллаж байсан туршлага болон бэрхшээл
- Хамтарсан багаар цогц үйлчилгээ үзүүлэх боломж, хэрэгжүүлэх арга зам
- Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүний илрэл хэлбэр, хор уршиг
- Гэр бүлийн хүчирхийллийн хэргийн онцлог, түүний илрэл хэлбэр
- Хамтарсан баг, багийн гишүүдийн үүрэг оролцоо, ажлын үр дүн хариуцлага
- Хамтарсан багаар ажиллах төлөвлөгөө, баримтлах стратеги боловсруулах зэрэг чиглэлээр тэдний ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлсэн юм.

Хороодод хамтарсан баг байгуулагдсанаас хойш сургалт, сурталчилгааны олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагдсаны үр дүнд иргэд, олон нийтийн хүчирхийллийг үл тэвчих, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх ойлголт нэмэгдэж, үйлчилгээ хүсэн хороондоо хандсан хохирогчдын тоо нэмэгдэх хандлагатай болсон байна.

2009 оны 5 дугаар сард НХТГ, НЗДТГ, ХЭҮТ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Хамтарсан багийн ажлын байрны тодорхойлолтонд нэмэлт оруулах хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэгт Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, дүүрэг хорооны холбогдох мэргэжилтнүүд, Хамтарсан багийн гишүүдийн төлөөлөл оролцсон ба оролцогчид багийн ахлагч хэн байх вэ гэсэн асуудалд нэлээд зөрүү байр суурьтай байсан. Ихэнх хэсэг нь нийгмийн ажилтнууд нэгдсэн бүртгэл мэдээллийг нэгтгэж, үйлчилгээг гардан үзүүлдгийн хувьд ахлагч байх нь зүйтэй гэж үзсэн. Хорооны Засаг дарга Хамтарсан багийн ахлагч байх нь хөрөнгө санхүүгийн талын асуудлыг шийдвэрлэхэд дөхөм гэсэн санал ч гарч байлаа.

Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх, хохирогчид сэтгэл санааны болон бусад талын зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх ажлыг нийгмийн ажилтан хийдэг. Хүчирхийлэлтэй гэр бүлтэй ажиллахад нийгмийн ажилтнууд өөрсдөө эрсдэлтэй хүнд байдалд орох, аюул заналтай тулгарах асуудал гардаг учраас Хамтарсан багийн гишүүд тэр дундаа цагдаагийн ажилтантай хамтарч ажиллах нь илүү үр дүнтэй юм.

Хамтарсан багийн гишүүдийн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон тэмцэх хүрээнд хийж байгаа ажилтай танилцах, гишүүдийн ажил байдлын тодорхойлолтын төсөл болон үйлчилгээний бүртгэлийн маягыг хэрэглэж байгаа байдалтай танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 2009 оны 9 дүгээр сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтарч төвийн 6 дүүргийн 12 хороогоор явж, газар дээр нь захирамжийн хэрэгжилттэй танилцлаа. Хамтарсан багийн ажил дүүрэг бүрт харилцан адилгүй байсан учир 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт албан тоот явуулж, 2009 онд багтааж Хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах сургалтыг зохиох, цаашид сургалтыг тогтмол зохион явуулах талаар зөвлөмж хүргүүлсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар нийгмийн ажилтан болон цагдаагийн ажилтны үүргийг зааж өгсөн боловч Хамтарсан багийн бүрэлдэхүүнд орж байгаа бусад ажилтнуудын үүргийн талаар зааж өгөөгүй, ажлын байрны тодорхойлолтонд нь ч байхгүй, багаар гүйцэтгэх эрх, үүрэг тодорхойгүй байгаа нь хамтран ажиллахад багагүй бэрхшээл үүсгэж байна.

“Хамтарсан баг” байгуулж ажиллах, хохирогч төвтэй нэг цэгийн үйлчилгээг үзүүлэх талаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тусгаж өгөөгүй ч Монгол Улсын Засгийн 2007 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн Хүрэх үр дүнгийн 1.3-д “Хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг таслан зогсоох мэргэжлийн үйлчилгээг үндэсний хэмжээнд шуурхай, хүртээмжтэй үр дүнтэй үзүүлдэг болсон байна.”, мөн Хэрэгжүүлэх арга хэмжээний 1.3.3-д “Нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийн буюу Хамтарсан багийн хэлбэрээр хүргэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах” гэж зааж өгсөн эрх зүйн энэхүү боломжийг бид ашиглах ёстой юм.

Хүчирхийлэлд өртсөн хохирогч, үйлчлүүлэгчид /охид, эмэгтэйчүүд, хүүхэд, бусад хүмүүс/ цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхээр эмнэлэгт түшиглэсэн “Нэг цэгийн үйлчилгээ”-г туршилтын журмаар Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл дээр 2009 оны 12 дугаар сард байгуулж, үйл ажиллагаа эхэлсэн. “Нэг цэгийн үйлчилгээ” төвийг бусад дүүргүүдэд байгуулах талаар судалгаа хийгдэж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг удирдах албан тушаалтанд танилцуулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх байгууллагуудын удирдлагыг оролцуулан 2010 оны 2 дугаар сарын 25-нд нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Цагдаагийн газарт уулзалт, ярилцлага зохион байгууллаа. Уулзалт ярилцлагад Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсийн удирдлагууд, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн нэгдлийн дарга нар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг төрийн болон ТББ-ын төлөөлөл оролцож, өөрсдийн байр суурийг илэрхийлж, хамтран ажиллах ажлын чиглэлийг гаргав. Энэ уулзалт ярилцлагаар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай

хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй ажил", "Нийслэлийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдөд үзүүлж буй эрүүл мэндийн тусламжийн өнөөгийн байдал, хүчирхийлэлд өртөгчдөд тусламж үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвөөс үзүүлж буй үйлчилгээний тухай", "Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдөд цагдаагийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд хийгдэж буй алхам, сайн туршлага, анхаарах асуудлууд" зэрэг сэдвээр мэдээлэл хийж санал солилцож, оролцогчид төлөвлөгөөнд бүтээлч санал хэлсэн нь нийслэлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр тодорхой ахиц гарах боломж гэж үзэж байна.

Цаашид нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, хорооны Засаг даргын ажлын алба, Цагдаагийн газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Хүүхдийн төлөө газар, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв ТББ, Хүүхдийг Хүчирхийллээс Хамгаалах Төв ТББ, бусад төрийн болон ТББ-ууд хамтран, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах чиглэлээр анхаарч ажиллах бодлогын түвшний болон зөвлөх үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай байна.

## **ЗАВХАН АЙМАГТ ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАЖ БАЙГАА ТУРШЛАГА**

*Ж. Бямбасүрэн, ХЭҮТ-ийн төвийн салбарын зохицуулагч*

Завхан аймгийн Засаг даргын 2007 оны 6-р сарын 15-ны захирамжаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтнүүдийг оролцуулсан Хамтарсан баг байгуулагдсан. Энэ багийн бүрэлдэхүүнд Цагдаагийн олон нийтийн байцаагч, ХЭҮТ-ийн салбарын ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, багийн Засаг дарга, шүүгч, өрхийн эмч нар орж ажиллаж байна.

Манай багийн онцлог нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй

тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол/хэргийг шийдвэрлэх зэрэгт илүү анхаарч ажиллаж байна.

Хүчирхийллийн харилцаатай нэг гэр бүлтэй шүүхээр хэргийг шийдвэрлэх шатанд ажилласан. Энэ гэр бүлтэй Хамтарсан баг одоо болтол холбоо харилцаатай байгаа бөгөөд Цагдаагийн газрын олон нийтийн байцаагч, ХЭҮТ-ийн салбарын ажилтан, шүүгч нар ганцаарчилсан болон гэр бүлийн зөвлөгөө өгсөн.

Манай багийн гишүүн, цагдаагийн олон нийтийн байцаагч нь орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтэд мэдээлэл түгээх, тэднээс мэдээлэл цуглуулах ажлыг ажил үүргийнхээ дагуу хийдэг нь Хамтарсан багийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, хүчирхийллийн харилцаатай гэр бүлийг илрүүлэхэд тус дөхөм болдог. Мөн илрүүлэх үйл ажиллагаанд өрхийн эмч нар гол үүрэг гүйцэтгэдэг. Эмч нар эрүүл мэндийн өдөр тутмын үзлэг хийх, төрсөн эхчүүдийг гэрээр эргэх, хүүхдийг вакцинжуулалтанд хамруулах явцдаа ажиглалт хийх, зөвлөгөө өгөх зэрэг аргаар хүчирхийллийн сэжиг бүхий тохиолдлыг Хамтарсан багт мэдээлдэг. Үүний дагуу олон нийтийн байцаагч тухайн гэр бүлд айлчилж, нууцлагдмал байсан хүчирхийллийн харилцаатай гэр бүлүүдийг илрүүлэн, хохирогч, хүчирхийлэл үйлдэгч нарт ганцаарчилсан хууль зүйн зөвлөгөө өгөх, олон нийтийн үйл ажиллагаанд тухайн гэр бүлийн гишүүдийг тогтмол хамруулах, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлах зэрэг олон ажлуудыг шат дараалан төлөвлөж, хэрэгжүүлж , тодорхой туршлага хуримтлуулж байна.

Гэвч, гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх явцад багагүй хүндрэл бэрхшээл тулгарсан хэвээр байна. Тухайлбал, Хамтарсан багаар ажиллах аргачлал дутмаг, гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг дээр ажиллах туршлага байхгүй, багийн гишүүдийн ажил байдлын тодорхойлолтонд суугаагүйгээс зарим гишүүд тухайн хэрэгт төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаа нь харагддаг.

Цаашид сургууль, цэцэрлэгийн багш ,нийгмийн ажилтан, баг, өрхийн эмч, багийн Засаг дарга, хэсгийн байцаагч, халамжийн ажилтан нарт Хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийг тухайн байгууллагын үр дүнгийн гэрээнд тусган ажиллуулах талаар шийдвэр гаргах түвшний хэмжээнд нөлөөллийн ажил хийх хэрэгтэй

хэмээн үзэж, энэ зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээг 2010 оноос эхлэн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

## **ХҮҮХДИЙГ ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАХ ТУРШЛАГА**

*Э.Алтантуяа, Дорнод аймгийн Хүүхдийн  
төлөө хэлтсийн дэргэдэх ОНТХХ  
төвийн нийгмийн ажилтан*

ХЭҮТ-ийн салбараас санаачлан аймгийн Засаг даргын 205 тоот захирамж гарснаар орон нутгийн түвшинд олон нийтийн оролцоотой хүүхдийг хүчирхийлэл дарамтанд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, өртсөн тохиолдолд хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн эрхийг хангах зорилготойгоор Хамтарсан багууд идэвхитэй ажиллаж байна. Хамтарсан багийн бүрэлдэхүүнд багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмч, хэсгийн ахлагч нар ордог, Аймгийн төвийн 10 багт Хамтарсан баг байгуулагдсан. Аймгийн хүүхдийн төлөө хэлтсээс Хамтарсан багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

2005 оноос эхлэн Хүүхдийг Ивээх Сангийн салбар, аймгийн төвийн зарим багуудад Хамтарсан багийг байгуулан ажилласан. Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд ОНТХХТ-ийн үүрэг оролцоо их байсан юм. Тухайлбал, Хэрлэн сумын 4 дүгээр багт 2006 оноос нийт 44 өрхийг сонгон ажиллаж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, эрх зүйн туслалцааг 21 хүүхдэд, сургууль завсардсан 16 хүүхдэд албан бус боловсрол болон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлж, эм тариа, хоол тэжээлийн дэмжлэгт 25 хүүхэд, нийгэмшүүлэх цирк сургалтанд 18 хүүхэд хамруулан тодорхой үр дүнг гаргаж ажилласан.

2009 онд Хамтарсан багийн гишүүдийн оролцоо, чадварыг нэмэгдүүлэх сургалт, тодорхой тохиолдол/хэрэгт суурилсан хэлэлцүүлгийг 7 хоног тутам тогтмол зохион байгуулж, гэр бүлд үзүүлэх үйлчилгээг чанартай болгоход анхаарч ажилласан.

Багуудын хэсгийн ахлагч нарыг идэвхижүүлж, хамтарч ажилласан нь хүүхдийн эрхийн зөрчлийг олж илрүүлэхэд чухал ач холбогдолтой байсан. Хэсгийн ахлагч нараас ирсэн мэдээллийн дагуу өрх гэрээр уулзалт зохион байгуулж, шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн. Хүчирхийлэлтэй харилцаатай гэр бүлийн талаарх мэдээллийг цуглуулахад тэдний оролцоо зайлшгүй хэрэгтэй байсан. 2010 онд мэдээлэл авахаас илүүтэйгээр тэднийг өрх, гэр бүлтэй тулж ажиллахад бэлтгэж, чадавхижуулахаар төлөвлөж байна.

2007 оноос эхлэн багуудад нийгмийн ажилтан ажиллуулж эхэлсэн. Одоо нийт 10 багийн 4-т нь нийгмийн ажилтан ажиллаж байна. Мөн багийн гишүүдийг харъяалдаг ажлын албаны үр дүнгийн гэрээнд Хамтарсан багаар ажиллах ажлын төлөвлөгөөг оруулах, үр дүнг хэлэлцэж байхаар шийдвэрлэсэн нь ажил урагштай хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлж өглөө.

## **ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ**

### *3. Бат-Эрдэнэ, Хэнтий аймгийн ХТТ хэлтсийн дарга, Хүүхэд хамгааллын Хамтарсан багийн ахлагч*

Хэнтий аймгийн Хэрлэн суманд байгуулагдсан зөвлөх үйлчилгээ үзүүлэх Хамтарсан баг нь анх аймгийн Хүүхдийн төлөө хэлтэс, Хүүхдийн гэмт хэргийг хариуцах хороо болон ДЗОУБ-ын санаачилгатайгаар 2008 оны 04-р сард анхны уулзалтаа хийж байгуулагдсан. Энэхүү баг нь хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор бодлогын түвшинд ажилладаг 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Явцын дунд энэ бодлогын баг маань үйлчилгээ үзүүлдэг анхан шатны нэгжтэй байх шаардлагатай болсон. Иймээс Хэрлэн сумын төвийн 5 баг дээр:

- Багийн Засаг дарга
- Өрхийн эмч
- Цагдаагийн хэсгийн байцаагч
- Хамран сургах тойргийн ЕБС-ийн нийгмийн ажилтан
- Цэцэрлэгийн арга зүйч

- ДЗОУБ-ын хувьсан өөрчлөгдөх хөгжлийн чиглүүлэгч гэсэн бүрэлдхүүнтэйгээр анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх Хамтарсан багийг бүрдүүлж, тэдгээрийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Багууд дээр анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх Хамтарсан баг байгуулагдсанаар орон нутагт хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр анхны ахиц гарсан гэж хэлж болно. Иргэд, олон нийт, хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдийн дунд хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, мэдлэг нэмэгдэж, хүний эрхийн энэ зөрчлийн эсрэг хүчээ нэгтгэж тэмцэх нь чухал гэдгийг мэддэг болж, хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэхэд иргэдийн оролцоо нэмэгдэж байна.

**Сургамж:** Тус аймагт Хамтарсан баг байгуулагдан 2 жил шахам болж байгаа ч тодорхой хэргүүд шийдвэрлэн амжилтанд хүрсэн бодит жишээ байхгүй байгаа. Цаашид анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх Хамтарсан багийг байгуулан ажиллуулахдаа багийн гишүүдийн урам зоригийг дэмжин сэргээж өгөх, удирдлагуудад энэ талын ойлголт өгч дэмжүүлэх, боломжтой бол санхүү, урамшууллын асуудлыг шийдвэрлэж өгөх, арга зүйгээр сайн хангаж өгөх шаардлагатай гэдэг нь харагдсан. Мөн Хамтарсан багийг мэргэжлийн арга зүйгээр хангах удирдлагын механизмыг бий болгох, албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтод оруулах, албажуулах хэрэгтэй байна.

## **ГОВИЙН БҮСИЙН МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАЖ ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ**

*Б.Долгормаа , Дундговь аймаг дахь ХЭҮТ-ийн салбарын  
зохицуулагч, "Говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний  
төв"-ийн дэргэдэх Хамтарсан багийн ахлагч*

Говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний төвийн дэргэдэх Хамтарсан баг нь 2009 онд ХЭҮТ-ийн салбарын санаачлагаар байгуулагдсан. Засаг захиргааны шийдвэр гарч, албан ёсоор

байгууллагдаагүй боловч, гэр бүл, хүүхдийн эрхийг хангах чиг үүрэг бүхий төр болон ТББ-ын төлөөлөгчид нэгдэж, аймгийн төвдөө зөвлөх багийн хэлбэрээр хамтран ажилладаг. Багийн бүрэлдэхүүнд:

- Аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн дарга
- Аймгийн Цагдаагийн хэлтсийн хүүхдийн байцаагч
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Өсвөр үе охидын эмч
- Аймгийн Боловсрол Соёлын Газрын арга зүйч
- Сайнцагаан сумын 5-р багийн Засаг дарга
- Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн нийгмийн ажилтан
- Дэлхийн зөн ОУБ-ын Дундговь аймаг дахь салбарын зохицуулагч
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн нийгмийн ажилтан, Сайнцагаан сумын хүүхдийн элч
- Эрдмийн далай цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан
- 11 жилийн 3-р дунд сургуулийн нийгмийн ажилтан
- Говийн бүсийн мэдээлэл, үйлчилгээний төвийн зохицуулагч /ХЭҮТ-ийн салбар/ багтсан.

Манай багийн онцлог нь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээлэл дээрх байгууллагуудын аль нэг дээр ирэхэд, багийн гишүүддээ мэдээлж, тухайн хэргийг шийдвэрлэгдэж дуустал хамтран ажилладаг онцлогтой гэж хэлж болно. Бидний хамтран ажилладаг арга барилыг дараах жишээнээс харж болох юм.

### **Хэргийн товч танилцуулга:**

*Үйлчлүүлэгч Б нь гэр бүлийн хүчирхийлэлд удаа дараа өртсөний улмаас ХЭҮТөвийн харъяа "Говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний төв"-өөр 2009 оноос хойш үйлчлүүлж байна. Тэрээр ам бүл 5, нөхөр 3 хүүгийн хамтаар айлын хоосон хашаанд толгой хоргодон түр амьдардаг. Нөхөр нь Б-тай гэрлэсэн цагаасаа эхлэн дарамталж, өөрийнхөө хэвтэрт орсон ээжтэйгээ цуг хаяад явсан төдийгүй өөр хүнтэй гэр бүлийн харилцаатай болсныг сүүлд мэджээ. Удалгүй хадам эх нь нас барсан. Энэ хугацаанд Б нөхрийн дарамтанд өртөөд зогсохгүй, хадам ах, эгч, хамаатан нь хүртэл түүнийг хүүхэдтэй нь цуг хөөдөг. Тэр өнчин бөгөөд*

багаасаа хөдөө хамаатныдаа мал маллан амьдардаг байхдаа О-тай танилцсан, бичиг үсэг мэдэхгүй. Тэрээр Манай төвийн хамгаалах байранд 3 хүүхдийн хамтаар хэд хэдэн удаа байрлаж байсан.

### **Хамтарсан багаар уг хэрэг дээр ажилласан байдал:**

ХЭҮТ-ийн салбарын зөвлөгч нь О, Б нартай ганцаарчлан уулзсан. Дараа нь хамтарсан багаараа нөхцөл байдлын үнэлгээ болон тандалтын судалгааг хийж, кейсийг шийдвэрлэх төлөвлөгөө гарган, хамтран ажиллах зураглалаа гарган ажилласан. Тухайлбал:

- ГБМҮТөвийн зүгээс нэн тэргүүнд хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах зорилгоор үйлчлүүлэгчийг хамгаалах байранд байрлуулж, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.
- Үйлчлүүлэгчийн хүсэлтээр аймгийн сум дундын шүүхэд гэрлэлт цуцлах, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох нэхэмжлэх гаргахад нь тусласан.
- Багийн гишүүн цагдаагийн хүүхдийн байцаагч нь бусад гишүүдтэй хамтран үйлчлүүлэгчийг шүүх эмнэлгийн магадлагаа гаргахад зуучилж тусалсан.
- Хамгаалах байранд байх хугацаанд гурван хүүхдийнх нь хамтаар эмчийн үзлэгт хамруулсан.
- Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран эрүүл мэндийн даатгалд нөхөн хамруулах ажлыг Дэлхийн зөн хариуцсан. /Үйлчлүүлэгч төлбөрийн чадваргүй байсан тул Хамтарсан багийн гишүүдийн оролцоотойгоор үнэ төлбөргүй хамруулж өгсөн ба зарим нэг шаардлагатай зардлуудыг ДЗОУБ-аас гаргуулсан. /
- ДЗОУБ-ын зүгээс 3 хүүхдийг нь” Зөнгийн хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр”-т хамруулж, хамгаалах байранд байранд ээжийн хамтаар байрлах хугацааны хоол хүнсний тусламжийг үзүүлж байсан.

### **Хамтарсан багийн үйл ажиллагааны үр дүн:**

- ДЗОУБ-ын “Гэр хөтөлбөр”-т хамруулж 4 ханатай иж бүрэн гэртэй болгосон. Аймгийн ХХҮХэлтсийн “Түлш хөтөлбөр”-өөс өвлийн түлшний хөнгөлөлтийг үзүүлсэн.

- Нийгмийн ажилтнууд хамтран сургууль завсардсан нэг хүүхдийг нь сургуульд хамруулан суралцууллаа. Бага нь болох 2 ихэр хүүхдийг Дэлхийн Зөн Дундговь байгууллагын халамжийн цэцэрлэгт хамруулсан. Мөн хүүхдүүдийг ХХҮХэлтсийн сургалтын төв болон манай төвийн дэмжих бүлгээс зохион байгуулдаг "Амьдрах ур чадвар"-т сургах сургалтуудад хамруулж байна.
- Үйлчлүүлэгч бичиг үсэг мэдэхгүй ба аймгийн Боловсрол соёлын газрын арга зүйч түүнийг "Албан бус сургалт"-д хамруулан бичиг үсэг заасан бөгөөд одоо уншиж бичиж чаддаг болсон.
- Хамтарсан багийн гишүүн багийн Засаг дарга үйлчлүүлэгчийг ажилд зуучилж өгсөн ба тэрээр гуанзанд туслах тогтооч, оройн цагаар сургуулиудад анги цэвэрлэх ажлыг давхар хийж, өөрийн гэсэн орлоготой боллоо.

Бидний хамтын ажиллагааны нэгдмэл зорилго, хичээл зүтгэлийн үр дүнд нэг эмэгтэй, 3 хүүхэд, нэг гэр бүлийн амьдралд тодорхой өөрчлөлтийг авчирч чадсан юм.



Хавсралт 1

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 05 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж

2.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>26</sup>, Иргэний хууль<sup>27</sup>, Эрүүгийн хууль<sup>28</sup>, Гэр бүлийн тухай<sup>29</sup>, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль<sup>30</sup> энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

<sup>26</sup>Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

<sup>27</sup>Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн

<sup>28</sup>Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

<sup>29</sup>Гэр бүлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 8 дугаарт

<sup>30</sup>Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 6 дугаарт нийтлэгдсэн

### **3 дугаар зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд**

3.1.Энэ хуулийн зохицуулалтад Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн хамаарна.

3.2.Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс, түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны үр дүнд тухайн иргэний асрамжид байгаа этгээд нэгэн адил хамаарна.

### **4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зарчим**

4.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх зарчимд үндэслэнэ.

### **5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1."гэр бүлийн хүчирхийлэл" гэж гэр бүлийн хүрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.2."болзошгүй хүчирхийлэл" гэж тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгааг;

5.1.3."хамгаалах байр" гэж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж, хохирогчид үйлчилгээ үзүүлэх газрыг;

5.1.4."хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт" гэж хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаанаас үүссэн асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн зохих хөтөлбөрийн дагуу явуулах сургалтыг;

5.1.5."хохилогчид үзүүлэх үйлчилгээ" гэж хохилогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь төр хямарсан үед эмчилгээ хийх, нөхөн сэргээх ажиллагааг;

5.1.6."эрх хязгаарлах арга хэмжээ" гэж хохилогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх албадлагыг.

## **6 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр**

6.1. Энэ хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүрэг**

## **7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн байгууллагын бүрэн эрх**

7.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи бодлого, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;

7.1.2. энэ хуулийн 7.1.1-д заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг улсын төсвийн төсөлд тусгаж, Улсын Их Хуралд оруулах.

7.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хохилогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээг зохион байгуулах;

7.2.2. хамгаалах байранд тавигдах наад захын шаардлагыг тодорхойлох.

7.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх

талаар хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.3.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай<sup>316</sup> хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулах;

7.3.2.гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх.

## **8 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

8.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.1.2.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх;

8.1.3.хууль хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих;

8.1.4.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **9 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи цагдаагийн байгууллагын үүрэг**

9.1.Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох талаар дараахь үүрэг хүлээнэ:

9.1.1.гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авч, бүртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж

<sup>316</sup>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах;

9.1.2. энэ хуульд заасны дагуу хохирогчид түүний эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчид эрхийг нь хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар тайлбарлан өгөх;

9.1.3. хүчирхийлэл үйлдэгчид захиргааны болон эрүүгийн шийтгэл ногдуулж болох тухай сануулах;

9.1.4. шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх;

9.1.5. шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах;

9.1.6. согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх;

9.1.7. хохирогчийг энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах талаар нийгмийн ажилтанд мэдэгдэх;

9.1.8. хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах;

9.1.9. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

## **10 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи нийгмийн ажилтны үүрэг**

10.1. Нийгмийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

10.1.1. тухайн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг цагдаагийн ажилтантай хамтран тогтоох;

10.1.2. хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж, энэ хуулийн 7.3.2-т заасан хөтөлбөрийн дагуу явуулах;

10.1.3. хохирогчид үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын тусалцаатайгаар явуулах;

10.1.4. хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи тайлан мэдээ гаргаж, гэр бүлийн хүчирхийллийн холбоотой мэдээллийн сүлжээ бий болгоход оролцох.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллагын оролцоо**

**11 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллагын оролцоо**

11.1. Хохирогчийг хамгаалах байраар хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах, хохирогчид үзүүлэх үйлчилгээ болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаархи бусад үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

11.2. Төрийн бус байгууллага нь энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг дүрмийнхээ зорилгод нийцүүлэн явуулж болно.

**12 дугаар зүйл. Итгэмжлэгдсэн төлөөлөгч**

12.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.

12.2. Итгэмжлэгдсэн төлөөлөгч дараахь эрх эдэлнэ:

12.2.1. хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, бусад этгээдтэй харилцах;

12.2.2. гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл олж авах, судалгаа явуулах;

12.2.3. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаархи саналаа эрх бүхий байгууллагад оруулах.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл өгөх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ**

#### **13 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл**

13.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ биелүүлж байх үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага, боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

13.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа тухай цагдаагийн буюу нутгийн захиргааны байгууллагад мэдээлж болно.

13.3.Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээд мэдээллээ цахилгаан холбоо, шуудан, мэдээллийн хэрэгслийг ашиглан өгч болно.

13.4.Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээллийг хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн байнга буюу түр оршин сууж байгаа, эсхүл хүчирхийлэл үйлдэгдсэн газрын, хэрэв хохирогч нь эрүүл мэндийн байгууллага, хамгаалах байранд болон хүчирхийлэл үйлдэгч нь энэ хуулийн 5.1.4-т заасан албадан сургалт явуулдаг байгууллагад байгаа бол уг байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хүлээн авч, энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан арга хэмжээ авна.

#### **14 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаархи сум, багийн Засаг даргын үүрэг**

14.1.Тухайн харьяалах нутаг дэвсгэртээ сум, багийн Засаг дарга гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, болзошгүй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

14.1.1.хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны байранд дуудан ирүүлж, шаардлага тавих;

14.1.2.шаардлагатай гэж үзвэл хохирогчийн байгаа гэр, орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, эсхүл боломжтой бол хохирогчийг төрөл, садангийн хүний нь төр хамгаалалтад өгөх;

14.1.3.гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах.

**15 дугаар зүйл. Хохирогчийг хамгаалах арга, түүний нууцыг задруулахгүй байх талаар бусад этгээдийн хүлээх үүрэг**

15.1.Хохирогчийг хамгаалах зорилгоор дараахь аргыг хэрэглэж болно:

15.1.1.хамгаалах байранд хүргэх;

15.1.2.эцэг, эх, төрөл, садны хүн, эсхүл хамт олны нь түр хамгаалалтад өгөх;

15.1.3.шаардлагатай гэж үзвэл хүүхэд асран хүмүүжүүлэх, эсхүл нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх;

15.1.4.энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах.

15.2. Хохирогч нь эрх зүйн асуудлаар хууль зүйн туслалцаа авах, хүчирхийлэл үйлдэгчээс гэрлэлтээ цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, тэжээн тэтгүүлэх, эсхүл хууль тогтоомжийн дагуу эдийн болон эдийн бус гэм хорыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй.

15.3.Нийгмийн ажилтан болон энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан этгээд зөвлөгөө өгөх явцдаа итгэмжлэлээр олж мэдсэн зүйлээ бусдад задруулахыг хориглоно.

15.4.Ажил үүргээ гүйцэтгэж байсантай холбоотой эсэхээс үл хамааран хамгаалах байрны байршлын талаар мэдсэн этгээд энэ тухай бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

**16 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ**

16.1.Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах зорилгоор дараахь арга хэмжээ авч болно:

16.1.1.тусдаа амьдрахыг даалгах;

16.1.2 хамгаалах байранд, эсхүл энэ хуулийн 15.1.3-т заасны

дагуу өөр газарт байгаа хохирогчтэй уулзах болон уулзахаар оролдохыг хориглох;

16.1.3.хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох;

16.1.4.асрамжиндаа байгаа насанд хүрээгүй хүнтэй харилцахыг түр хориглох;

16.1.5.зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах;

16.1.6.шаардлагатай гэж үзвэл согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан эмчилгээ хийлгэх, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан арга хэмжээ авагдсан этгээд хохирогчийг хуулийн дагуу асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ чөлөөлөгдөхгүй.

## **17 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр**

17.1.Хохирогчийн гомдол, цагдаагийн байгууллагын ажилтны, эсхүл өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт, түүнд хавсаргасан нотлох баримтыг үндэслэн хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай<sup>32</sup> хуулийн 82.1.8-д заасны дагуу гаргана.

17.2. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор шүүх нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай гомдол хүлээн авсанаас хойш 24 цагийн дотор энэ хуулийн 16.1.1-16.1.5-д заасан арга хэмжээ авах тухай шийдвэр гаргаж болно.

17.3.Энэ хуулийн 16.1-д заасан хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээг тухайн нөхцөл байдалд нь тохируулж нэг жил хүртэл хугацаагаар авч болно.

17.4.Талууд энэ хуулийн 17.1-д заасан шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй. Ийнхүү гомдол гаргасан явдал тухайн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй.

17.5.Энэ хуулийн 17.1-д заасан шийдвэр нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн талаар захиргааны зөрчлийг хянан

<sup>32</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

шалгах ажиллагаа явуулах, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болон иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

17.6.Шүүх энэ хуулийн 17.1-д заасны дагуу шийдвэрээ гаргахдаа дараахь нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

17.6.1.хохирогчтой удаа дараа хэрцгий хандсан, заналхийлсэн, хүч хэрэглэсэн;

17.6.2.хүчээр бэлгийн харьцаанд оруулсан буюу оруулахыг завдсан;

17.6.3.хохирогчийг төрөл садан, хамт олноос нь тусгаарлаж, сэтгэл санааны хүнд дарамтад оруулсан;

17.6.4.тэжээн тэтгэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн буюу хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж байсан;

17.6.5.согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга буюу удаа дараа хэрэглэж хохирогчийг айдас, түгшүүрт байдалд оруулсан;

17.1.6.гэр бүлийн хүчирхийллийн улмаас энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээдийн хэн нэгний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй байгаа.

## **18 дугаар зүйл.Хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам**

18.1.Шүүхийн шийдвэрт энэ хуулийн 16.1.2, 16.1.4-т заасан арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд уг шийдвэр хүчинтэй байх хугацаанд хохирогч өөрөө буюу насанд хүрээгүй болон иргэний эрх зүйн чадамжгүй хохирогчийн хувьд асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан бол нийгмийн ажилтны зөвшөөрлөөр хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулж болно.

18.2.Шүүхийн шийдвэрт энэ хуулийн 16.1.2, 16.1.4-т заасан арга хэмжээ тусгагдсан бөгөөд зайлшгүй шаардлагаар насанд хүрээгүй этгээдийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах бол нийгмийн ажилтны зөвшөөрлөөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулан уулзуулж болно.

18.3.Энэ хуулийн 18.1,18.2-т заасан уулзалтыг цагдаагийн эрх бүхий ажилтан зохион байгуулж болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**19 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

19.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

**20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

20.1. Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**С.ТӨМӨР-ОЧИР**

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

2006 оны 10 дугаар сарын 30-ний өдөр Улаанбаатар хот

### Дугаар 47

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ 3 дугаар зүйлийн 3.2-т заасан "...хамтын амьдралтай байгаа хүмүүс..." гэдэгт иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч нэг ам бүлд хамт амьдарч байгаа, өрхийн аж ахуйг хамтран эрхэлдэг, эр эмийн харьцаатай этгээдүүд хамаарна.

2. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан "... гэр бүлийн хүчирхийлэл"-ийн "бие мах бодын хэлбэр" гэдгийг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд нөгөө этгээдээ өөрийн эрхшээлд байлгах, гэр бүлийн харилцаанд давамгайл байдал тогтоох зорилгоор хүч хэрэглэн биед нь халдсаныг; "сэтгэл санааны хэлбэр" гэдгийг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдээ айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгөх, доромжлох, нэр төр алдар хүндийг гутаах, ах дүү, хамт олноос нь тусгаарлах, хүсэл зоригийнх нь эсрэг үйлдэл хийлгэхийг албадах, тулган шаардах зэргээр үг яриа, үйл хөдлөлөөрөө сэтгэл санааны дарамтад оруулсныг; "бэлгийн хэлбэр" гэдгийг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдийнхээ бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, хүүхдээ бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан зэрэг үйлдлийг; "эдийн засгийн хэлбэр" гэдгийг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдийнхээ хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарласныг тус тус ойлгоно.

3. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д заасан "... шаардлагатай бусад ажиллагаа..." гэдэгт гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эсэхийг тогтоох

зорилгоор цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулахыг хэлнэ.

4. Мөн зүйлийн 9.1.4-т заасан "...хохирогчийг ... боломжтой бол төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх" гэдэгт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчээс хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор эрх бүхий байгууллагаас хүчирхийлэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авч, шийдвэр гаргах хүртэлх хугацаанд түүнийг төрөл, садангийн хүнтэй нь хамт байлгахыг ойлгоно.

5. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан "итгэмжлэгдсэн төлөөлөгч" гэдэг нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдсон аливаа хэрэг, маргаанд хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагаас итгэмжлэгдсэн этгээд байна.

6. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан "энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан этгээд зөвлөгөө өгөх явцдаа итгэмжлэлээр олж мэдсэн зүйл" гэдэгт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй хүмүүсийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлэх, тэдгээрт хуулийн зөвлөгөө өгөх, эрх зүйн туслалцаа үзүүлэх явцдаа олж мэдсэн хувийн, гэр бүлийн, албан ажлын зэрэг аливаа мэдээллийг хамааруулан ойлгоно.

7. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасан "тусдаа амьдрахыг даалгах" гэдэг нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэж болзошгүй этгээдийг хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүчирхийлэл үйлдэгдэх бололцоо, нөхцөл, шалтгаан арилах хүртэлх хугацаанд хохирогчтой хамт нэг гэрт амьдрахгүй байхыг шүүхээс түүнд үүрэг болгохыг хэлнэ.

8. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан "шийдвэр" гэдэгт мөн хуулийн 16 дугаар зүйлийн аль тохирох заалтыг баримтлан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дүгээр зүйл, 132 дугаар зүйлийн 132.5-д заасан журмаар гаргасан захирамж, шийдвэрийн аль аль нь хамаарна.

Мөн зүйл, хэсэгт заасан этгээдээс гаргасан гомдол, хүсэлтийн дагуу "хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэр"-ийг шүүх энэ зүйлийн 17.2-т зааснаас бусад тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж гаргана.

Гэрлэлт цуцлахтай холбогдсон маргааныг шүүх хянан шийдвэрлэх явцад дээрх гомдол, хүсэлтийг гаргасан бол тухайн хэрэгтэй нь хамт шийдвэрлэнэ.

9. Мөн зүйл, хэсэгт заасан журмаар гаргасан гомдол, хүсэлтийг шүүх хянан шийдвэрлэхдээ хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, гэрчээс мэдүүлэг авах, эд мөрийн баримтад үзлэг хийх зэрэг ажиллагааг тэдний хүсэлтээр явуулж болно. Энэ тохиолдолд уг ажиллагааг цагдаагийн байгууллага урьдчилан явуулсан байхыг шаардахгүй.

10. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан "шийдвэр" гэдгийг Шүүхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан шийтгэвэр гэж ойлгоно.

11. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан журмын дагуу шүүхээс хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахдаа хүчирхийллийн улмаас хохирогчид бодит хохирол учирсан байхыг шаардахгүй.

12. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасан "талууд" гэдэгт хохирогч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, мөн хүчирхийлэл үйлдэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчийг хамааруулан ойлгоно.

13. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасан давж заалдах гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д зааснаар 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гаргаж болно.

Давж заалдах гомдлыг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

14. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.6.4-т заасан "тэжээн тэтгэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн" гэдэгт тэжээн тэтгэгч оршин суугаа хаяг болон ажиллаж буй байгууллага, цалин орлогоо нуух, өөр байгууллага, орон нутагт шилжсэнээ мэдэгдэхгүй байх, тэтгүүлэгчийг тэтгэвэр авахаас татгалзуулах зорилгоор дарамт шахалт үзүүлэх, хуурамч баримт бичиг үйлдэх зэргээр тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүйг ойлгоно.

15. Мөн зүйл, хэсгийн "хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж байсан" гэдэгт гэмт хэрэг, эрх зүйн зөрчил, мөрийтэй тоглоом, садар самуун, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэхэд татан оролцуулсан, мөн хүүхдээ хаях, төөрүүлэх, орон гэрээс нь дайжуулах, биеийг нь үнэлүүлэх, гуйлгачлуулах, хөдөлмөрийг нь зүй бусаар ашиглах, хүүхдийн дэргэд гэр бүлийн гишүүдийг доромжлох, зодох зэргээр хүүхдийн хүмүүжилд муугаар нөлөөлөх үйлдэл хийснийг хамааруулж үзнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

П.ЦЭЦГЭЭ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

### ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

2007 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

#### Дугаар 225

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Жендэрийн тэгш байдлын үндэсний хороонд, хариуцсан чиглэл тус бүрийнхээ арга хэмжээг эрхлэх асуудлын хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, бүх шатны Засаг дарга нар тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв болон гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хүрээнд зохицуулан шийдвэрлэж байхыг Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо, Сангийн сайд Н.Баяртсайханд тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд М.ЭНХБОЛД

Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.ОДБАЯР

Засгийн газрын 2007 оны 225 дугаар  
тогтоолын хавсралт

## **ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)-д заасан хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966), Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979), энэхүү конвенцийн нэмэлт протокол (1999), Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989), Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчилахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол (2000), түүнчлэн Хүний эрхийн талаархи 1993 оны Венийн, Хүн ам ба хөгжлийн асуудлаархи 1994 оны Кайрын, Эмэгтэйчүүдийн байдлын тухай 1995 оны Бээжингийн бага хурлуудын шийдвэрүүдэд тусгагдсан гэр бүлийн гишүүн бүр аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг хангахад чиглэгдэнэ.

### **1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар олсон амжилт**

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаархи асуудлыг төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгайлан тусгаж, холбогдох олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсны зэрэгцээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр шинээр баталсан нь төрөөс энэ асуудлыг ихээхэн анхаарч, хүчин чармайлт гаргаж байгаагийн илрэл юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, хохирогчийг хамгаалах арга, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах журам зэрэг асуудлыг зохицуулсан болно.

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого (2003)-ын баримт бичигт гэр бүлийн харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны эсрэг хүчирхийллийг таслан зогсоох үндсэн чиглэлийг тодорхойлсон байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2004)-т гэр бүлд хууль зүй, сэтгэл зүйн болон амьжиргаагаа дээшлүүлэх зөвлөгөө өгөх, шаардлагатай үед гэр бүлийн гишүүдийг хүчирхийллээс хамгаалах түр байр ажиллуулах зэрэг үйлчилгээний сүлжээ бий болгох нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах нэг үр дүн байхаар заасан.

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003)-т эмэгтэйчүүд гэр бүлийн харилцаанд тэгш оролцоход нь үзүүлэх нөлөөллийг үнэлэх шалгуурыг боловсруулан нэвтрүүлэх, байнгын хүчирхийлэлд өртөж болзошгүй эмэгтэйчүүд, хүүхдийг асран хамгаалах талаар гүйцэтгэх эрх мэдлийн зохих байгууллагуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэхээр заасан.

Жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаар Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо байгуулагдан, орон тооны ажлын албатайгаар тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагууд үүсэн байгуулагдаж, энэ чиглэлээр хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх зэргээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг идэвхтэй дэмжин ажиллаж байна.

Хүчирхийлэлд өртөгсдийг түр хамгаалах байрны зарим үйлчилгээг төрийн бус байгууллага бие даан хэрэгжүүлж, төрийн байгууллага үүнийг нь санхүүжүүлж, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төрийн болон төрийн бус байгууллага хамтдаа тэмцэж эхэлсэн зэрэг нааштай алхмууд хийгдэж байна.

## **1.2. Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ, шаардлага**

Хүн амьдралынхаа анхдагч орчин болох гэр бүлдээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид, эрүүл саруул, аюулгүй орчинд эрх тэгш амьдрах эрхтэй бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн ноцтой зөрчил мөн.

Гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох нь хохирогчийн аюулгүй байдлыг хангахаас гадна хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхэд зохих нөлөө үзүүлэх болно. Хүчирхийлэл бүхий нөхцөлд байгаа хохирогчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг нэн тэргүүнд анхааран үзэж гэр бүлийн хүчирхийллийн уршигт үр дагаврын нэг болох эрүүл мэнд, эрхтэн тогтолцооны бүрэн бүтэн байдал алдагдах, ойр дотны хүмүүсийнхээ гарт амь үрэгдэх явдлаас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Гэр бүлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, сэтгэл засал, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хувь хүнийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах, гэр бүлийн нөхцөл байдалд тохирсон тусламж, дэмжлэг үзүүлэх зэрэг нийгмийн ажлын үйлчилгээг гэр бүлийн гишүүдийн нас, хүйс, хөгжлийн онцлогийг харгалзсан өвөрмөц хэрэгцээнд тохируулахын зэрэгцээ тэдний нийтлэг эрх ашигт суурилсан цогц үйлчилгээг хүртээмжтэйгээр, мэргэжлийн түвшинд үзүүлэх шаардлагатай юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинээр батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа боловч уг хууль батлагдсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт ороогүйн улмаас эрх зүйн иж бүрэн зохицуулалт бүрдээгүй байна.

Хууль тогтоомжийн харилцан уялдааг ханган, бие биеэ дэмжсэн цогц зохицуулалт бий болгох нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүхий л үйл ажиллагааны хүрээнд үр дүнгээ үзүүлэх юм. Иймээс эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн болон хувь хүний ухамсар, хүмүүжил, үзэл хандлагатай шууд хамааралтай бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн зарим үйлдлийг нийгмийн аюултай үзэгдэл бус зөвхөн тухайн гэр бүлийн дотоод асуудал, гарцаагүй хэрэглэх арга мэтээр хүлээн авах явцуу ойлголт нийгэмд тодорхой хэмжээнд оршоор байна.

Эрх нь зөрчигдөж байгааг хохирогч тэр бүр ухамсарлахгүй, гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр, хүчирхийлэгчид хүлээлгэх хариуцлагын талаархи мэдлэг дутмаг байна. Гэр бүлийн хүчирхийлэлгүй орчин бүрдүүлэх гол хүчин зүйл нь өрх гэрийн ёс заншил, өв уламжлал, үнэт зүйлийг эрхэмлэх, үүрэг, хариуцлагаа

ухамсарлах, бие биенээ хүндлэх замаар гэр бүлийн гишүүдийн ухамсар, соёлыг дээшлүүлэхэд оршино.

Иймээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг өргөн хүрээнд авч үзэн эцэг, эхийн үүрэг, хариуцлага болон хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг сайжруулах, гэр бүлийн боловсрол олгох, нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх чиглэлээр нухацтай анхааран ажиллах шаардлага тулгарч байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаар гол үүрэг хариуцлага хүлээх төрийн байгууллагуудын тусгай үүрэг хариуцлагыг тодорхой заасан хэдий ч гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүтэц, механизм хангалттай бүрдээгүй, энэ төрлийн хүчирхийлэл бий болж байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах арга зүй, чадавхи дутмаг, үндэсний бусад төрөлжсөн хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгүүдтэй уялдуулах нэгдмэл удирдлага, зохицуулалт бүрдээгүйгээс салбар хоорондын ажлын уялдаа холбоо хангагдаж чадахгүй байгаа тул гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын явуулж байгаа үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих асуудал чухлаар тавигдаж байна.

Хүчирхийллийн тархалтын талаархи судалгаа, статистикийн мэдээ баримтжуулалт хангалтгүй байгаа нь хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны хүчин чармайлтыг сааруулахад нөлөөлж байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлыг бүртгэх тодорхой журам, стандартыг цагдаа, шүүх, эрүүл мэндийн байгууллагад мөрдүүлж, мэдээллийг тогтмол цуглуулж, эргэн мэдээлэх мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх талаар хамтран ажиллах нь үр дүнтэй юм.

Хуулийн болон эрүүл мэндийн байгууллага, нийгмийн ажилтнуудын гэр бүлийн хүчирхийллийн хохирогчидтой ажиллах ур чадвар дутмаг, зэрэг хандлага төлөвшөөгүй, чирэгдэл ихтэй зэрэг нь хохирогчид холбогдох байгууллагуудад хандахгүй, гэр бүлийн хүчирхийлэл дарагдан өнгөрөх нөхцөлийг бүрдүүлдэг тул хүний нөөцийг чадавхижуулах хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэл нь нийгмийн хурц асуудал болохын хувьд түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн оролцооноос гадна иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн хүчин чармайлт нэн чухал болно.

## **Хоёр. Хөтөлбөрийн эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, үндсэн зарчим**

2.1. Хөтөлбөрийн эрхэм зорилго нь гэр бүлийн гишүүд хүчирхийллээс ангид амар амгалан, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн харилцаанд хүчирхийллийн бус арга, хэлбэрийг нэвтрүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг хангаж, гэр бүлийн хүчирхийлэл үүсэн гарч байгаа шалтгаан нөхцөл болон нийгмийн сөрөг үзэгдлийг арилгахад оршино.

2.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь хоорондоо харилцан уялдаа бүхий дараахь тэргүүлэх чиглэлтэй байна.

### **2.2.1. Хамгаалах**

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэний дараа өртөх эрсдэл, болзошгүй аюул заналаас хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хүний эрхэд суурилсан эрх зүйн таатай орчин, бодлого, удирдамжийг боловсруулан хөгжүүлэх.

### **2.2.2. Үйлчилгээ үзүүлэх**

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн хэрэгцээ, сонирхол, насанд тохирсон цогц үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх нийгмийн ажлын үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг сайжруулан хөгжүүлэх.

### **2.2.3. Урьдчилан сэргийлэх**

Олон нийтэд урт болон богино хугацааны боловсрол олгох албан ба албан бус хөтөлбөрөөр дамжуулан гэр бүлийн хүчирхийллийг эсэргүүцэх, үл тэвчих ойлголт, мэдлэг, үүрэг хариуцлагыг дээшлүүлж, зан үйл, хандлагын эерэг өөрчлөлтийг бий болгохыг дэмжих.

2.3. Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

### 2.3.1. Аюулгүй байдлыг дээдлэн хангах зарчим

Гэр бүлийн гишүүд аюулгүй орчинд, айдасгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг тэргүүн ээлжинд анхаарч үзнэ.

### 2.3.2. Нийтлэг эрх, онцлог хэрэгцээнд суурилах зарчим

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэр бүлийн бусад гишүүдийн нийтлэг эрх ашиг болон онцлог хэрэгцээнд нийцсэн байна.

### 2.3.3. Салбар хоорондын зохицуулалтаар хангах зарчим

Харилцан хамааралтай, уялдаа холбоотой нь авч үзсэн нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэхдээ салбар хоорондын зохицуулалтаар хангана.

### 2.3.4. Оролцооны зарчим

Хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг бүхий л үйл ажиллагаа нь гэр бүлийн гишүүд болон олон нийтийн оролцоонд тулгуурлана.

## **Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилт, хүрэх үр дүн, арга хэмжээ**

### **А. Гэр бүлийн хүчирхийллийг шуурхай таслан зогсоох механизмын хүрээ**

#### **Зорилт 1**

Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох механизмыг бий болгон хөгжүүлнэ.

#### **Хүрэх үр дүн 1.1**

Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэнд мэргэжлийн түвшинд шуурхай хамгаалагдах баталгаа бүрдсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.1.1. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах тухай шүүхийн шийдвэрийг шүүхээс нэн даруй гаргах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

1.1.2. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх механизмыг тодорхой, боловсронгуй болгон хөгжүүлэх.

Хүрэх үр дүн 1.2

Гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг шуурхай таслан зогсоох үйл ажиллагаа нь стандартчилагдан журамлагдсан байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.2.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хохирогч, гэр бүлийн бусад гишүүдтэй ажиллах удирдамж, стандартыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэгч байгууллагууд дангаараа болон хамтран боловсруулж, мөрдөх;

1.2.2. Алслагдсан бүс нутгийн ард иргэд болон үндэстний цөөнхийн дунд гарч буй гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний онцлог хэрэгцээг судалсны үндсэн дээр холбогдох удирдамжийг боловсруулж мөрдүүлэх.

Хүрэх үр дүн 1.3

Хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг таслан зогсоох мэргэжлийн үйлчилгээг үндэсний хэмжээнд шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлдэг болсон байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.3.1. Хохирогчийн аюулгүй байдлыг хангасан түр хамгаалах байрны сүлжээг үндэсний хэмжээнд бий болгох ажлыг зохион байгуулах;

1.3.2. Гэр бүлд мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа өгөх зорилгоор 24 цагийн утасны үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох;

1.3.3. Нийгмийн ажил, сэтгэл зүй, эрх зүйн үйлчилгээг нэг цэгийн буюу хамтарсан багийн хэлбэрээр хүргэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

1.3.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх асуудлыг иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор судалж, турших.

## Б. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажлын үйлчилгээний хүрээ

### Зорилт 2

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид болон тэдний гэр бүлд зориулсан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.

### Хүрэх үр дүн 2.1

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн ажлын цогц үйлчилгээг үзүүлэх төр ба иргэний нийгмийн байгууллагын салбар хоорондын сүлжээт тогтолцоо бий болж, хамтран ажиллах чадавхи, бүтэц, зохион байгуулалтын механизм бэхжиж, боловсронгуй, тодорхой, хүртээмжтэй болно.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.1.1. Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлыг эрхлэх төрийн бус байгууллага, ажилтныг зохих шалгуур үзүүлэлт, нөхцөл, болзлын дагуу сонгон шалгаруулах тогтолцоог бий болгож, эдгээр байгууллага, ажилтны ажлын байрны тодорхойлолт, эрх, үүргийг баталгаажуулан магадлан итгэмжлэх;

2.1.2. Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах замаар чадавхижуулж нийгмийн амьдралд оролцох оролцоог нь нэмэгдүүлэх;

2.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажлын үйлчилгээний үр нөлөөний судалгааг хийх.

## Хүрэх үр дүн 2.2

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүчирхийллээс ангижрах урт, богино хугацааны нийгэм, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээг хүртэх таатай орчин бүрдсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.2.1. Хохирогчид шаардлагатай урт, дунд ба богино хугацааны нийгмийн ажлын үйлчилгээг ялгамжтайгаар тодорхойлох талаар судалж, удирдамж, заавар боловсруулан үндэсний хэмжээнд нэгдсэн журмаар мөрдүүлэх механизм бий болгох;

2.2.2. Хохирогч, тэдний гэр бүлийнхэнд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийг давтан бэлтгэх, их, дээд сургуулийн хичээлд нэмэлт хөтөлбөр боловсруулж оруулах талаар судалж, шийдвэрлэх.

## Зорилт 3

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх нийгмийн ажлын үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлнэ.

## Хүрэх үр дүн 3.1

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх замаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид эерэг зан үйл төлөвшүүлэх арга, хэлбэр тодорхойлогдож, тодорхой загвар бий болсон байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1.1. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;

3.1.2. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сэтгэл засал, зөвлөгөө өгөх, чадавхижуулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжин хамтарсан төсөл хэрэгжүүлэх.

## Зорилт 4

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн эрх ашигт нийцсэн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлнэ.

#### Хүрэх үр дүн 4.1

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд тусгайлсан цогц үйлчилгээг хүргэж, хүчирхийллээс хамгаалах нөхцөл боломж бүрдэнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1.1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тархац, тандалтын талаархи судалгааг тогтмол хийх;

4.1.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг бууруулахын тулд уг асуудлын учир шалтгаан, хүрээ, нийгэм, эрх зүйн үйлчилгээг хэрхэн хүртэж байгаа талаархи мэдээлэл судалгааны санг үндэсний хэмжээнд бүрдүүлэх;

4.1.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, өмгөөлөгч, цагдаа, прокурор, шүүгч, багш гэх мэт холбогдох мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэж, хүний нөөцийг чадавхижуулах;

4.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд зохицуулан нийгмийн ажлын болон нөхөн сэргээх сэтгэл зүйн үйлчилгээний удирдамж, зааврыг тусгайлан боловсруулах, гарын авлага, зөвлөмжөөр хангах.

#### Зорилт 5

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлнэ.

#### Хүрэх үр дүн 5.1

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх замаар гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл бүхий бүлгийг тусгайлан хүчирхийллээс хамгаалах нөхцөл бүрдэнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн албан хаагч болон нийгмийн ажилтан тухайн гэр бүлд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа эсэхийг тодруулж, тэдэнд шаардлагатай нийгмийн

ажлын үйлчилгээг тусгайлан үзүүлэх арга хэмжээ авах;

5.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнд нийцсэн нийгмийн үйлчилгээний удирдамж, стандартыг боловсруулж мөрдүүлэх.

## В. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчны хүрээ

### Зорилт 6

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлнэ.

### Хүрэх үр дүн 6.1

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж харилцан уялдаж, боловсронгуй болсон байна.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ:

6.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хохирогчийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэх зэрэг шаардлагын үүднээс зарим нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

6.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний, Захиргааны хариуцлагын, Иргэний бүртгэлийн болон Тэмдэгтийн хураамжийн зэрэг бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

6.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх олон улсын баримт бичгүүдийг судалсны үндсэн дээр Монгол Улс нэгдэн орох талаар санал, дүгнэлт боловсруулан шийдвэрлүүлэх.

### Хүрэх үр дүн 6.2

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулийн талаар нэгдсэн ойлголт бий болж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил тогтмолжсон

байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

6.2.1. Холбогдох хуулиудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор тогтмол зохион байгуулах;

6.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн хэрэгжилтийн байдал, цаашид анхаарах асуудлын талаархи зөвлөмж, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

6.2.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулийн шинжлэх ухааны тайлбар гаргаж нийтийн хүртээл болгох арга хэмжээг зохих байгууллагуудын оролцоотой хэрэгжүүлэх.

Г. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажиллагааны хүрээ

Зорилт 7

Гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих нийгмийн ухамсрыг дээшлүүлнэ.

Хүрэх үр дүн 7.1

Гэр бүлийн гишүүд бие биенээ хүндэтгэх, хүчирхийлэлгүй аж төрөх хандлага нийгэмд тодорхой хэмжээнд төлөвшинэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

7.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар олон нийтэд зориулсан ухуулга сурталчилгааны стратегийг боловсруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлэх;

7.1.2. Олон нийтэд зориулсан албан бус сургалт, сурталчилгааны ажлыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулах;

7.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ойлголт, мэдлэг,

хандлага, ухамсрыг дээшлүүлэх, энэ талаархи хууль тогтоомжийг сурталчлахад зориулсан зөвлөмж, гарын авлага, материалуудыг боловсруулах чиглэлээр төрөл бүрийн мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн баг бүрдүүлэн ажиллах;

7.1.4. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг архидан согтуурахтай тэмцэх үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх;

7.1.5. Гэр бүлийн харилцааны болон гэр бүлийн хүчирхийллийн тархалтын судалгааг хийх;

7.1.6. Монгол гэр бүлийн дэвшилтэт өв уламжлал, ёс заншлыг өвлүүлэн гэр бүлийн үнэлэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах.

## Хүрэх үр дүн 7.2

Хамт олон, хөрш зэрэг нийгмийн бичил хэсэг нь хүчирхийлэлд өртөгсдөд мэдрэмжтэй, хариуцлагатай хандах ухамсар төлөвшинө.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

7.2.1. Хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудлаар зорилтот бүлэг, олон нийтэд зориулсан гарын авлагыг бэлтгэн түгээх;

7.2.2. Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг сонгон хэрэгжүүлэх;

7.2.3. Шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад хүчирхийлэл, жендэрийн талаархи судалгааны үр дүн, зөвлөмжийг танилцуулах, сурталчлах зэрэг арга замаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хандлагыг төлөвшүүлэх;

7.2.4. Шинээр гэр бүл бологсдод зориулан гэр бүлийн үүрэг, хариуцлага болон жендэрийн харилцааны чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

7.2.5. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт гэр бүлийн хөгжил, хүчирхийлэлгүй аж төрөх харилцааны асуудлыг тусгах.

### Хүрэх үр дүн 7.3

Гэр бүлд хүний эрхийг хүндэтгэн үзэх хандлага төлөвшин гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

7.3.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид эерэг зан үйл төлөвшүүлэх зорилго бүхий ухуулга, сурталчилгаа, сургалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

7.3.2. Хохирогчийг чадавхижуулахад чиглэсэн ухуулга, сурталчилгаа, сургалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

Д. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үндэсний чадавхийн хүрээ

### Зорилт 8

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд салбар хоорондын зохицуулалтыг хангах үндэсний чадавхийг бэхжүүлнэ.

### Хүрэх үр дүн 8.1

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаархи салбар хоорондын зохицуулалтыг хангахад чиглэсэн болон мэргэшсэн үндэсний тогтолцоо бүрдсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

8.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг дагнан хариуцаж, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий нэгжийг Жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны бүтцэд үүсгэн байгуулах;

8.1.2. 8.1.1-д заасан нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх орон тооны бүтцийг Жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны ажлын албанд бий болгох;

8.1.3. Гэр бүлийн хэргийг шийдвэрлэх чиглэлээр шүүгчдийг мэргэшүүлэх, дагнасан шүүхийг бий болгох асуудлыг судлах;

8.1.4. Цагдаагийн байгууллагын бүтцэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийг бий болгох асуудлыг судлах.

#### Зорилт 9

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр салбарын болон орон нутгийн хооронд мэдээлэл байнга солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

#### Хүрэх үр дүн 9.1

Мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээ, материалыг холбогдох эх сурвалжаас цуглуулах, хэрэглэгчдэд мэдээлэх боломжтой болсон байна.

#### Хэрэгжүүлэх арга хэмжээ:

9.1.1. Гэр бүлийн хүчирхийллийн талаархи мэдээллийг цуглуулж сан бүрдүүлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох замаар мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгон хөгжүүлэх;

9.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд шаардлагатай маягт, бүртгэлийг эрх бүхий байгууллагуудаас баталж мөрдүүлэх;

9.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенциудын хороодоос өгсөн зөвлөмж болон түүнийг хэрэгжүүлэх ажлын үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх ажлыг тогтмолжуулах.

#### Зорилт 10

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.

#### Хүрэх үр дүн 10.1

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар төрийн болон иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирч,

хүний нөөцийн чадавхи дээшилнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

10.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйлчилгээ үзүүлэх шүүгч, прокурор, цагдаа, өмгөөлөгч, сэтгэл зүйч, эрүүл мэнд, боловсролын байгууллагын ажилтан болон салбарын бодлого боловсруулагч мэргэжилтнүүдэд хууль тогтоомжоор хүлээлгэсэн нийтлэг болон тусгай үүрэгтэй нь холбогдуулан цогц сургалтыг тогтмол зохион байгуулах;

10.1.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаархи судалгааны ажлыг хөгжүүлэн, эрдэмтэд, судлаачдыг өргөнөөр оролцуулах;

10.1.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаархи төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, санхүүжүүлэх арга хэрэгслийг бүрдүүлэх;

10.1.5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажил, үйлчилгээний чанарт хяналт тавьж, үр дүнг нь үнэлж дүгнэн, сайжруулах нэгдсэн стандарт боловсруулж мөрдөх;

10.1.6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн санал санаачилгыг дэмжин, хөрөнгө нөөцийг бүрдүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.

## **Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

4.1. Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороонь хөтөлбөрийн хэрэгжилтийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурал, Засгийн газраас батлан гаргасан бусад хөтөлбөртэй уялдуулан зохицуулна.

4.2. Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор

хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр салбарын яамд, холбогдох бусад байгууллагын хийх ажлыг тусгасан үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжилтийг удирдан зохион байгуулна.

4.3. Монгол Улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын ба бусад түншлэлийн байгууллага, иргэдтэй энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

4.5. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого болон Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилттой нийцүүлэн улс орны нийгэм, эдийн засгийн нөөц боломж, хамтын ажиллагааны хүрээнд үе шаттайгаар зохион байгуулна.

4.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа хүн ам, нийгмийн бүлгүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөгжил, нийгмийн халамж, хамгаалал, өсвөр үеийн оролцоо, хүний эрх, гэр бүлийн хөгжлийг дэмжсэн бусад хөтөлбөр, төсөлтэй уялдуулан зохицуулна.

## **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт, тайлан мэдээлэл**

5.1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт болон Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын хугацаатай уялдуулан хөтөлбөрийг 2007-2015 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

5.1.1. Эхний үе шат нь 2007-2009 оныг хамаарах бөгөөд энэ үеийн үнэлгээгээр хөтөлбөрт зарим нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.1.2. Хоёр дахь үе шат нь 2010-2012 оныг хамаарах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн завсрын үнэлгээг хийж, цаг үеийн нөхцөл байдалд тохируулан хөтөлбөрт зарим нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.1.3. Гурав дахь үе шат нь 2013-2015 оныг хамааруулан хэрэгжүүлж, хөтөлбөрийн эцсийн үр дүнг тооцно. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг үндэсний болон орон нутгийн хэмжээнд

нэгтгэн гаргаж, олсон амжилт, туршлага, авсан сургамжид үнэлгээ өгнө.

5.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.2.1. Улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

5.2.2. Хандивлагч орон болон олон улсын байгууллагын тусламж, хандив;

5.2.3. Төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө;

5.2.4. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

5.3. Хөтөлбөрийн санхүүжилт:

5.3.1. Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаанд зориулсан төвлөрсөн арга хэмжээний санхүүжилтийг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

5.3.2. Санхүүжилтийг Жендэрийн тэгш байдлын Үндэсний хорооны ажлын албаны төсөвт тусгана.

5.4. Төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, хандивлагч орны шугамаар олгосон хандив, тусламж, түүнчлэн гэр бүл, олон нийт, иргэдийн үүсгэл санаачилга, оролцоотойгоор хуримтлуулсан хөрөнгийн эх үүсвэртэй холбоотой хөтөлбөрийн санхүүжилтийн тайланг сум, дүүрэг, аймаг, нийслэл болон үндэсний хэмжээнд тогтмол мэдээлж, хандивлагч, гүйцэтгэгчийн үйл ажиллагааг жил тутам шударгаар үнэлэн урамшуулах ажлыг зохион байгуулна.

## **Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1. Яамд болон бусад байгууллага нь энэхүү хөтөлбөрийн холбогдох арга хэмжээ тус бүрийнхээ хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороонд хүргүүлснээр тус хороо хөтөлбөрт бүхэлд нь нэгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

6.2. Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг жил бүр Засгийн газарт танилцуулж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар

холбогдох байгууллагуудад чиглэл өгнө.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгмийн байгууллага, иргэдийг өргөнөөр оролцуулна.

#### Хавсралт 4.

### НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2009 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 128/188

Улаанбаатар  
хот

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай  
хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.7 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг болон Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


Нэг. Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох үнэлгээний маягыг нэгдүгээр хавсралтаар, Нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох зааврыг хоёрдугаар хавсралтаар, Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлж эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах загварыг гуравдугаар хавсралтаар, Хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээний маягыг дөрөвдүгээр хавсралтаар, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн бүртгэлийн маягыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Нийгмийн ажилтны ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтод гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх, холбогдох судалгаа, тайланг нэгтгэн гаргах үүргийг тусган боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Т.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

Гурав. Цагдаагийн ажилтны ажил үүргийн хуваарьт цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлж эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах, хохирогчид үйлчилгээ үзүүлэх, судалгаа, тайланг нэгтгэн гаргах үүргийг тусгахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /хошууч генерал Д.Сандаг-Очир/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн болон хүчирхийлэл үйлдэгчийн судалгаа, тэдгээрт төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлсэн үйлчилгээний талаархи тайлан, мэдээг багтаасан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийн санг бий болгох ажлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт үүрэг болгосугай.





**НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ ХИЙХ АЮУЛЫН ТҮВШИНГИЙН ЗЭРГИЙГ ТОДОРХОЙЛОХ ҮНЭЛГЭЭГ ХИЙХ ЗААВАР**

Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ гэдэг нь:

1. Гэр бүлийн хүчирхийллийн түүхийг бичсэн үйл явцын тэмдэглэл юм.
2. Үйлчлүүлэгчид учирч болох аюулын түвшинг үнэлэх, хохирогч амь насаа алдахаас хамгаалах, анхааруулга өгөх үнэлгээний хуудас юм.
3. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийн эрсдэлийг тодорхойлох, түүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуудас юм.
4. Нийгмийн орчны зүгээс хохирогч туслалцаа дэмжлэг авч чадахгүй байх эрсдэлээс хамгаалах хуудас юм.
5. Нөхцөл байдлын үнэлгээ хийхээс өмнө үзүүлсэн үйлчилгээ болон үнэлгээ хийснээс хойш ямар үйлчилгээ, дэмжлэг хохирогчид хэрэгтэйг тодорхойлсон дэмжлэгийн хуудас юм.
6. Хуулиар үүрэг хүлээсэн төрийн албан хаагчид, төрийн бус байгууллагын оролцоог хангах захиргааны хуудас юм.
7. Шүүх, цагдаа, шаардлагатай бусад байгууллагын өмнө нотлох баримт юм.
8. Мэргэжлийн шинжээчийн дүгнэлт юм.

Гэр бүлийн хүчирхийллийн үйлчлүүлэгчийн нууцын тухай

Гэр бүлийн хүчирхийллийн үйлчлүүлэгчийн нууцыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 15.3 болон Монгол Улсын Хувь хүний нууцын тухай хуулиар чандлан хадгалах ба үйлчлүүлэгчийн хүчирхийллийн тухай мэдээлэл, эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг хийсэн материал, үйл явцын тэмдэглэлийг цоожтой шүүгээнд найдвартай хадгална.

Хохирогчид үзүүлэх үйлчилгээг тасралтгүй байх нөхцөл бүрдүүлэх нь:

1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээг хийх, үйлчилгээг үзүүлэх зардлыг улсын төсөвт суулгах нь үйлчилгээг тасралтгүй байх нөхцлийг хангана.
2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан, ерхийн эмнэлгийн ажилтан, хамран сургах тойргийн нийгмийн ажилтны ажил үүргийн хуваарь болон жилийн ажлын үр дүнгийн гэрээнд заавал тусгасан, үр дүнг тооцдог, урамшуулах, хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх хэрэгтэй юм.

Ийнхүү, гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдэлийн түвшинг тодорхойлохдоо тухайн эрсдэл байгаа тохиолдолд "тийм" гэсэн хариултын урд чагт тэмдэг тавьж нэг оноо өгнө. Харин тухайн эрсдэлд өртөөгүй буюу тийм нөхцөл байдал үүсээгүй тохиолдолд "үгүй" гэсэн хариултын өмнө чагт тавьж тэг оноо өгнө. Ингэж эрсдэлийн хүчин зүйлст оноо өгснөөрөө тэдгээр эрсдэлийн түвшинг тодорхойлох боломжтой болно.

### **Гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдэлийн түвшинг үнэлэх аргачлал**

*Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид аюул учрах эрсдэлийн түвшин бага гэдэгт хэрвээ хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдэлүүд дангаараа 0-4 оноо болсон эсвэл нийгмийн орчны эрсдэлүүд дангаараа 0-3 оноотой нөхцөл байдлыг багтааж байвал хохирогчид учрах аюулын эрсдэлийн түвшин харьцангуй бага гэж үнэлэхийг санал болгож байна. Гэхдээ, гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, хүчирхийлэл үйлдэгч гадны биет тухайлбал хутга мэс, галт зэвсэг хэрэглэдэг, мөн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдсан буюу бие махбодид хүнд гэмтэл учирсан нь нотлогдсон тохиолдолд нөхцөл байдлыг онцгойлон үзэж тухайн эрсдэлүүдийг аюул багатай гэж үзэхгүй. Энэ тохиолдолд эрсдэлийн хүчин зүйлсийн дан ба хавсарсан нөлөөллийг нарийвчлан судлаж аюулын түвшинг дунд зэрэг буюу түүнээс өндөр эрсдэл байх магадлалтай тухай дахин тандах хэрэгтэй болно.*

Гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдэлийн түвшин бага тохиолдолд дараах хариу арга хэмжээг авна. Үүнд: Хохирогчийн шийдвэрийг нэн түрүүнд харгалзан үзэх ба нийгмийн хамгаалал, Халамж, эрүүл мэндийн үйлчилгээг санал болгоно. Нийгмийн ажилтан болон хамтарсан багийн бусад гишүүд хохирогч өөрийн аюулгүй байдлаа хангах төлөвлөгөө боловсруулахад нь тусална. Нөгөө талаас орон нутгийн нийгмийн үйлчилгээний байгууллагын ажилтнууд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж хохирогчийг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдах боломжоор хангана.

*Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид аюул учруулах эрсдэлийн түвшин дунд зэрэг гэдэгт хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдэлүүд ба нийгмийн орчны эрсдэлүүдийн нийлбэр оноо 5-11 оноо болсон тохиолдолд хохирогчид учрах эрсдэлийн аюулын түвшинг дунд зэрэг гэж үнэлнэ. Харин гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, хүчирхийлэл үйлдэгч гаднын биет буюу галт зэвсэг хэрэглэдэг, хохирогч нэн даруй хүчний байгууллагын буюу нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй, эсвэл архаг хууч өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэйин улмаас хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай гэдэг нь тогтоогдсон тохиолдолд нөхцөл байдлыг онцгойлон үзэж зөвхөн нийлбэр оноогоор аюулын түвшинг дунд зэрэг гэж үзэж болохгүй. Магадгүй, тухайн тохиолдлыг хохирогчид учрах аюулын эрсдэлийн*

түвшин өндөр гэж үзэн бусад хавсарсан нөлөөллийг дахин нарийвчлан судлах шаардлагатай болно.

Хохирогчид учруулах эрсдэлийн түвшин дунд зэрэг гэдгийг тогтоосон үед хохирогчийн хүсэлтийг харгалзан гэрт нь буцаах буюу хүчирхийлэл үйлдэгчтэй хамт байх шийдвэрийг нь хүндэтгэж үзнэ. Гэхдээ орон нутгийн цагдаагийн байгууллага ба нийгмийн үйлчилгээний байгууллагын ажилтнууд хохирогчийн нөхцөл байдлыг хяналтандаа авах хариу арга хэмжээ авна. Нөгөө талаас ах дүү, төрөл садан болон хөршийн хамгаалалтыг санал болгоно. Нийгмийн ажилтан болон хамтарсан багийн бусад гишүүд хохирогч өөрийн аюулгүй байдлаа хангах төлөвлөгөө боловсруулахад нь тусална.

*Хохирогчид учрах аюулын эрсдэлийн түвшин өндөр* гэдэгт хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдэлүүд нь нийгмийн орчны эрсдэлүүд ба хохирогчийн амь насыг хөнөөх магадлал бүхий эрсдэлүүдийн аль нэгэнтэй хавсарсан эсвэл гурван бүлгийн эрсдэлүүд бүгд хавсарсан хэлбэрээр зэрэг илэрсэн тохиолдлыг тус тус багтаана. Өөрөөр хэлбэл, гурван бүлэг хүчин зүйлсийн нийлбэр оноо нь 12 буюу түүнээс их болсон тохиолдолд хохирогчид учрах аюулын эрсдэлийн түвшинг өндөр буюу аюултай гэж үнэлнэ.

Гэр бүлийн хүчирхийллийн аюулын эрсдэлийн түвшин өндөр тохиолдолд хохирогчийг шууд хөндлөнгийн хяналт, хамгаалалтанд авах ба хүчирхийлэл үйлдэгчид шүүхээр эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтийг шүүхэд гаргах зэрэг хариу авах арга хэмжээ авна. Мөн хохирогчийн хүсэлтийг харгалзан хуулийн байгууллагаар шийдвэрлэх асуудлуудыг тогтооно. Хохирогчийг нэн даруй хамгаалах арга хэмжээг төлөвлөж холбогдох нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэндийн байгууллагуудтай холбон зуучлана.

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН  
ЭРСДЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ  
ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ**

**А. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЕРӨНХИЙ  
МЭДЭЭЛЭЛ**

1. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагын нэр: .....
2. Бүртгэлийн дугаар No .....
3. Үнэлгээ хийсэн .....он ..... сар ..... өдөр
4. Үнэлгээ хийсэн нийгмийн ажилтны овог, нэр .....
5. Үнэлгээ хийсэн газар
  - Үйлчилгээ үзүүлж буй байгууллага
  - Үйлчлүүлэгчийн гэр
  - Хамгаалах байр
  - Бусад.....
6. Үнэлгээний ерөнхий дүн (Энэ хэсгийг үнэлгээний эцэст бөглөнө )
  - Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн даруй хангахад туслах (хамгаалах байртай холбох, хувийн аюулгүйн төлөвлөгөө зохиох)
  - Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн даруй хангахууль эрх зүйн туслалцаатай холбох (хуулийн зөвлөгөө өгөх, цагдаагийн байгууллагын хойшлуулшгүй ажиллагааг хийх, аюулгүй байдлаа хангахад нь туслалцаа үзүүлэх, шинжээчийн дүгнэлт гаргах, аюулын зэргийн түвшинг цагдаагийн ажилтантай хамтран тогтоох, итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу өмгөөлөгч сонгоход нь туслах гэх мэт)
  - Байгууллагын нийгмийн ажлын үйлчилгээнд хамруулах
  - Орон нутгийн нийгмийн үйлчилгээний бусад байгууллагатай холбох
7. Үйлчлүүлэгчид аюул учрах эрсдлийн түвшин (Энэ хэсгийг үнэлгээний эцэст бөглөнө )
  - Үйлчлүүлэгчид аюул учрах эрсдэл өндөр
  - Үйлчлүүлэгчид аюул учрах эрсдэл дунд зэрэг
  - Үйлчлүүлэгчид аюул учрах эрсдэл бага
8. Үнэлгээний ерөнхий дүгнэлт (Нөхцөл байдлын үнэлгээнд

тулгуурласан шинжээчийн дүгнэлт, санал зөвлөмжийн гол агуулгыг энэ хэсэгт тусгана. Харин үнэлгээний явцад илэрсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох бүхий л нотолгоо баримт бүхий мэдээллийг энэхүү нөхцөл байдлыг үнэлгээний үндсэн бүлэгт буюу дараах ..... хуудсанд дэлгэрэнгүй тусгах болно)

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Нөхцөл байдлын үнэлгээг хамтран хийсэн ажилтны албан тушаал

..... Гарын үсэг .....

.....он..... сар..... өдөр

## Б. ХОХИРОГЧ БА ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Б.1 Хохирогчийн тухай мэдээлэл	Б.2 Хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээлэл
Овог:..... Нэр:..... Хүйс:..... Төрсөн он сар өдөр:..... Оршин суугаа хаяг:..... Холбоо барих утас:.....	Овог:..... Нэр:..... Хүйс:..... Төрсөн он сар өдөр:..... Оршин суугаа хаяг:..... Холбоо барих утас:.....
Ам бүлийн байдал:	Ам бүлийн байдал:
Хөдөлмөр эрхлэлтийн байдал:	Хөдөлмөр эрхлэлтийн байдал:
Амьдарч буй байр/ орон сууц/ гэрийн байршил ба нөхцөл:	Амьдарч буй байр/ орон сууц/ гэрийн байршил ба нөхцөл:
Хохирогчийн тодорхойлсон түүнд тулгарч буй асуудал, бэрхшээлүүд	Хүчирхийлэл үйлдэгч хохирогчид тулгарч буй асуудалтай ямар холбоотой болох
Хохирогчийн тухай болон түүнд тулгарч буй асуудлыг сонсох явцад хийсэн нийгмийн ажилтны ажиглалт тэмдэглэл	Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээлэх явцад хийсэн нийгмийн ажилтны ажиглалт тэмдэглэл

## Г. ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ТҮҮХ

1. Хамт амьдарч эхэлсэн буюу гэр бүл болсон .....он.....(сар)  
.....
2. Хамт амьдарсан хугацаа.....
3. Хүчирхийлэл эхэлсэн ..... он ..... (сар)
4. Хүчирхийлэл ямар хэлбэрээр эхэлсэн ба одоо ямар хэлбэрийн хүчирхийлэл үйлдэгддэг (бие махбодийн, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн, хавсарсан)  
.....  
.....  
.....
5. Хүчирхийллийн хэлбэр, давтамж хэрхэн өөрчлөгдсөн  
.....  
.....
6. Хүчирхийлэл ямар давтамжтай явагддаг (нэг хүчирхийллээс дараагийн хүчирхийлэл болох хооронд ямар хугацаа өнгөрдөг)  
.....  
.....
7. Хамгийн сүүлд хэзээ хүчирхийлэл болсон  
.....
8. Хүчирхийлэл яаж илэрдэг (доромжлох, айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгих, тулган шаардах, зодох, хүсээгүй үед бэлгийн харилцаанд орохыг шаардах, эрх мэдлийн тэнцвэргүй байдал гэх мэт)  
.....  
.....  
.....

9. Хүчирхийлэл болохын өмнө ба болсны дараа хохирогчид ямар сэтгэгдэл, мэдрэмж төрж байсан

.....  
.....  
.....  
.....

10. Хүчирхийллийг таслан зогсоох ба урьдчилан сэргийлэх талаар ямар нэг байгууллагад хандаж байсан эсэх, хэрэв тийм бол ямар байгууллагын үйлчилгээ авч байсан

.....  
.....  
.....

11. Хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааны түүхийг сонсох явцад хийсэн нийгмийн ажилтны ажиглалт, тэмдэглэл

.....  
.....  
.....  
.....

## Д. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД АЮУЛ УЧРУУЛАХ

### ЭРСДЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ НЬ

#### Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдлүүд

Хохирогч сэтгэл санааны байнгын дарамт, шахалтанд байдаг эсэх

Тийм  
Үгүй

Хэрэв тийм бол энэ дарамт шахалт нь хохирогчийн ажил амьдралд нь ямар нөлөө үзүүлдэг тухай тодруулан бичнэ үү

Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг ямар нэг шалтгаанаар заналхийлэн сүрдүүлж, эсхүл гэмт хэрэгт гүтгэхээр айлгадаг эсэх

Тийм  
Үгүй

Хэрэв тийм бол ямар шалтгаанаар хохирогчийг айлган сүрдүүлж, заналхийлдэг тухай тодруулан бичнэ үү

Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн биед гэм хор учруулдаг, эсхүл биед ил харагдахуйц гэмтэл учруулахгүй ч өөрийн эрхшээлд байлгах, гэр бүлийн харилцаанд давамгайл байдал тогтоох зорилгоор хүч хэрэглэн биед нь халддаг эсэх

Тийм  
Үгүй

Хэрэв тийм бол энэ нь ямар байдлаар илэрдэг тухай тодруулан бичнэ үү

Хүчирхийлэл үйлдэгч нь хутга мэс, галт зэвсэг болон бусад гаднын биет эд зүйлс хэрэглэдэг эсэх

Тийм  
Үгүй

Хэрэв тийм бол ямар гаднын ямар эд зүйлс, зэвсэг хэрэглэдэг тухай тодруулан бичнэ үү

.....

Хүчирхийлэл үйлдэгч бэлгийн хүчирхийлэл ба бусад бэлгийн шинжтэй үйлдлийг хохирогч хүсээгүй байхад үйлддэг шаарддаг/, эсхүл гэр бүлээс гадуур өөр хүнтэй бэлгийн харилцаатай байдах эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол ямар байдлаар энэ дарамтыг үзүүлдэг тухай тодруулан бичнэ үү

.....

Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн бие даасан байдалд нөлөөлдөг, эсхүл хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарладаг эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол хохирогчийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн бие даасан байдалд хэрхэн нөлөөлдөг тухай тодруулан бичнэ үү

.....

Хүчирхийлэл үйлдэгч тэжээн тэтгэх үүргээс зайлсхийдэг, энэ зорилгоор дарамт шахалт үзүүлдэг эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол ямар байдлаар энэ дарамтыг үзүүлдэг тухай тодруулан бичнэ үү

.....

Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг нийгмээс тусгаарлаж, бусадтай холбоотой байхад нь саад болдог эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол нийгмээс хэрхэн тусгаарлаж, бусадтай холбоотой байхад нь яаж саад болдог тухай тодруулан бичнэ ҮҮ

.....

.....

Хүчирхийллийн улмаас хохирогчийн бие махбод, эрхтэн системийн болон сэтгэл санаа, сэтгэцийн үйл ажиллагаанд өөрчлөлт ба гэмтэл гарсан эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол ямар эрхтэн системийн үйл ажиллагаанд өөрчлөлт, гэмтэл учирсан эсэхийг тодруулан бичнэ үү

.....

.....

Хүчирхийлэл үйлдэгч хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол ямар хэлбэрийн хүчирхийллийг хэрхэн үйлддэг тухай тодруулан бичнэ үү/ сэтгэл санааны, бие махбодын, эдийн засгийн, бэлгийн болон үл хайхрах/

.....

.....

Хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж байсан эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол ямар байдлаар хохирол учруулдаг тухай тодруулан бичнэ үү

/Гэмт хэрэг, буруу зуршилд татан оролцуулах, мөн хүүхдээ орон гэрээс нь дайжуулах, гэр бүлдээ хэвийн амьдрах боломжгүй болгох зэргээр хүүхдийн хүмүүжилд муугаар нөлөөлөх үйлдэл зэрэг/

.....

.....

Гэр бүлийн хүчирхийлэл даамжирч, хүчирхийлэл үйлдэх давтамж ойртсон эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол хүчирхийлэл хэрхэн даамжирч, давтамж нь ямар хугацаагаар ойртсон тухай тодруулан бичнэ үү.

.....

.....

Шүүхээс эрх хязгаарлах арга хэмжээ авагдаж байсан эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол хэдэн удаа, аль хуулиар ямар төрлийн хуулийн хариуцлага хүлээж байсан эсэх/эрүүгийн, иргэний төлбөр нөхөн төлсөн, захиргааны хуулиар, эрүүлжүүлэгдсэн, захиргааны арга хэмжээ авагдсан, тусдаа амьдрахыг даалгасан, зан үйлээ өөрчлөх тухай сургалтанд суухаар даалгагдсан, гэр бүлийн гишүүдтэй уулзахыг хориглосон талаар тодруулан бичнэ үү/

.....

.....

## Нийгмийн орчны эрсдлүүд

Хохирогч санхүүгийн асуудалтай байнга тулгардаг эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол санхүүгийн ямар асуудалтай тулгардаг талаар тодруулан бичнэ үү.

.....

.....

Хохирогч хүчирхийлэл гарсан үед нэн даруй цагдаагийн байгууллагын болон нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг эсэх, эсхүл хүчирхийлэл тусламж авах боломжгүй орой үдшийн цагаар үйлдэгддэг эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол хохирогч хаана амьдардаг, ямар шалтгаанаар үйлчилгээ нэн даруй авах боломжгүй тухай тодруулан бичнэ үү.

Хохирогч ямар нэг архаг хууч өвчтэй эсхүл хөгжлийн бэрхшээлтэй эсэх

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол ямар өвчтэй эсхүл ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй тухай тодруулан бичнэ үү.

Хохирогчийн хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг орон нутгийн нийгмийн халамж, хамгаалал, нийгмийн үйлчилгээний байгууллагаас үзүүлэх боломжгүй

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол ямар шалтгаанаар орон нутгийн нийгмийн үйлчилгээний байгууллагууд хохирогчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх боломжгүй талаар тодруулан бичнэ үү.

Хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааг гэр бүлийн бусад гишүүд, ах дүү, хөрш, орон нутгийнхан хэвийн гэж үздэг эсэх

Тийм

Үгүй

Хохирогч ямар нэг шалтгаанаар (нас, хүйс, гарал үүсэл, боловсрол, эрхэлж буй ажил, эрүүл мэндийн байдал, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага зэрэг шалтгаанаар) ялгаварлан гадуурхагддаг эсэх.

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол хохирогчийг ямар шалтгаанаар бусдаас ялгаварлан гадуурхдаг тухай тодруулан бичнэ үү.

.....  
.....

### **III. Хохирогчийн амь насыг хөнөөх магадлал бүхий эрсдлүүд**

1. Хүчирхийлэл үйлдэгч өөрийгөө болон эхнэр эсхүл хамтран амьдрагч, үр хүүхдээ ална гэж заналхийлдэг эсэх
  - Тийм
  - Үгүй
2. Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг өмчилж, өөрөөс нь салбал түүнийг ална гэж заналхийлдэг, мөн энэ бодолдоо итгэлтэй зан үйл гаргадаг эсэх
  - Тийм
  - Үгүй
3. Хүчирхийлэл үйлдэгч ямар нэг галт зэвсэг эзэмшдэг эсхүл хэрэглэнэ гэж өмнө нь заналхийлж байсан эсэх
  - Тийм
  - Үгүй
4. Хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс зугтаахад түүнийг мөрдөн мөшгиж, хохирогчийг гэртээ харихгүй бол ална хэмээн айлган заналхийлдаг эсэх
  - Тийм
  - Үгүй
5. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг олохын тулд хүүхдээ холбоо тогтоох хэрэгсэл болгон ашигладаг эсхүл хэн нэгнийг барьцаалж ална гэж заналхийлдаг эсэх
  - Тийм
  - Үгүй

## **Е. НИЙГМИЙН АЖИЛТНЫ ДҮГНЭЛТ**

1. *Үйлчилгээ үзүүлсэн байгууллага ба ажилтны тухай ерөнхий мэдээлэл*
  1. Үйлчилгээ үзүүлсэн байгууллагын нэр: .....
  2. Байгууллагын хаяг .....
  3. Үнэлгээ хийсэн .....он ..... сар ..... өдөр
  4. Үнэлгээ хийсэн нийгмийн ажилтны овог нэр .....
2. *Хохирогч ба хүчирхийлэл үйлдэгчийн тухай ерөнхий мэдээлэл*
3. *Хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааны түүх*
4. *Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид аюул учрах эрсдлүүд*
5. *Хохирогчид аюул учрах эрсдлийн түвшинг үнэлсэн дүн*
6. *Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр авсан арга хэмжээ*

7. Нийгмийн ажилтны ерөнхий дүгнэлт ба санал зөвлөмж

8. Цаашид авах арга хэмжээ, шаардлагатай хамгаалалт үйлчилгээ

Нийгмийн ажилтны гарын үсэг ..... /Овог нэр...../  
.....он..... сар..... өдөр



..... цаашид  
..... хохирол учруулж болзошгүй  
байна.

Хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлж

1. Хүчирхийлэл дахин давтагдах магадлалтай
2. Хүчирхийллийн болзошгүй эрсдлийн түвшинг
  - А. Аюултай ба эрсдлийн түвшин өндөр
  - Б. Дунд зэргийн аюултай ба эрсдлийн түвшин дунд зэрэг
  - В. Аюул багатай ба эрсдлийн түвшин бага зэрэг

байна гэж дүгнэлээ.

Иймд хохирогчийн аюулгүй байдлыг хангахын тулд ..... овогтой  
.....нд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16-р  
зүйлийн 16.1-д заасны дагуу .....

зэрэг эрх хязгаарлах арга хэмжээг *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16.1-д заасан арга хэмжээнээс шаардлагатайг сонгон бичнэ/ болон мөн хуулийн 16.1.5-д заасан зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулах эрх хязгаарлах арга хэмжээтэй хамтруулан* ..... хугацаагаар ногдуулах шаардлагатай гэж үзэж байна.

Хүсэлтэнд ..... хороо /сумын нийгмийн ажилтан .....  
овогтой .....-тэй хамтран тогтоосон нөхцөл байдлын үнэлгээ  
болон ..... хуудас материал хавсаргав.

Хүсэлт гаргасан .....  
байгууллага /албан тушаал / ..... овогтой ..... /нэри/  
.....гарын үсэг

**Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах шийдвэр гаргуулахаар шүүхэд хүсэлт гаргахад анхаарах асуудал**

Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлуулах шийдвэр гаргуулахаар шүүхэд хүсэлт гаргах нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Цагдаагийн байгууллагад хуулиар хүлээлгэсэн үүрэг болно. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9.1.7/

Үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд дараах зүйлүүдийг анхаарвал зохино.

**I. Гэр бүлийн хүчирхийллийн тухай гомдол, мэдээллийг**

1. Хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн байнга буюу түр оршин сууж байгаа газрыг
2. Хохирогч эмнэлэгт эсхүл хамгаалах байр, нийгмийн халамжийн газарт байгаа бол тус байгууллага оршин байгаа газрыг
3. Хүчирхийлэл үйлдэгч албадан сургалт явуулдаг байгууллагад байгаа бол тэр газрыг харьяалах цагдаагийн байгууллага мэдээллийг хүлээн авч, холбогдох арга хэмжээ авах үүрэгтэй. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13.4; 9.1 болон Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24.1/

II. Цагдаагийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээлэл хүлээн авч бүртгэх, тэмдэглэл хөтлөх төдийгүй хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж хохирогчийг хамгаалах, хүчирхийллийн нөхцөл байдлыг тодруулах ажиллагааг хийх үүрэгтэй. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9.1.1, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 24.1, Улсын Дээд Шүүхийн 2006 оны 11 сарын 30-ны өдрийн 47-р тогтоолын 3/

- Ямар хэлбэрийн хүчирхийлэл үйлдэгдсэн, хүчирхийллийн хэлбэрүүд хавсарсан эсэх /Улсын Дээд Шүүхийн 2006 оны 11 сарын 30-ны өдрийн 47-р тогтоолын 2/
- Хүчирхийллийн улмаас учирсан эсхүл учирч болох хохирол, хохирогчийн өөрийгөө хамгаалах чадварт байдал /хохирогч бага насны эсхүл бага насны хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй, хүчирхийлэл үйлдэгчийн байнгын дарамт, заналхийллийн улмаас айдаст бүрэн автагдсан, аюултай нөхцөлд авч болох тусламж, дэмжлэгээс хол байдаг/
- Хүчирхийллийн давтамж, үргэлжилсэн хугацаа
- Хүчирхийлэл үйлдэхдээ гадны биет ба галт зэвсэг хэрэглэх зэргээр ноцтой байдлаар үйлддэг зэргийг тодруулан бэхжүүлнэ. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9.1.1 болон 10.1.1/

**III. Аюулын болон эрсдэлийн түвшинг**

- Аюултай ба эрсдэлийн түвшин өндөр

- Дунд зэргийн аюултай ба эрсдэлийн түвшин дунд
  - Аюул багатай буюу эрсдэлийн түвшин бага зэргийн аль түвшинд хамаарахыг тодорхойлж улмаар хүсэлтэндээ хүчирхийлэл үйлдэгчид ногдуулах арга хэмжээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд заагдсан зүйл, заалтын дагуу зааж өгнө. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9.1.7 болон 10.1.1/
2. Яаралтай тохиолдолд богино хугацаанд эрх хязгаарлах шийдвэр гаргуулах шаардлагатай бол хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, гэрчээс мэдүүлэг авах, эд мөрийн баримтад үзлэг хийх зэрэг ажиллагааг урьдчилан явуулахгүйгээр шүүхэд хандаж болно. Цагдаагийн байгууллагаас эдгээрийг ажиллагааг заавал хийсэн байхыг шүүх шаардахгүй. Талууд дээрх ажиллагааг хийлгэх хүсэлтийг шүүхэд гаргах эрхтэй байна. /Улсын Дээд Шүүх ийн 2006 оны 11 сарын 30 ны өдрийн 47-р тогтоолын 9/
  3. Шүүх хохирогчийн амь нас, эрүүл мэндийг яаралтай хамгаалах зорилгоор 24 цагт багтаан эрх хязгаарлах шийдвэр гаргахдаа хүчирхийллийн улмаас хохирогчид бодит хохирол учирсан байхыг шаардахгүй болно. /Улсын Дээд Шүүх ийн 2006 оны 11 сарын 30-ны өдрийн 47-р тогтоолын 11/
  4. Хүсэлтэнд эрх хязгаарлах арга хэмжээний төрлөөс шаардлагатай гэж үзэж байгаа бол хэдийг ч давхардуулан зааж болох бөгөөд зан үйлд нөлөөлөх сургалтанд хамруулах арга хэмжээг заавал дурьдаж байх нь зүйтэй болно. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 4.1/
  5. Цагдаагийн ажилтан хохирогчийг төлөөлөн цүүхэд хүсэлт гаргахдаа аюултай буюу эрсдэлийн түвшин өндрөөс бусад тохиолдолд хохирогчийн саналыг харгалзан үзнэ. Харин гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол бүрт харьяалах сум, хорооны нийгмийн ажилтанд заавал мэдээлэх бөгөөд нөхцөл байдлын үнэлгээ, аюулын болон эрсдэлийн түвшинг заавал хамтран тогтоох үүрэгтэй. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9.1.7 болон 10.1.1, 17.2 /
  6. Эрх хязгаарлах хүсэлтийг шүүх шийдвэрлэсэн эсэх асуудал нь уг хэрэгт захиргааны арга хэмжээ ногдуудах эсхүл эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болон иргэний журмаар гэрлэлтээ цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, тэжээн тэтгүүлэх, эдийн болон эдийн бус гэм хор арилгуулахаар нэхэмжлэл гаргахад саад болохгүй. /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 15.2 болон 17.5/
  7. Хүсэлт нь хуулийн дагуу улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн болно. /МУ-ын Тэмдэгтийн хураамжийн хуулийн 18.1.5/
  8. Хүсэлтийг заавал 2 хувь хийнэ. /Иргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.3/

9. Хүсэлтэнд хавсрагдах материалууд нь эх хувиар эсхүл нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар болон цагдаагийн эрх бүхий албан тушаалтнаас баталгаажуулсан дардас бүхий хуулбар хэлбэрээр байна. /Мргэний хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хуулийн 44.2/
10. Цагдаагийн ажилтан нь харъяа нутаг дэвсгэртээ оршин сууж байгаа хэширогчийг хамгаалах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчид хамаарах эрх хязгаарлах арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж ажиллана. /Гэр, бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13.4 болон Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 10.5/



**Гэр бүлийн хүчирхийлэлийн  
хоширогчийн бүртгэл**

Код:.....  
 Овог:..... нэр:.....  
 Нас: 0-6 7-12 13-17 18-25 26-35 36-45 46-55 55-

Хүйс: Эсэгтэй Эрэгтэй  
 Боловсрол: Дээд Тусгай дунд Бүрэн бус дунд  
Бага Бусад  
 Иргэнийн: .....

Ажилладаг эх: Тайм Үгүй  
 Хариуаалаа албаат/дүүргээр: аймаг/дүүрэг: .....

Сүүж хөдөө  
 Гэрээлтийн байдал: Баталгаатай гэр бүл Гэрээгүй Салсан  
Хэвтрэн амьдрах Хэвтрэн амьдраагүй бэлгийн харилцаатай  
 Мучирхайлаа үйлдэгч нь хэн бөлэх: Ногоор/эхээр Хамтран амьдрагч  
Төрсөн эцэг эх Халам эцэг эх  
Ах дүү, хамтатан садан Уерсэдг найз залуу/охио Бусад

Мучирхайлаагийн төрөл: Сэтгэл санааны Бие махбодийн  
Бэлгийн Эдийн засгийн

Мучирхайлаа үргэлжлэсэн хугацаа: 0-1 жил 1-3 жил 3-5 жил 5-8 жил 8-аас дээш жил  
 Мучирхайлаагийн давтамж: .....

Жила 1-2 удаа Уураад 1-2 удаа Сара 1 удаа  
14 хоног тугаад 7 хоног тугаад 3 хоног тугаад  
Өвөр бүр

Үйлдвүүлэгчид аюул учрах эрсдэлийн түвшин: Эрсдэлийн түвшин өндөр, амь насанд аюултай  
Эрсдэлийн түвшин дунд зэрэг Эрсдэлийн түвшин бага  
 Ашиг зорлох өрөхдөлгөө хийсэн эх: Тайм Үгүй

Хучирхайлаа үйлдэгч нь гаднын биет, дутга мэт болон галт гэвсг  
 хэрэглэдэг эх: Тайм Үгүй  
 Хучирхайлаагийн хэлбэр: Гэр бүлийн хүчирхийлэл Бэлгийн хүчирхийлэл  
Бусад

Хочирлын төрөл/доогуур нь турал уу/  
 Сэтгэл санааны Бие махбодийн

Эдийн засгийн хүчирхийлэл  
 Үйлдвүүлэгчийн хувьд, хэргийг: Хамгаалах байрлал байрлах Шүүсээр гэрэлтээ тушуулах  
Хучирхайлаа үйлдэгчээс өөрийн эд хөрөнгөө алдсан гаргуулах  
Хучирхайлаа үйлдэгчийг уутлуулах, дан үйлд нь мөнгөсөө  
Замарганы арга хэмжээг амьсгуулах Эвгэг тогтоологч  
Хүүхэд тэтгэлэг тогтоологч Аюулгүй байдала хамгаалуулах  
Шүүсээр эрх хязгаарлах шийдвэр гаргуулах  
Нийгмийн халамжийн үрвэлгээнд хамрагдах  
Эрүүл мэндээ ноён сүргэлтэх Хочирал тушуулах  
Тусал амьдрах Хүүхдээ өөрийн асрамжинд үлдээх  
Эрүүгийн харууллага хүлээлгэх Замалхайлаагийн зогсоогдох

Хүргэгчг шийдвэрлэх давуу тал, боломж

- Өөртөө итгэлтэй  Мэргэжлэгтэй  Өөрийн гэсэн орон байртай  
 Ажил хийдэг  Хүүхдүүд том болсон  Өөрийг нь дэмжих  
 орчин бий /эх дүү хамтатан саалийн дэмжлэг сайн/  Буцаад  
 Хэргэлтэй шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал  
 Өөрөө архамы хамаралтай  Биегц баримтгүй  
 Орон гэрээ  Нэхл хүүхэдтэй  Эрүүд мөнд эрс муудсан  
 Өөрийн гэсэн орлоготгүй  Боловсрол мэргэжлэггүй  
 Хөнгөлийн бэрхшээлтэй  Хүүчрхийхэлээ үйлдэгчдээ  
 хардаг/байдагтай/  Ажла олхдоггүй  Буцаад

**ХЭҮТ-өөс авсан арга хэмжээ**

**а/ҮЙЛДЭМЖЛЭЭ ГҮЭГДЭСНИ**

- Бүртгэлийн програмд бүртгэгч, баримтжуулсан  
 Гянахад бэлдсэн үндсээ хийсэн  Кейс тоглоомоо хийсэн  
 Аюулгүй төлөвлөгөө боловруулсан  
 Хамгаалах байранд байрлуулсан  Дэмжих бүхэлт хамралсан  
**б/Уялдуулах өгсөн**  
 Анхны үзлэлт хийсэн  Хуулийн зөвлөгөө өгсөн  
 Итгэлийн утсаар зөвлөгөө өгсөн  Хүүхдэд зөвлөгөө өгсөн  
 Хүүчрхийхэлээ үйлдэгчтэй ярихсан

**в/Эрх зүйн төслөлөгчөө ГҮЭГДЭСНИ**

- Бүтэцлэгчээр хангасан  Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр  
 оролцсон  Ногоох баримтжуулалт хийсэн  Бүртгэвэл,  
 ихэмжлэл биегц өгсөн  
 Шүүхийн шийдвэр гаргуулсан  Шүүхийн захирамж гаргуулсан  
 Шийгвэр гаргуулсан  Захиргааны арга хэмжээ авуулсан  
 /доогуур нь зурга уу/  
 Гэрээгээ тохуулсан, баримтжуулсан /

**г/Хөтөлбөр зурчлах үйлдвэлээ ГҮЭГДЭСНИ**

- Эрүүд мөндөй байгууллагдах зуучилсан  
 / орхамы эмнэлэг, шүүх эмнэлэг, дүүргийн эмнэлэг, гэмтлийн  
 эмнэлэг, халамжийн эмнэлэг, эмгэгтгүүдийн эмнэлэг, бусад  
 Нийгмийн халамжийн үйлчилгээнд зуучилсан  
 Дүүргийн халамж үйлчилгээтний төв, Овоо улсын халамжийн  
 байгуулага, бусад байгууллага, Хөдөлмөр эрхлэлтийн алба/  
 Боловсролын байгууллагад зуучилсан

/ЕБС, Албан бус боловсролын төв, мэргэжлэд сургалтын төв,  
 Цэвэрлэгч, явж, их дээд сургууль/  
 Хуулийн байгууллагад зуучилсан / Дүүргийн шүүх, Өмгөөлөгчдийн  
 холбоо, Цагдаагийн газар, бусад/  
 Хороо, дүүргийн засаг даргын тамгын газарт  
 /Дүүргийн засаг дарга, нийгмийн асуудал хариуцсан түшмэл,  
 хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, шалдаг/

**Үйлчлүүлэгчийн гарын үсэг**

**Мавгт бичсэн**

.....  
 /Ажлын өмөг нэр/

**Огноо**

.....

## Хавсралт 5

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, НИЙГМИЙН  
ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2009 оны 9 сарын 22 өдөр

Дугаар 308/129/129 Улаанбаатар хот

Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төвийг Эрүүл мэндийн яамны харьяа Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Шүүх эмнэлэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эрүүл мэндийн газрын харьяа Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдэл дээр тус тус байгуулсугай.


2. "Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааг уялдуулж зохицуулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нэг цэгийн үйлчилгээг 2009 оны 9 дүгээр сард багтаан эхлүүлэхийг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (С.Төгсдэлгэр), Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (Т.Алтангэрэл), Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (Т.Энхтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Эмнэлэг тус бүр дээр "Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний журам"-д нийцүүлэн, тухайн эмнэлгийн онцлогт тохирсон нэг цэгийн үйлчилгээний төвийн дотоод дүрмийг орон тооны бус зөвлөлөөр батлуулан дагаж мөрдөхийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дарга (С.Отгонгэрэл), Шүүхийн эмнэлгийн дарга (Г.Дагиймаа), Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн дарга (О.Бямбаа) нарт тус тус даалгасугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг орон тооны бус зөвлөл (Н.Хуралбаатар)-д даалгасугай.





#### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогчид (цаашид "хохирогч" гэх) эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ (цаашид нэг цэгийн үйлчилгээ гэх) үзүүлэхэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон энэхүү журмыг баримтална.

#### Хоёр. Үйл ажиллагааны үндсэн зарчим

2.1. Нэг цэгийн үйлчилгээний төв нь үйл ажиллагаандаа дараахь зарчмыг баримтална:

- 2.1.1. Хүний нэр төр, эрх, эрх чөлөөг хүндэтгэн хувь хүний нууцыг хадгалах;
- 2.1.2. Хохирогчийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр 24 цагийн турш үйлчлэх;
- 2.1.3. Үйлчилгээг үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд суурилан шуурхай, хүртээмжтэй хүргэх;
- 2.1.4. Мэргэшсэн, тогтвортой байх;

#### Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэлзүйн үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий нэг цэгийн үйлчилгээний төвд нийгмийн болон эрүүл мэндийн ажилтан ажиллах бөгөөд тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хэсгийн байцаагч дуудлагаар ирж ажиллана.

3.2. Хохирогчийн амь нас эрүүл мэндэд зайлшгүй аюул нүүрлэж байгаа тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэж таслан зогсоолгох арга хэмжээг яаралтай авч.

3.3. Хохирогчид шаардлагатай богино болон урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээтэй нягт уялдаа холбоотой байх үйл ажиллагаа явуулна.

3.4. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хохирогчид зөвлөгөө өгөх, орон нутгийн холбогдох байгууллагуудтай гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллана.

### **Дөрөв. Үйлчилгээний нөхцөл, үйлчилгээ**

4.1. Нэг цэгийн үйлчилгээний төв нь хохирогчийн аюулгүй байдал, эрүүл ахуйд нийцсэн байр, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

4.2. Хохирогчид сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ, яаралтай мэс засал, нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ, оношлогоо хийлгэх, шаардлагатай гэж үзвэл нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан хохирогчийг холбогдох эмнэлгийн байгууллагад шилжүүлнэ.

4.3. Нэг цэгийн үйлчилгээний ажилтнууд мэргэшсэн байж мэргэшүүлэх давшан сургалтанд тогтмол хамрагдана.

4.4. Нэг цэгийн үйлчилгээний төвөөс хохирогчид яаралтай тусламж, анхан шатны үзлэг, тайвшруулах болон сэтгэлзүйн зөвлөгөө зааварчилгаа өгөх, эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох үйлчилгээг үзүүлнэ.

#### **Тав. Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд оролцогсодын үүрэг**

##### **5.1. Нийгмийн ажилтан дор дурдсан үүрэгтэй:**

5.1.1. Нэг цэгийн үйлчилгээний багийн ажил, салбарын хоорондын уялдааг хангах, зохицуулах;

5.1.2. Хохирогчийн хувийн хэргийг нээхээс нь хаах хүртэл хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний үр дүнгийн талаарх нэгдсэн тайлан мэдээ гаргах;

5.1.3. Хохирогчийг тайвшруулах, мэдээлэл өгөх, зөвлөгөө өгөх;

5.1.4. Хохирогчийн нөхцөл байдал болон аюулын зэргийн түвшний үнэлгээ хийх;

5.1.5. Шаардлагатай тохиолдолд хохирогчийн хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан хууль зүйн туслалцаа авах нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах, хуулийн байгууллагад хандахад нь зуучлах. Үүнд:

5.1.5.1. Эрх зүйн туслалцааны төвд хандах;

5.1.5.2. Бичиг баримтжуулах;

5.1.5.3. Нийгмийн халамж үйлчилгээ;

5.1.5.4. Хууль, хяналтын байгууллагад хандах;

5.1.6. Үйлчлүүлэгч хөгжлийн бэрхшээлтэй болон хүүхдэд тусгайлсан туслалцаа үзүүлэх.

##### **5.2. Эрүүл мэндийн ажилтан нь дор дурдсан үүрэгтэй:**

5.2.1. Хохирогчид үзлэг хийж анхан шатны эмнэлгийн туслалцаа үзүүлэх;

5.2.2. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлыг тогтоож, шаардлагатай нарийн мэргэжлийн эмчид илгээнэ.

5.2.3. Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд биеийн байдлын талаар холбогдох маягыг хөтөлж, дүгнэлт гаргах;

5.2.4. Нарийн мэргэжлийн эмчийн оношлогоо, эмчилгээний тухай мэдээллийг үндэслэн дүгнэлт гаргаж нийгмийн ажилтанд өгөх;

5.2.4. Үйлчлүүлэгч согтуурах болон мансуурах донтой эсэхийг тогтооходорхойлох, холбогдох байгууллагад нийгмийн ажилтнаар дамжуулан илгээх.

### 5.3. Цагдаагийн байгууллагын хэсгийн байцаагч дор дурдсан үүрэгтэй:

5.3.1. Нутаг дэвсгэрийн харъяаллын дагуу дуудлагаар шуурхай үйлчилгээ шаардлагатай тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах;

5.3.2. Нийгмийн ажилтантай хамтран үйлчлүүлэгчийн аюулын эрсийг тогтоох;

5.3.3. Шаардлагатай гэж үзвэл шүүхийн магадлан шинжилгээ хийлгэх гэмтлийн зэргийг тогтоолгох тухай шийдвэрийг холбогдох журмын дагуу гаргах;

5.3.4. Тухайн хүчирхийлэл бүхий үйлдлийн хүчирхийлэл үйлдэгчийн эрх үйлд нөлөөлөх, согтуурах мансуурах донгийн эсрэг албадан эмчилгээнд хамруулах арга хэмжээ авах хүсэлтийг зохих журмын дагуу илүүхэд гаргах;

5.3.5. Шаардлагатай тохиолдолд хохирогчийг хамгаалах байранд журмын боломжтой бол төрөл, садангийн хүний түр хамгаалалтад өгөх.

## Зургаа. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

6.1. Хохирогч нь Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэхдээ дараах эрхтэй байна:

6.1.1. Нутаг дэвсгэрийн харъяалал харгалзахгүйгээр үйлчлүүлэх;

6.1.2. Анхан шатны болон яаралтай эмнэлгийн тусламж авах;

6.1.3. Хувийн нууцаа хамгаалуулах;

6.1.4. Хууль зүйн зөвлөгөө авах;

6.1.5. Нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авч, шаардлагатай бол шүүх эмнэлэгээр холбогдох журмын дагуу гэмтлийн зэргээ тодорхойлуулах, шинжилгээ хийлгэх;

6.1.6. Хүчирхийлэлд өртсөн тухайгаа баримтжуулуулах.

6.1.7. Хохирогч нь нэг цэгийн үйлчилгээний төвийн дотоод журмыг даган мөрдөх үүрэгтэй.

## Долоо. Бусад

7.1. Нэг цэгийн үйлчилгээний төвийн нийгмийн ажилтан тус үйлчилгээний төвийн үйл ажиллагааны тайланг орон тооны бус зөвлөлд үлирал тутам хүргүүлж хэлэлцүүлнэ.

7.3. Орон тооны бус зөвлөл нь Нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагааны тайлан, явцын үнэлгээний дүнг хагас жил тутамд эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.4. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд жил бүр хамтарсан хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ.

--- оОо---

Хууль зүй, дотоод хэргийн сайд,  
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2009 оны 8 дугаар  
сарын 19-ны өдөр

Дугаар 19 / 33

Улаанбаатар  
хот



Албадан сургалт зохион байгуулах журам,  
сургалтын хөтөлбөр батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2. дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулах журам"-ыг 1 дүгээр, "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж, холбогдох зардлыг жил бүрийн төсөв, гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хүрээнд зохицуулан шийдвэрлэж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар /Д.Сандаг-Очир/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /Д.Батжаргал/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Т.Энхтуяа/-д тус тус даалгасугай.

3. Албадан сургалтыг зохион явуулах талаар арга зүйн гарын авлага бэлтгэн гаргах, сургалт зохион байгуулах баг, мэргэжилтнийг мэргэшүүлэн бэлтгэх ажлыг удирдан зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Т.Алтангэрэл/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Т.Энхтуяа/-д тус тус даалгасугай.





**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН  
ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл, ухамсарт нөлөөлөн хүлүүжүүлэх зорилго бүхий албадан сургалтыг шүүхийн шийдвэрийн дагуу эрх бүхий мэргэжлийн байгууллагууд хариуцан зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт цаашид "албадан сургалт" гэх-ыг зохион байгуулахад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтална.

1.3. Албадан сургалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/ Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулна.

1.4. Энэ журмын 1.3-т заасан этгээд нь албадан сургалтын хичээлийг хөтөлбөрт заасан агуулгын дагуу мэргэжлийн түвшинд зохион байгуулах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан мэргэжлийн байгууллага, сэтгэл зүйчтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа авч болно.

1.5. Албадан сургалт нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн хүчирхийлэл бүхий үйлдлийг таслан зогсоох төдийгүй хүчирхийлэлгүйгээр асуудлыг шийдэх арга зам, эерэг зан үйлийг төлөвшүүлж, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэх бөгөөд сургалтанд дараахь зарчмыг баримтална:

1.5.1. албадан сургалтанд оролцогчтой ажиллах явцдаа хохирогчийн аюулгүй байдлыг хангах;

1.5.2. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хувь хүний нууцыг хадгалах;

1.5.3. сургалтанд оролцогчийн зан үйл бүрэн өөрчлөгдөх болон үйлдлээ зогсоох хүртэл орчны дэмжлэг, шахалт, цаг хугацаа шаардлагатай харгалзан тогтвортой ажиллагааг хангах;

1.5.4. салбар дундын уялдаа холбоог хангаж хамтран ажиллах;

1.5.5. хүчирхийлэл үйлдэгч хүчирхийлэл бүхий үйлдлээ таслан зогсоон зан үйлээ өөрчлөн төлөвшүүлэхэд зан байдлын онцлог, хэрэгцээнд нь суурилсан мэдээлэл, сургалтаар хангах.

**«Хоёр, Мэдээлэл цуглуулах, солилцох журам.»**

2.1. Хохирогчийг хамгаалах, албадан сургалтыг үр дүнтэй цогц хэлбэрээр зохион байгуулахын тулд зохион байгуулагчид салбар хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагааг нээлттэй, нягт, уян хатан байлгаж дор дурдсанаар хамтран ажиллана:

2.1.1 хохирогч болон хүүхдийн байгаа газар, тухайн орчны аюулгүйн түвшин тогтоогдсон эсэхийг анхаарч, хүүхэд хүчирхийллийн хохирогч болсон бол хүүхэд хамгааллын үйлчилгээнд мэдэгдэх;

2.1.2. хохирогчид эмнэлгийн тусламж шаардлагатай, сэтгэцийн хямралын хурц хэлбэрт орсон тохиолдолд эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээний маргажилтнүүдэд нэн даруй мэдэгдэх;

2.1.3. албадан сургалтанд оролцогч согтуурах, мансуурах донтой өвчтэй, албадан эмчилгээнд хамруулах шаардлагатай эсэхийг тогтоож, холбогдох байгууллагуудад мэдэгдэх;

2.1.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусгайлан туслалцаа үзүүлэн шаардлагатай эсэхийг тогтоож, холбогдох байгууллагад мэдэгдэх;

2.1.5. хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад болон гэр бүлийн бусад гишүүдэд хууль зүй, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг шаардлагатай байгаа эсэхийг тогтоох.

2.2. Албадан сургалтын оролцогч болон зохион байгуулагчид оролцогчийн хувийн мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусад этгээдэд задруулахыг хориглож, энэ тухай бичгээр баталгаажуулна:

2.2.1. тухайн оролцогч нь өөрөө зөвшөөрч гарын үсэг зурсан, бусад мэдэгдэж болох мэдээлэл;

2.2.3. албадан сургалтын үед тусгайлан бичлэг хийх талаар бүх оролцогчдын зөвшөөрлийг бичгээр авсан тохиолдолд аудио болон видео бичлэг хийх;

2.2.4. Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

2.3. Дараахь этгээдүүдийг оролцогчийн талаарх холбогдох мэдээллээр хангахыг зөвшөөрнө.

2.3.1. хохирогч, хүүхэд;

2.3.2. шүүх, прокурорын байгууллага;

2.3.3. цагдаагийн байгууллага;

2.3.4. шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;

2.3.5. нийгмийн ажилтан;

- 2.3.6. оролцогч болон хохирогчийн өмгөөлөгч;
- 2.3.7. хүүхэд хамгааллын байгууллага, итгэмжлэгдсэн төлөөлөгч;
- 2.3.8. тухайн оролцогчийн хамрагдаж буй архивалт, мансуурлын эсрэг эмчилгээ заслын хөтөлбөр, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагын бусад хөтөлбөрийн ажилтан;
- 2.3.9. тухайн оролцогчийн хүчирхийлэл, заналхийлэлд өртөж болзошгүй эрсдэл бүхий этгээд.

2.4. Хохирогч зөвшөөрснөөс бусад тохиолдолд хохирогчийн өгсөн мэдээллийг сургалт зохион байгуулагч бусдад задруулахыг хориглоно.

### **Гурав. Албадан сургалт зохион байгуулагчийн эрх, үүрэг**

#### **3.1. Цагдаагийн байгууллага дор дурдсан эрх, үүрэг хүлээнэ:**

3.1.1. хорих, баривчлах ялаар шийтгэгдсэнээс бусад этгээдийг албадан сургалтанд хамруулах талаар шүүхийн шийдвэр гарсан бол уг сургалтыг нийгмийн ажиглангай хамтран зохион байгуулах;

3.1.2. хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтийг шүүхэд гаргах;

3.1.3. албадан сургалтанд оролцогчийг согтуурах болон мансуурах донтой эсэхийг нь тогтоолгохоор, хэрэв шаардлагатай бол эмчлүүлэхээр мэргэжлийн эмнэлгийн байгууллагад шилжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах.

3.2. Энэ журмын 3.1.2-т заасан хүсэлт гаргахдаа эрх бүхий алба хаагч тэмдэглэл хөтлөх бөгөөд түүнд хүчирхийлэл үйлдэгдсэн газар, он, сар, өдөр, цаг, хүчирхийлэл үйлдэгчийн овог, нэр, хаяг, эрхэлсэн ажил, зөрчлийн байдал, учруулсан хохирол, захиргааны хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийн холбогдох заалт /эрх хязгаарлах тухай/, хохирогч болон гэрчийн нэр, хаяг, хүчирхийлэл үйлдсэн этгээдийн тайлбар, зөрчлийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай бусад мэдээллийг тусган хүчирхийлэл үйлдсэн этгээд, хохирогч болон гэрчээр гарын үсэг зуруулж, авахуулах арга хэмжээний саналын хамт харьяалах шүүхэд хүргүүлнэ.

#### **3.3. Нийгмийн ажилтан дор дурдсан эрх, үүрэг хүлээнэ:**

3.3.1. шүүхийн шийдвэрт үндэслэн албадан сургалтын хичээлийн хуваарь; агуулгыг оролцогчийн онцлогт тохируулан зохион байгуулах;

3.3.2. холбогдох бусад байгууллагуудтай хамтран тухайн гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, уг үнэлгээнд тулгуурлан сургалтанд оролцогч нэг бүрийн онцлогт тохирсон зан үйлд нөлөөлөх сэтгэл заслын төлөвлөгөөг сэтгэл зүйч, сэтгэл засалчтай хамтран тусгайлан боловсруулах;

3.3.3. хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын явц, нөлөө, үр дүнгийн тухай мэдээллийг хохирогчтой харилцан солилцсоны үндсэн дээр цаашдын үйлчилгээний чиглэлийг тодорхойлох;

3.3.4. албадан сургалтын үргэлжлэх хугацаа, явцын талаар хохирогчид мэдэгдэх;

3.3.5. хохирогч хуулийн болон нийгмийн ажлын үйлчилгээний бусад байгууллагад хандах, холбогдох дэмжлэг, туслалцаанд хамрагдах шаардлагатай бусад мэдээлэл өгч, холбон зуучилж туслалцаа үзүүлэх;

3.3.6. хохирогчид өөрийгөө болон гэр бүлийн бусад гишүүдийг хамгаалах төлөвлөгөө боловсруулахад нь туслас;

3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дор дурдсан эрх, үүрэг хүлээнэ:

3.4.1. хорих болон баривчлах ял эдлүүлэхээр шийтгэгдсэн этгээдийг албадан сургалтанд хамруулахаар шүүхийн шийдвэрт заасан бол уг сургалтыг нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах;

3.4.2. албадан сургалтын үргэлжлэх хугацаа, явцын талаар хохирогчид мэдэгдэх;

3.4.3. албадан сургалтын хугацаанд хохирогчийн- аюулгүй байдлыг хангах зорилгоор хохирогчид зориулсан тусгай үйл ажиллагаа, яаралтай тусламж, тур хамгаалах байр, эмнэлэгийн нэг цэгийн үйлчилгээгээр хангах бол энэ талаар түүнд мэдээлэл өгөх.

Нийгмийн ажилтан болон шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага энэ журмын 3.3.4., 3.4.2.-т заасан мэдээллийг өгөхдөө сургалтын үйл ажиллагаанд оролцохыг хохирогчоос шаардах, урихыг хориглоно.

#### **Дөрөв. Албадан сургалтанд тавигдах шаардлага**

4.1. Албадан сургалтыг дор дурдсанаар зохион байгуулна:

4.1.1. сургалтанд 2-12 хүнийг хамруулах;

4.1.2. бүлгийн сургалтанд ижил хүйсийн оролцогчдыг хамруулах;

4.1.3. нэг удаагийн сургалтын үргэлжлэх хугацаа 90 минутаас багатай байх;


4.2. Бүлгийн сургалт нь оролцогчид, бүлэгт туслагч, тухайн бүлгийн удирдагчийн тусгайлан урьсанаас бусад этгээдэд хаалттай байх бөгөөд бүлгийн удирдагч тусгайлан дараахь этгээдүүдийг урьж болно:

4.2.1. холбогдох салбарын мэргэжилтэн;

4.2.2. дүлий болон сонсголын бэрхшээлтэй оролцогчид зориулсан хэлмэрч;

4.2.3. хэрэгцээтэй бусад мэдээлэл хийх мэргэжилтэн.

4.3. Оролцогчийг тухайн албадан сургалтын үед өөр бусад сэтгэл заслын хөтөлбөр, албадан эмчилгээнд давахар хамрагдаж байгаа эсэхийг тодруулна.



**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД  
НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**Нэг. Албадан сургалтын үе шат**

1.1. Албадан сургалтыг 12 хүртэлх сарын хугацаанд зохион байгуулах бөгөөд 7 хоногт 1-3 удаагийн давталттай явуулна.

1.2. Албадан сургалт нь 20 цуврал хичээлтэй, 7,14, 20 дугаар хичээлээр явцын болон эцсийн үр дүнгийн үнэлгээ хийнэ.

1.3. Албадан сургалтын явцад зан үйл өөрчлөгдөх дараахь 5 үе шатыг заргалзан үзнэ;

1.3.1. эсэргүүцэл ба эргэцүүлэн бодох үе шат;

1.3.2. зан үйлээ өөрчлөх хүсэл эрмэлзлэлийг дэмжих үе шат;

1.3.3. хариуцлагаа ухамсарлаж, зан үйлээ өөрчлөх, эерэг зан үйлийг ажгуулах шийдвэр гаргах үе шат;

1.3.4. зан үйлдээ хяналт тавих арга замыг сургаж дадлагажуулах үе шат;

1.3.5. зан үйлдээ хяналт тавьж, эерэг зан үйлийг хэвшүүлж, бататгахад нь нөлөөлж, дахин хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх.

1.4. Хичээл тус бүр дараахь бүтэцтэй байж болох бөгөөд оролцогчдын тухайн үеийн онцлогт тохируулан зохион байгуулна:

1.4.1. нүүр хагарах дасгал буюу өмнөх хичээлийн талаарх сэтгэгдэл, гэрийн даалгаврын биелэлтийн байдлын талаар оролцогч бүр ярилцах;

1.4.2. сэдвийн хүрээнд дасгал хийх;

1.4.3. сэдвийн хүрээнд мэдээлэл өгөх;

1.4.4. гэрийн даалгавар хийх талаар зөвлөмж, ярилцлага, дадлага хийх.

**Хоёр. Албадан сургалтын хичээлийн сэдвийн хүрээ**

2.1. Албадан сургалтын хичээлийг дараахь сэдвийн хүрээнд зохион байгуулна:

**Хичээл 1**

- Гэр бүлийн хүчирхийллийн тухай тодорхойлолт, илрэх хэлбэр;
- Эсэргүүцэл ба эргэцүүлэл;
- Уураа хянах.

**Хичээл 2**

- Гэр бүлийн хүчирхийллийн давтамж, даамжирал;
- Хүчирхийлэл ба хүндэтгэл бүхий харилцааны шинж тэмдэг.

**Хичээл 3**

- Хүчирхийлэл үйлдэх учир шалтгаан, үр дагавар;
- Хүчирхийллийн бус харилцааны үр чадвар.

**Хичээл 4**

- Уур ба үйлдэл;
- Уураа хянах ба зан үйлийн өөрчлөлт.

**Хичээл 5**

*/4 дүгээр хичээлийн үргэлжлэл/*

- Хүчирхийллийн үр дагавар эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдэд нөлөөлөх нь;
- Хүчирхийллийн зан үйлийн үе дамжсан давтамж.

**Хичээл 6**

- Хүчирхийллийн зан үйлээ хянах –эерэг зан үйлээ хөгжүүлэх;
- Харилцааны үр чадвар.

**Хичээл 7**

- Өмнөх хичээлүүдийн үр нөлөөг үнэлэх;
- Зан үйлээ хянах хариуцлага.

**Хичээл 8**

*2 дугаар хичээлийн давталт*

- Хүчирхийлэл бол гэмт хэрэг;
- Хүчирхийлэл ба хүндэтгэл бүхий харилцаан дахь өөрчлөлт;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж, хүний эрх, жендэрийн асуудал.

**Хичээл 9**

- Зан үйлээ өөрчлөх үүрэг хариуцлагадаа үнэнч байх;
- Мэдрэмж, сэтгэл хөдлөлийн тухай ойлголт.

**Хичээл 10**

- Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байрын талаарх уламжлалт хандлага;
- Гэр бүлийн харилцааны бүтцийн тухай ойлголт.

**Хичээл 11**

- Эцгийн эрхт ёсны түүх, түүний үр дагавар өнөө үед.

**Хичээл 12**

- Эсэргүүцэл ба Эргэцүүлэл /давталт/;
- Зан үйлээ өөрчлөхийн зэрэг үр нөлөө.

**Хичээл 13**

- Сэтгэл хөдлөл ба мэдрэмжээ зөв илэрхийлэх;
- Өөрийгөө болон бусдыг ойлгох харилцааны үр чадвар.

**Хичээл 14**

- Өмнөх хичээлүүдийн давтлага – ярилцлага;
- Өмнөх хичээлүүдийн оролцооны үр дүнгийн үнэлгээ хийх ярилцлага.

**Хичээл 15**

- Зан үйлээ хянах-харилцааны үр чадварт гарч буй өөрчлөлт;
- Хүчирхийллийг дахин үйлдлэхээс сэргийлэх арга замууд.

**Хичээл 16 -17**

- Хүчирхийллийн талаарх хүүхдийн ойлголт;
- Бодол эргэцүүлэл.

**Хичээл 18**

- Дахилтаас урьдчилан сэргийлэх – зан үйлээ хянах арга техник.

**Хичээл 19**

- Зан үйлээ хянах өөртөө итгэлтэй байдал – эргэн дүгнэх.

**Хичээл 20**

- Дүгнэлт хичээл;
- “Бид хүчирхийлэлгүй амьдарч чадна” ярилцлага.

Хавсрамт 7

**Хамтарсан багийн бусад шаардлагатай  
баримт бичгийн загварууд**

**ҮЙЛ ЯВЦЫН ТЭМДЭГЛЭЛ**

Үйлчлүүлэгчийн код: .....

Огноо: .....

Уулзалт хийсэн газар: .....

Уулзалтын тоо: .....

Уулзалт хийсэн нийгмийн ажлантай: .....

Нийгмийн ажилтны асуулт	Тэмдэглэл/Үйлчлүүлэгч	Өөрт төрсөн мэдэрэмж	Үйлчлүүлэгчийн гэдлэл байдал

**КЕЙС ТӨЛОВЛӨГӨӨ**

Үйлчлүүлэгчийн код: .....

Нийгмийн ажилтны нэр: .....

Он, сар, өдөр: .....

оригло	Үзүүлэх үйлчилгээ	Үйлчилгээ үзүүлэх байгууллага болон холбогдох хүмүүсийн нэр, утас, хаяг	Үйлчилгээ эхлэх болон төгсгөх өдөр	Тэмдэглэл	Линч үзлийн

### **Үйлчлүүлэгчийн амьдардаг орчны эко зураглал**

Энэ арга нь гэр бүл болон гэр бүлүүдийн гишүүдийн бусад орчинтойгоо харьцах харилцааны дүр төрх, гэр бүл ба орчны харилцааны мөн чанар, нөвцийг дэлгэн дүрслэн үзүүлдэг арга хэрэгсэл юм.



### **Үйлчлүүлэгчийн гэр бүлийн генограммын зураглал**

Энэхүү арга нь гэр бүлийг нэгэн систем болохын хувьд гэр бүлийн харилцааг ойлгоход туслах зорилготой гэр бүлийн гарал үүсэл, бүтцийн тухай мэдээллийг гэр бүлийн үе үеэр нь харуулдаг. Энэ хэрэгсэл нь өөрийн гэсэн үндсэн тэмдэглэгээнүүдийг ашиглаж, үйлчлүүлэгчийн гэр бүлийн түүх, өмнөд байдалд үзэлгээ хийдэг.



**Байгууллагад холбон зуучлах хуудас**

**А. ҮЙЛЧЛЭЭ ХУУДАС**

1. Үйлчилгээ үзүүлэх байгууллага.....
2. Кейсийг дугаар.....
3. Үйлчилгээнд холбон зуучлагч байгууллага.....
4. Үйлчилгээнд холбон зуучилсан он сар өдөр.....
5. Тантай байгууллагаас хүсэж буй үйлчилгээний агуулга.....
6. Үйлчилгээнд холбон зуучилж байгаа шалтгаан (давуу талууд болон хүндрэл бэрхшээлүүд).....

**Үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл:**

7. Үйлчлүүлэгчийн овог, нэр.....
8. Иргэний үнэмлэх болон Регистрийн дугаар.....
9. Хааг, утас.....
10. Түүнд туслалх-Гэр бүлийн болон холбогдох хүмүүсийн нэр хааг утасны дугаар.....

**Үйлчилгээ үзүүлж байгаа бусад байгууллага:**

Нэр.....

Хааг.....

Утас.....

Ямар үйлчилгээ үзүүлж байгаа.....

**Үйлчилгээ үзүүлж байгаа бусад байгууллага:**

Нэр.....

Хааг.....

Утас.....

Ямар үйлчилгээ үзүүлж байгаа.....

Холбон зуучилсан ажилтаны нэр, гарын үсэг.....

Хүлээн авсан ажилтаны нэр гарын үсэг.....

**Буцах хуудас**

1. Холбон зуучлагч байгууллагын зүгээс үзүүлсэн үйлчилгээний тухай мэдээлэл.....
2. Өнөөгийн нохиол байдал.....
3. Цаашид үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд, хэрхэн хамтран ажиллах ба мэдээлэл солилцох вэ?  
Үйлчилгээнд холбон зуучлах байгууллага кейсийг хлааж байгаа юу?  
\_\_\_\_\_тийм \_\_\_\_\_үгүй
4. Бусад зөвлөмж/тайлбар.....

Үйлчилгээ үзүүлдэг гэмдэгчл хөтөлсөн ажилтаны нэр, албан тушаал:

\_\_\_\_\_/гарын үсэг/

Хуудасыг буцаасан он, сар, өдөр \_\_\_\_\_

## КЕЙСИЙГ ХААХ МАЯГТ

Кейсийн код:.....

Он, сар, өдөр:.....

Овог нэр:.....

Нас:.....

Төрсөн он, сар, өдөр:.....

Бичиг баримтын дугаар:

1. Терсний гэрчилгээний дугаар: .....
2. Регистрийн дугаар: .....
3. Эрүүл мэндийн даатгалын дэвтэр:.....

Кейс төлөвлөгөө хэрэгжсэн байдал:

Кейс менежрийн нэр: .....

Д/д	Үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хийгдсэн ажлууд	Хугацаа	Гарсан үр дүн	Үйлчлүүлэгчийн гарын үсэг	Биелэлт, тайлбар

Кейс хаах болсон шалтгаан:.....

Аюулгүй байдлын үнэлгээ:.....

Кейс хаах талаарх үйлчлүүлэгчийн сэтгэгдэл:.....

Нийгэмийн ажиглагчийн нэр, гарын үсэг:.....

Үйлчлүүлэгчийн гарын үсэг:.....

## Хамтарсан багийн судалгааны загварууд

### 1. Архаг архичинтай гэр бүлийн судалгаа

Д/д	Өрхийн тэргүүний нэр	Ам бүсийн байдал	Архи уудаг гишүүний нэр, ямар ажил эрхэлдэг болох	Гэрийн хаяг (албан ёсны бүртгэлтэй эсэх)	Архидалтаас үүссэн үр дагавар

### 2. Хорих суллагдсан болон хорихоос өөр төрлийн ял эдлэж байгаа иргэдийн судалгаа

Д/д	Овог нэр	Ам бүсийн байдал	Ямар ял эрхэлдэг болох	Хэргийн анг	Гэрийн хаяг (албан ёсны бүртгэлтэй эсэх)	Тайлбар

### 3. Ойр орчиндөө талаарх тэргүүнээр айл өрхийн судалгаа

Д/д	Өрхийн тэргүүлэгчийн нэр	Ам бүсийн байдал	Ямар (албан ёсны бүртгэлтэй эсэх)	Тайлбар (түгшүүр төрүүлэгчийн талаарх мэдээлэл)



**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2016 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Гэрээний загвар, аргачлал, хувийн хэргийн  
маягтын загвар батлах тухай

"Нийгмийн халамжийн тухай" хуулийн 8.3, 8.4 дугаар зүйл, МУЗГ-ын 2008 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээ үзүүлэх журам"-ын 2.8, 2.9 дахь заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор тушаах нь.

1. "Аймаг дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагаас халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээ"-ний загварыг 1 дүгээр хэвсрэлтээр, "Үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийн тоо, хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлалыг 2 дугаар хэвсрэлтээр, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний хувийн хэргийн маягтын загварыг 3 дугаар хэвсрэлтээр тус тус баталсугай.
2. Батлагдсан загвар, маягыг олшруулан үйл ажиллагаандаа хэрэглэх ажлыг зохион байгуулахыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга нарт зөвшөөрсүгэй.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Дэд даргын үүргийг орон нийцэтгэгч Д.К. Эрдэнэбаатар, Хяналт, шалжилгээ үнэлгээний хэлтсийн дарга И.Ганбат, Санхүүгийн хэлтсийн дарга И.Н. Жангараг нарт үүрэг болгосугай.



ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

## Хавсралт 8

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
газрын даргын 2010 оны .....дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

### Гэрээгээр гүйцэтгэх үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийн тоо, хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал

"Нийгмийн халамжийн тухай хууль"-ийн 8.3-д иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нийгмийн халамж, асрамжийн үйл ажиллагаа эрхэлж болохыг заасан. Гэрээгээр гүйцэтгэх хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх туршлагатай байна.

"Нийгмийн халамжийн тухай" хуулийн 26.1-т заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэн, ААН, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэхэд хамрагдах өрх, иргэдийн тоо, зарцуулах хөрөнгийн хэмжээг тодорхойлоход энэхүү аргачлалыг ашиглана. Үүнд:

#### **1. Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх үйлчилгээ**

Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх үйлчилгээг иргэн, ААН, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлнэ.

Сургалт нь өрхийн амьжиргааг дэмжих, төсөл бичих, бүлгийн зохион байгуулалтанд орж хөдөлмөрөөр хоршин ажиллах чадвар, асарч сувилах үйлчилгээний ур чадвар олгох гэсэн чиглэлээр байна.

Сургагч багшийн ажлын хөлсийг өдрийн 8000₮ тооцно.

**Нэг суралцагчийн сургалтын зардлын дээд хэмжээ:**

**/ажлын 5 өдрөөр/**

№	Зардлын нэр	14 хоног	7 хоног
1	Бичиг хэргийн зардал	1500	1500
2	Тараах материал, гарын авлага	2000	1000
3	Цайны зардал	4000	2000
4	Хоол, унааны мөнгө /1500/	15000	7500
5	Дадлагын материал	5000	2500
Бүгд		27500	14500

Сургалтын нэр төрлөөс шалтгаалж дадлагын материал болон бусад зардал шаардагдахгүй тохиолдолд нийт зардлаас хасаж тооцно.

**2. Зохион байгуулалттай бүлэгт төсөл хэрэгжүүлэх**

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2 ба түүнээс дээш өрх, иргэд өөрсдийн санаачлагаар нэгдэн бүлэг болж орлогоо нэмэгдүүлэх зорилгоор төсөл боловсруулан хэрэгжүүлэх нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөлд хамрагдана. Зохион байгуулалттай бүлэгт нийгмийн халамжийн тухай хуулийн 26.2-д заасан өрх, иргэдийг хамруулна.

Иргэдийн ирүүлсэн төслийг амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. АДЗ-өөр дэмжигдсэн төслийг ХХҮХ хянаж үзээд хэрэгжих магадлалтай бол 1,0 сая хүртэлх төгрөгөөр санхүүжүүлнэ.

**3. Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ**

Иргэн, ААН, ТББ халамжийн үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулан гэрийн асрамжийн үйлчилгээг гүйцэтгэж болно. Энэ үйлчилгээнд Нийгмийн халамжийн тухай хуулийн 25.2.2-д заасан амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж, түүнийг асарч буй иргэнд 19.1-д заасан нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг авдаг иргэдийг давхар хамруулахгүй.

Гэрийн асрамж халамжийн үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлэхэд олгох санхүүжилтийг тооцоходоо доорх үнийн тарифыг баримтлан, зөвхөн гэрээнд зааж гүйцэтгэсэн

үйлчилгээний зардлыг санхүүжүүлнэ.

**Гэрийн асрамж халамжийн үйлчилгээний 1 үйлчлүүлэгчийн зардлын дээд хэмжээ:**

№	Үзүүлэх үйлчилгээний нэр төрөл	Хөдөө		Хот	
		7 хоногт	1 сард	7 хоногт	1 сард
1	Хэвтрийн өвчтөнийг эргүүлэн сэлгүүлж хэвтүүлэх, өргөж тээх, эмчид үзүүлэх	400	1600	500	2000
2	Усанд оруулах, хар цайнд оруулах	1150	4600	1250	5000
3	Хөл гарын хумс авах, угаах	200	800	300	1200
4	Ор дэр засах	100	400	200	800
5	Хувцас, цагаан хэрэглэл солих угаах, индүүдэх	1150	4600	1250	5000
6	Гэр цэвэрлэх /ариутгалын бодисоор цэвэрлэгээ хийх, гал түлэх, аяга таваг угаах, тоос арчих, шал угаах г.м/	1400	5600	1500	6000
7	Хоол цай хийх, хооллох	2400	9600	2500	10000
8	Халуун хүйтэн жин тавих	500	2000	600	2400
9	Цонх, хаалга угаах, дулаалах	900	3600	1000	4000
10	Хүнсний бүтээгдэхүүн цуглуулах	1400	5600	1500	6000
11	Бие засуулах, өтгөн шингэн цэвэрлэх	1400	5600	1500	6000
<b>Бүгд</b>		<b>11000</b>	<b>44000</b>	<b>12100</b>	<b>48400</b>

#### **4. Түр байрлуулан асрамжлах үйлчилгээ**

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийлэлд өртөж болзошгүй хохирогч, түүний бага насны хүүхдийг түр хугацаанд байрлуулж асрамжлах үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.

Асрамжлах байрны хүчин чадлаас хамаарч иргэдийг түр байрлуулан үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гарсан зардлыг

үйлчлүүлэгчийн байнга оршин суугаа харъяаллын дагуу аймаг, дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага санхүүжүүлнэ.

Түр байрлуулан асрамжлах үйлчилгээнд олгох санхүүжилтийг тооцохдоо доорх үнийн тарифыг баримтлана.

**Түр байрлуулан асрамжлах үйлчилгээний 1 үйлчлүүлэгчийн 1 хоногийн зардлын дээд хэмжээ:**

№	Зардлын нэр	Үнийн дүн
1	Байр	1800
2	Хоол, цай	2000
3	Ариун цэвэр	500
4	Эрүүл мэндийн үйлчилгээ	500
5	Нийгмийн ажлын үйлчилгээ	600
6	Цалин /ажилтан/	1000
7	Шимтгэл	100
8	Бусад	2500
<b>Бүгд</b>		<b>9000</b>

Хууль, хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж аль болох богино хугацаанд үйлчлүүлэгчийг гэрт нь буцаах боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

## **5. Сэргээн засах үйлчилгээ**

Сэргээн засах үйлчилгээг иргэн, ААН, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж болно. Сэргээн засах үйлчилгээг үзүүлэхэд олгох санхүүжилтийг тооцохдоо доорх үнийн тарифыг баримтлан зөвхөн гэрээнд зааж гүйцэтгэсэн үйлчилгээний зардлыг санхүүжүүлнэ.

**Сэргээн засах үйлчилгээний 1 үйлчлүүлэгчийн зардлын дээд хэмжээ:**

№	Үзүүлэх үйлчилгээний нэр төрөл	Хөдөө		Хот	
		7 хоногт	1 сард	7 хоногт	1 сард
1	Эмчийн үзлэг /судас барих, пульс тоолох, тогшилт тэмтрэлт, шинжилгээний аргууд/	1150	4600	1250	5000
2	Сэтгэл засах эмчилгээ, урьдчилан сэргийлэх зөвөлгөө өгөх	650	2600	750	3000
3	Биеийн халуун хэмжих	100	400	200	800
4	Цусны даралт үзэх	400	1600	500	2000
5	Бүх биеийн бариа засал /толгой хүзүү бусад бие эрхтэн/	2400	9600	2500	10000
6	Бумба тавих, наамал гич хэрэглэх	1400	5600	1500	6000
7	Зөгийн балтай татлага	700	2800	800	3200
8	Утлага хийх /содтой болон бусад/	200	800	300	1200
9	Катетър авах, тавих	1400	5600	1500	6000
10	Соронзон зүү тавих	700	2800	800	3200
11	Шивүүр	400	1600	500	2000
12	Төөнүүр хийх	400	1600	500	2000
13	Бохир шарх цэвэрлэх ариун боолт хийх	1150	4600	1250	5000
14	Эмчилгээний дасгал заах	900	3600	1000	4000
15	Хануур	300	1200	400	1600
<b>Бүгд</b>		<b>12250</b>	<b>49000</b>	<b>13750</b>	<b>55000</b>

Сэргээн засах үйлчилгээнд иргэнийг аль болох богино хугацаанд хамруулж гэр бүлийн гишүүд болон иргэн өөрөө үйлчилгээг бие даан хийж чаддаг болгоход анхаарч ажиллана.

## 6. Өдрийн үйлчилгээ

Өөртөө үйлчлэх чадвартай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг идэвхжүүлэх өдрийн үйлчилгээг иргэн, ААН, ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

Чийрэгжүүлэх, эрүүл урт наслах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх чөлөөт цаг өнгөрүүлэх үйлчилгээнд 1 хүнд 1 өдөрт олгох санхүүжилтийн дээд хэмжээ 3000 төгрөг байна.

НХХ-ийн сайдын 2009 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Жишиг үнэ тогтоох тухай" 61 дүгээр тушаалд заасны дагуу иргэн өөрөө өдрийн 2000 төгрөг төлнө.

### Өдрийн үйлчилгээний зардлын дээд хэмжээ:

№	Зардлын нэр	Үнийн дүн
1	Хоол унаа	2000
2	Өдрийн цай /өдөрт 2 удаа/	400
3	Үзүүлсэн үйлчилгээний зардал	2600
Бүгд		5000

Үзүүлсэн үйлчилгээний зардал гэдэгт доорх үйлчилгээнд зарцуулах зардлыг тооцно.

- Урлаг соёлын арга хэмжээ-Дуу хөгжим сонгож алжаал тайлах өөрсдөө дуулж хөгжимдөх
- Эрүүл мэндийн үзлэг хийх-Эмнэлгийн анхан шатны болон уламжлалт эмчилгээ хийх- бие эрхтэний хөшүүн байдлыг арилгах, сэргээн засах дасгал хөдөлгөөн, бясалгал хийх
- Чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх төрөл бүрийн оюуныг хөгжүүлэх тоглоом /шатар, даам г.м/
- Мэдээллээр хангах, өдөр тутмын сонин сонин, сэтгүүл, радио, телевиз үзүүлэх
- Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын хууль тогтоомжийг таниулах самбар ажиллуулах, зөвөлгөө өгөх
- Төвийнхөө үйл ажиллагааг сурталчлах, тэднээр сурталчлуулах гэх мэт байна.

Өдрийн үйлчилгээнд 1 хүнийг 7 хоног хамруулж дараагийн хүнийг хүлээн авах журмаар аль болох олон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг хамруулах зорилготой ажиллана.

## Ашигласан номын жагсаалт

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Монгол улсын хууль 2004 он
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөр 2007 он
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай НХХЯ, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаал 2009 оны 09 сарын 21-ний өдрийн дугаар 128/188
- "Нийгмийн ажилтны талаар авах зарим арга хэмжээний тухай" Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаал
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги ХЭҮТ, АНУ-ын Азийн сан 2005 он
- Гэр бүл дэх хүүхдийн хамгаалал, хамтарсан багийн оролцоо. ХЭҮТ, ХИС / Их Британи / зөвлөлдөх уулзалтад оролцогчдын тайлангийн эмхэтгэл 2005 он
- Хамтарсан баг НХХЯ, ХЭҮТ. 2006 он
- Хамтарсан багийн үнэлгээний багийнхны тайлан ХЭҮТ, ИБХИС 2005 он
- Хороо, сум, багийн түвшинд хүүхэд хамгааллын үйлчилгээг олон нийтэд түшиглэн хамтарсан багаар үзүүлэх нь. С.Энхтуяа, Д.Олончимэг. УБ 2009 он.
- Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь А.Батхишиг 2008 он
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ А.Батхишиг, О.Мягмар, М.Нямдорж.. УБ 2009 он.
- ХЭҮТ-ийн стратеги төлөвлөлтийн баримт бичиг 2005 - 2008 он
- Хүүхэд хамгааллын нэгжийн төслийн үнэлгээ Гучаран Вирдее 2003
- ХИС / Их Британи/-ийн Хүүхэд хамгаалах бодлого

